



ЖИЛИЙН ТАЙЛАН
2019

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	4
АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ	7
Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх нь	8
Сонгуулийн үйл явц, улс төрийн санхүүжилтийг боловсронгуй болгох нь	16
Төсвийн хариуцлагыг сайжруулах	24
Эрдэс баялгийн салбарын сайн засаглалыг дэмжих	38
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ	51
Хүний эрх	52
Эрүүгийн эрх зүйн шинэчлэл	62
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	70
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь	76
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО	83
Тэгш хамруулах боловсрол	84
Залуучуудын дундах хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх нь	90
САНХҮҮГИЙН ТАЙЛАН	93

ТОВЧИЛСОН ҮГ

АСДҮОУХ	Ардчилал, Сонгуульд Дэмжлэг Үзүүлэх Олон Улсын Хүрээлэн
АТГ	Авлигатай тэмцэх газар
АШУҮИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БХАН	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЛЭОС	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан
МУБИС	Монгол Улсын Багшийн Их Сургууль
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НЭМС	Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СХС	Сум хөгжүүлэх сан
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХЭЭХ	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний комисс
ХЭФ	Хүний эрхий форум
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭЗНСЭОУС	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын сүлжээ

ӨМНӨХ ҮГ

Манай улсад ардчилсан, хариуцлагатай засаглалыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий нэмэлт өөрчлөлтүүд Үндсэн хуульд орсон нь 2019 оны гол үйл явдал боллоо. Энэхүү нэмэлт өөрчлөлтөд Нээлттэй Нийгэм Форумын зүгээс сүүлийн 10 гаруй жил анхаарч ажиллаж ирсэн асуудлууд тусгалаа олсон нь бидний цаашдын ажил үйлсэд ихээхэн урам нэмлээ. Төрийн хариуцлагыг дээшлүүлэх, шүүхийн хараат бус байдлыг нэмэгдүүлэх, улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох, сонгуулийг шударга болгох, төсвийн сахилгыг сайжруулах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нийтийн эрх ашгийг хамгаалахад Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт чухал үүрэг гүйцэтгэх нь эргэлзээгүй.

Бид үйл ажиллагаагаа жил бүр нэгтгэн тайлагнадаг уламжлал ёсоор 2019 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа уншигч олондоо үүгээр тоймлон танилцуулж байна.

Төрийн ил тод, хариуцлагатай байдал, иргэдийн оролцоог дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд 2019 онд үргэлжлүүлэн анхаарч зүүн бүсийн аймгуудын иргэний нийгмийн идэвхтэн 140 гаруй хүнд нийтийн болон захиргааны сонголт зохион байгуулах, нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах зэрэг асуудлаар сургалт зохион байгуулж, эдгээр асуудлаар орон нутагтаа түүштай ажиллах эрмэлзэлтэй 11 төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлээ. Энэ хүрээнд иргэдийн үр нөлөөтэй оролцооны шинэ хэлбэр болсон нийтийн сонголыг 5 аймагт төсвийн хяналт, орон нутгийн хөрөнгө оруулалт зэрэг асуудлаар зохион байгуулжээ.

2019 онд Улсын бүртгэлийн багц хуулийн хүрээнд ил болсон хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлэг, тендер, уул уурхайн лицензийн мэдээлэлтэй холбосноор иргэд хайлт хийн шууд үзэх боломжтой www.opendatalab.mn мэдээллийн сан мөн нээгдлээ. Төрөөс нэгэнт ил болгосон мэдээллийг үр дүнтэй ашиглан шийдвэр гаргах процесст иргэдийн оролцоог идэвхжүүлэхэд дээрх мэдээллийн сан тус дөхөм болно гэж найдаж байна.

УИХ-ын ээлжит сонгуулийн жил угтаж намын санхүүжилтийг ил тод болгохоос эхлээд холбогдох төрийн байгууллагын хяналтын арга механизмыг боловсронгуй болгох, үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, сонгуулийн явцад мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зэрэгт дэс дараатай анхаарч ажиллалаа. 2012 оноос мониторинг хийж байгаа “Шударга сонгуулийн төлөө” иргэний нийгмийн сүлжээнээс өгсөн нийт 28 зөвлөмжөөс 25 нь Сонгуулийн хуульд шинээр туссан байна. Үүнд нам, нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдээллийг сонгуулийн өдрөөс өмнө ил болгох, зардлын тайланд тавих шаардлага болон тайланг хянахтай холбоотой Төрийн аудитын эрх үүрэг, оролцоог тодорхой болгоход чиглэсэн саналууд багтсан юм.

Сүүлийн жилүүдэд ННФ төсвийн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн төсвийн хүрээний судалгаа шинжилгээ, мониторингийг төрийн бус байгууллагууд, судлаачидтай хамтран хийж гүйцэтгэж байна. 2019 оны хувьд хөрөнгө оруулалтын төсөвт илүү анхаарал тавьж төрийн аудитын байгууллагатай анх удаа иргэний нийгмийн байгууллагууд хамтарч ажиллав. Энэ хүрээнд Үндэсний аудитын газартай хамтран дуусаагүй

барилга, байгууламжийн санхүүжилт, тархалтыг харуулсан багц инфографик боловсруулж бодлого боловсруулагчид, олон нийтэд хүргэв. Мөн орон нутагт шилэн дансны мэдээлэлд иргэний нийгмийнхний хийдэг мониторинг ч үргэлжилж, олон улсын төсвийн түншлэлийн хүрээнд гаргадаг Монгол Улсын “Төсвийн нээлттэй байдал”-ын ээлжит үнэлгээ хийгдлээ.

Үндсэн хуульд туссан зарчмын шинжтэй шинэчлэлийг дагаад эрдэс баялгийн салбарын хуулиудад зохих өөрчлөлтүүд орно. Үүний нэг нь бидний 10 гаруй жил ажиллаж ирсэн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хэрэгжилтийг хуульчлах ажил юм. Уг хуулиар эрдэс баялгийн салбарын эцсийн өмчлөгчийн мэдээлэл, бүх төрлийн гэрээ, компани, төрийн байгууллагуудын тайлан ил тод болох суурь зарчим тавигдана. Эрдэс баялгийн гэрээнүүдийг ил болгох зорилгоор эхлүүлсэн www.iltodgeree.mn мэдээллийн санд одоогоор 14 төрлийн 770 орчим гэрээ тавигджээ. ННФ 2019 онд энэхүү гэрээний ил тод байдлыг тойрсон асуудлаар олон улсын хэмжээний хэлэлцүүлэг, сургалт семинар зохион байгуулж талуудын оролцоог нэмэгдүүллээ. Түүнчлэн, Авлигатай тэмцэх газартай хамтран ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх бүхий хуулийн этгээдийн бүртгэлийг шинжилж үзэхэд эцсийн өмчлөгчдийн 63 хувь нь мэдээллээ огт оруулаагүй байгаа нь харагдлаа. Тиймээс, хуулийн этгээдийн бүртгэлийн газартай хамтран эцсийн өмчлөгчийн бүртгэлийн маягтыг шинэчлэн батлууллаа.

ННФ байгалийн баялгийн зохистой удирдлагыг хангахад чухал үүрэгтэй төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, Топ-20 ангиллын хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулалтад үнэлгээ хийв. Үүнд, Эрдэнэс Тавантолгой, Багануур, Шивээ овоо, Шарын гол, Тавантолгой зэрэг төрийн болон орон нутгийн өмчит уул уурхайн компаниудыг мөн нэмж хамрууллаа.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2019 онд бодлогын нөлөөллийн олон үйл ажиллагаа явуулж, бие даасан судалгаа, мониторингийн үр дүнг бодлого боловсруулагчдад хүргэж, эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, болзошгүй үхралтаас сэргийлэхэд гол анхаарлаа хандуулж ажиллалаа. 2019 онд хууль сахиулах байгууллагад техникийн туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ шинэ эрх зүйн орчинд ажиллах хуульчид, хууль сахиулагчдын эрх зүйн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлууд хийгдлээ. Түүнчлэн, эрх зүйн шинэчлэлийн явцад тулгарч буй маргаантай асуудлаар эсрэг тэсрэг үзэл бодлуудыг уралдуулах “Үзэл бодол” хэлэлцүүлэг шинээр эхлүүлсэн нь судлаач мэргэжилтнүүдэд тухайн асуудалтай гүнзгий танилцах боломж олголоо.

ННФ-ын бүхий л хөтөлбөрийн үйл ажиллагаанд хүний эрхийг дээдлэх, хамгаалах, эрхийн тухай мэдлэг мэдээлэл түгээх, сурталчлан таниулах ажил багтдаг билээ. 2019 онд бид “Хүний эрхийн форум”-тай хамтран НҮБ-д Хүний эрхийн төлөв байдлын ээлжит тайлангаа илгээв. Уг тайланг бэлтгэхэд 21 аймаг, нийслэлд олон удаагийн цуврал хэлэлцүүлэг өрнүүлж байж дүгнэлт гаргав. Мөн хүний эрхийн сэдвээр Өглөөний үулзалт, кино хэлэлцүүлэг, телевизийн нэвтрүүлэг, хүний эрхийн тухай лекц давтамжтайгаар, тогтмол зохион байгуулагдлаа.

Нээлттэй Нийгэм Сангуудын олон улсын санаачилга, санхүүжилтээр 2016 онд эхлүүлсэн “Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх” төсөл амжилттай хэрэгжиж дууслаа. Энэ хүрээнд ННФ хоёр аймагт эрх зүйн хөтчийн булан ажиллуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэв. Хууль зүйн Үндэсний хүрээлэнтэй хамтран Эрх зүйн хөтөч бэлтгэх арга зүй боловсруулж, нийт 118 эрх зүйн хөтөч сургаж бэлтгэн Хэнтий, Сэлэнгэ аймгуудад тэд ажиллаж эхэллээ. 2020 онд үлдсэн аймгуудад эрх зүйн хөтөч нарыг сургаж ажиллуулснаар үндэсний хэмжээнд Эрх зүйн хөтчийн тогтолцоо бүхэлдээ ажиллаж эхлэх болно.

Боловсрол, нийгмийн бодлогын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах бодлого хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ННФ нь иргэний нийгэм, боловсролын байгууллагуудтай хамтран бодлогын хэрэгжилтийг дэмжихийн зэрэгцээ түүнд ажиглалт хяналт тавихад төвлөрч ажиллав. Хот, хөдөөгийн иргэний нийгмийн байгууллагууд хамтран мэдлэг мэдээлэл өгөх хэвлэмэл бүтээгдэхүүн, гарын авлага гарган мониторинг, мэдээллийн аян хийж, монгол брайль үсгийн стандарт боловсруулав. МУБИС, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ)-тэй хамтран тэгш хамруулах боловсролыг тууштай хэрэгжүүлэх хүний нөөц, мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих төслүүд эхлүүлээ.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чиглэлд 2019 онд ННФ-ын түнш байгууллага, үйл ажиллагааны төрөл, хэлбэр нэмэгдэв. Сурагчдад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх ТББ-ын төсөл, 4 их сургуулийн хөтөлбөр шинэчлэлийн ажил амжилттай үргэлжилж байгаа бол уран бүтээлч залуустай ажиллаж комикс бүтээхэд оролцон, мэдээллийн салбарын залуу идэвхтнүүдэд үзүүлсэн дэмжлэгийн үр дүнд хуурамч мэдээ, үзэн ядах үг хэллэг, суртал үхүүлга зэрэг чухал сэдвүүдийг багтаасан мэдээллийн боловсролын хөтөлбөр бэлэн болов.

Төгсгөлд нь, өнгөрсөн хугацаанд бидэнтэй хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллагууд, судлаачид, мэргэжилтнүүд, мөн манай үйл ажиллагаанд оролцож мэдлэг, туршлага, үзэл бодлоо хуваалцдаг хүмүүст гүн талархал илэрхийлж байна. Мөн хөтөлбөр тус бүрийн хүрээнд хийгдсэн ажлыг тухайн сэдвээс нь дэлгэрүүлж харахыг хүсье.

Бидний үйл ажиллагаа болон тайлантай холбоотой асуулт, санал байх аваас манай байгууллагын osf@forum.mn хаягаар бидэнд ирүүлээрэй.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



АРДЧИЛСАН САЙН
ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ



ТӨРИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

2019 онд Монгол Улсын ардчиллын түүхэнд үлдэх чухал үйл явдал тохиосон нь УИХ-аас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан явдал байв. Уг нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 28.5 хувь буюу 19 зүйл, 35 заалтыг хөндсөн бөгөөд үүнд засаглалын хяналт-тэнцлийг хангаж, гүйцэтгэх засаглалын тогтвортой байдал, парламентын хариуцлагыг нэмэгдүүлэхтэй холбоотой хэд хэдэн чухал зохицуулалт багтсан билээ. Эдгээрээс онцолбол, УИХ-аас нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах түр хороо цөөнхийн төлөөллийг оролцуулан байгуулж болох тухай заажээ. Түүнчлэн Үндсэн хууль зөрчсөн нь нотлогдсон тохиолдолд УИХ-ын гишүүнийг эгүүлэн татах тухай тусгасан байна.


Парламентын хариуцлага, хяналтыг боловсронгуй болгоход чиглэсэн дээрх заалтуудаас гадна Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэхтэй холбоотой “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэсэн нэмэлт мөн тусгалаа олжээ. Иргэдийн мэдэх эрхийг хангахтай холбоотой “иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэсэн заалт нэмэгдэн орсныг мөн онцлох нь зүйтэй. Ардчилсан сайн засаглалыг бэхжүүлэхэд чухал ач холбогдол бүхий Үндсэн хуулийн эдгээр

нэмэлт, өөрчлөлтийг цаашид холбогдох хууль тогтоомжид дэлгэрүүлэн тусгаж, хэрэгжилтэд хяналт тавихад ННФ-ын зүгээс иргэний нийгмийн байгууллагууд болон судлаачидтай хамтран ажиллахаар төлөвлөж байна.

2019 оны хувьд мэдээллийн ил тод байдлыг сайжруулах хүрээнд гарсан бас нэг гол ахиц дэвшил нь Улсын бүртгэлийн багц хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой 200,000 шахам хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг ил болгосон явдал байв. Олон нийтэд хүрэх нээлттэй өгөгдөл ийнхүү нэмэгдсэнээр Авлигатай тэмцэх газар (АТГ)-ын хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийн сан, төрийн тендерт оролцогч хуулийн этгээдүүдийн (www.tender.mn) зэрэг бусад мэдээлэлтэй харьцуулан хяналт тавих боломж нэмэгдсэн. ННФ-ын зүгээс нээлттэй өгөгдлийн ашиглалтыг хялбар болгох зорилгоор “Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв” ТББ-тай хамтран www.opendatalab.mn мэдээллийн сан бий болгож уг санд одоогийн байдлаар байгууллага, хувь хүн, тендер, уул уурхайн лицензийн мэдээлэл, албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг

нэгтгэж оруулаад байна. Өдөр бүр хайлт хийж идэвхтэй ашиглаж буй 100-300 орчим хэрэглэгч байгаа ба өдрийн хандалтын тоо 1000-аас 5000 орчим байна. Үүний дотор уг мэдээллийн санг сэтгүүлчид идэвхтэй хэрэглэж байгаа нь сайшаалтай.

Иргэдэд хүрч буй нээлттэй мэдээллийн цар хүрээ ийнхүү нэмэгдэж байгаа ч 2016 оны 12 дугаар сард батлагдан 2017 оны 9 дүгээр сараас хэрэгжиж эхлээд байгаа “Төрийн болон албаны нууцын тухай хууль” –ийн хүрээнд төрийн нууцын жагсаалтыг УИХ-аас хууль гарган баталдаг байсныг өөрчилж Засгийн газар батлах болсноор нууцад хамаарах мэдээллийн тоо эрс өссөн нь анхаарал татаж байна. 2019 онд Глоб Интернэшнл ТББ-ын хийсэн судалгаанд дурдсанаар төрийн нууцад хамаарах мэдээлэл 2004-2017 онд 60 байсан бол дээрх хууль хэрэгжиж эхэлснээр 565 болж 9.5 дахин нэмэгджээ. Цаашид иргэдийн мэдээлэл авах эрхийг хамгаалах хүрээнд энэхүү асуудалд зайлшгүй анхаарал хандуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.



www.opendatalab.mn сайтад одоогийн байдлаар 208 923 байгууллага, 546 547 хувь хүн, 20 315 тендер, 73 189 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг, 3 356 уул уурхайн лицензийн мэдээл оруулаад байна.



www.opendatalab.mn мэдээллийн сан нээх үеэр "Хоёр хотын цадиг" үзэсгэлэнг зохион байгуулав.

ННФ-аас 2019 онд Глоб Интернэшнл ТББ-д дэмжлэг үзүүлэн иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалах, нийгмийн сүлжээний зохистой хэрэглээ, зохицуулалтыг дэмжих зорилго бүхий “Хэвлэл мэдээлэл ардчиллын төлөө” төсөл хэрэгжүүлэхэд хамтарч ажиллалаа. Энэхүү төсөл нь (i) Сэтгүүлчид ажил үүргээ хараат бусаар гүйцэтгэхэд нь тэдэнд эрх зүй, мэргэжлийн дэмжлэг үзүүлж, аюулгүй байдлыг хамгаалах, (ii) нийгмийн сүлжээнд эерэг хандлага, зан үйл хэвшүүлэхэд нөлөө үзүүлэх гэсэн хоёр зорилтын хүрээнд хэрэгжив. Цахим технологид суурилсан мэдээллийн эрин үед нийгмийн сүлжээний гүйцэтгэж буй үүрэг уламжлалт хэвлэл мэдээлэлтэй өрсөлдөх хэмжээнд хүрч үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл шуурхай авах болон түгээх нэн нөлөөтэй хэрэгсэл нэгэнт болоод буй билээ. Гэвч нөгөө талаас, нийгмийн сүлжээ нь худал мэдээлэл тараах, үзэн ядалт, ялгаварлан гадуурхалтыг өөгшүүлэх зэрэг сөрөг үзэгдлийн талбар бас болж байна. Эдгээр үзэгдэлтэй зэрэгцэн төрийн зүгээс нийгмийн сүлжээг хэтрүүлэн зохицуулах оролдлого, санал санаачилгууд мөн гарч эхэллээ. Төслийн хүрээнд Глоб Интернэшнл байгууллагын зүгээс энэхүү нөхцөл байдалд иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах, ингэхдээ хувь хүний халдашгүй байдлыг хамгаалахад чиглэсэн зохистой эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийгмийн сүлжээнд ёс зүйтэй оролцох асуудлаар мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэсний зэрэгцээ цахим аян болон цуврал хэлэлцүүлэг, сургалт, вебинар зэрэг арга хэмжээг зохион байгуулжээ. Түүнчлэн төслийн нэгдүгээр зорилтын хүрээнд эрх нь зөрчигдсөн 19 сэтгүүлчид хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Эдгээр сэтгүүлчдэд бэлтгэсэн мэдээ, сурвалжилгатай нь холбогдуулан зөрчлийн хэрэг үүсгэсэн, утсаар дарамталсан, биед нь халдсан, тэдний эсрэг иргэний хэргийн шүүхэд нэр төр, алдар хүндэд хандсан хэмээн нэхэмжлэл гаргасан тохиолдлууд байх ба мөн хөдөлмөрийн маргаантай холбоотой асуудлуудаар хууль зүйн зөвлөгөө, тусламж хүссэн байх аж.

ННФ-аас үйл ажиллагааныхаа стратегийн хүрээнд 2015-2016 онд батлагдан хэрэгжиж эхэлсэн төрийн бодлого, шийдвэр гаргах үйл явцад иргэний нийгмийн оролцоог хангах үйл явцыг зохицуулсан гол хуулиудын хэрэгжилтийг дэмжих асуудалд онцгойлон анхаарал хандуулж ажиллаж ирлээ. Энэ хүрээнд иргэдийн оролцооны шинэ механизмуудыг ашиглах арга барилд иргэний нийгмийн байгууллагуудыг сургаж, хуулийн хэрэгжилтийг хангахад татан оролцуулах ажлыг шат дараатай зохион байгуулж байна. 2019 оны хувьд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудад болон Улаанбаатар хотноо Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах асуудлаар цуврал сургалт, үүлзалт зохион байгуулж төр, иргэний нийгмийн төлөөлөл 140 гаруй хүнийг хамруулав.

Мөн сургалтын агуулгыг оролцогч талуудад энгийн ойлгомжтой, хүртээмжтэй болгох зорилгоор видео хэлбэрт оруулан интернэтэд байрлуулах ажлыг 2019 онд үргэлжлүүлээ. Энэ нь орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр хэрэгтэй мэдээлээ олж үзэх, ашиглах боломжийг иргэдэд олгож буй хэрэг юм. Нийтийн сонсгол гэж юу, энгийн хэлэлцүүлгээс юугаараа ялгаатай вэ зэрэг түгээмэл асуултуудад хариулт өгсөн эхний видео хичээлийг 2019 оны 4-р сард ННФ-ын Facebook хуудсанд байршуулснаас хойш 5000 гаруй хүн үзсэн байх ба Томилгооны сонсголын онцлог ялгаа, зохион байгуулалтын асуудлыг тайлбарласан видеог 1500 гаруй хүн үзжээ. Түүнчлэн дээрх сургалтын үр өгөөжийг баталгаажуулах, хуулиудын хэрэгжилтийг хангахад төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор нийтийн эрх ашгийн өмгөөлөл хийх, болон цаг үеийн тодорхой асуудлаар нийтийн сонсгол зохион байгуулахад ТББ болон бусад талуудад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллав.

ННФ-ын дэмжлэгтэйгээр 2019 онд нийтийн эрх ашгийн өмгөөллийн хүрээнд, буруутай шийдвэр, эс үйлдэхүй нь нийтийн эрх ашгийг хохироосон төрийн

СЭДВИЙН ХҮРЭЭНД ОРОН НУТАГТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЦУВРАЛ СУРГАЛТ

Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах асуудлаарх цуврал сургалт, 2019 оны 6 сард



Сүхбаатар аймагт зохион байгуулсан сургалтын үеэр Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу иргэдийг шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцуулах сонсох ажиллагааг зохион байгуулах дадлага олгох дасгалын үеэр



Захиргааны ерөнхий хуулийг иргэдэд ойлгомжтой байдлаар тайлбарласан зурагт хуудсыг сургалтын үеэр орон нутагт тараав



Сургалтын явцаас



ННФ-ын Засаглалтын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг Хэнтий аймгийн иргэний нийгмийн төлөөлөлд Нийтийн эрх ашгийн өмгөөллийн талаар танилцуулж байгаа нь

байгууллага, албан тушаалтнуудыг хариуцагчаар татсан хэд хэдэн хэрэг нааштай шийдэгдээд байна. Үүнд:

- Жавхлант гэрэлт ирээдүй ТББ-ын хэрэгжүүлсэн нийтийн эзэмшлийн орон сууцны хорооллын гадна тохижилт хийлгэх, тохижилт хийгээгүй барилгыг хүлээн авч байгаа практикийг таслан зогсоох зорилго бүхий өмгөөллийн дүнд Ховд аймагт баригдсан "Гэрэлт хотхон"-ны гадна тохижилтын ажил хийгдэж, цаашид ийм дутагдалтай барилгыг хүлээн авахыг зогсоосон байна.
- Амьд хууль ТББ нь Баянхонгор аймгийн Бууцагаан сумын дунд сургуулийн захирлыг ажлаас үндэслэлгүй халсан Баянхонгор аймгийн Засаг даргын шийдвэрийг хүчингүй болгуулав.
- Онч шийдэл ТББ-ын гаргасан төрийн албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хуулийн хэрэгжилтийг хангах зорилго бүхий өмгөөлөл хийлээ. Үндэсний аудитын газрыг хариуцагчаар татан төрд учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаас нэхэмжлэх үүргээ хэрэгжүүлэхийг даалгах нэхэмжлэлийн шаардлагыг Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхээс

хангах шийдвэр гаргасан боловч Давж заалдах шатны шүүхээс ТББ-ын дүрмийн зорилгод нийцээгүй гэсэг үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болголоо. Ийнхүү нэхэмжлэл гаргах эрхгүй гэсэн үндэслэлээр шүүх хэргийг хэрэгсэхгүй болгосон ч энэхүү өмгөөллийн үр дүнд Үндэсний аудитын байгууллага болон түүний орон нутаг дахь салбарууд хуульд заасан үүргийн дагуу төрд учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаас нэхэмжлэх ажлыг эхэлжээ. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах албыг прокурорын байгууллагын дэргэд байгуулсан байна.

2019 онд Нийтийн сонсголын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд нийт долоон байгууллагад тэтгэлгийн дэмжлэг үзүүлэв. Үүнд: Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ) нь Баянхонгор аймгийн 2018 оны Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гийн хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаарх нийтийн сонсголыг 2019 оны 9 дүгээр сарын 20-нд зохион байгуулж, нийт 100 гаруй иргэн оролцжээ. Баянхонгор аймгийн хувьд энэ нь нийтийн сонсгол анх удаа зохион байгуулсан туршлага болсноороо онцгой ач холбогдолтой байв.



Булган аймгийн ИТХ-аар батлагдсан 2018 оны төсвийн талаар Нийтийн хяналтын сонсгол хийж буй нь, 2019 оны 7 сарын 19

Булган аймгийн ЛЭОС нь холбогдох төрийн байгууллагуудтай хамтран мөн “2018 оны ОНХС-гийн гүйцэтгэл” сэдвийн хүрээнд 2019 оны 7 дугаар сарын 19-нд нийтийн сонсгол анх удаа зохион байгуулжээ. Сонсголд нийт 60 хүн оролцсон ба сонсголын явцыг www.bulgan.gov.mn болон нийтийн сүлжээгээр дамжуулж олон нийтэд мэдээлсэн аж.

Өвөрхангай аймагт ЛЭОС-гийн салбар зөвлөл Бат-Өлзий, Уянга сумдад төсвийн хяналтын сонсгол зохион байгуулахад нутгийн удирдлагын байгууллагуудтай хамтран ажиллажээ. Энэ явцад нийтлэг тохиолдсон бэрхшээл нь сумдын удирдлагын зүгээс сонсголын ач холбогдлыг үл тоомсорлон хандах, олон нийт оролцооны шинэ тутам энэхүү механизмын талаар ойлголт мэдээлэл хангалтгүйн үлмаас сонирхохгүй байх, иргэдийн хувьд сонсголын үеэр санал хэлэхээс болгоомжлох, нийтийн эрх ашиг зөрчигдсөн асуудлаар санал хэлсэн ч хүлээж авахгүй, асуудал шийдэгдэхгүй, хэн ч хариуцлага хүлээхгүй гэж үзэн идэвх гаргахгүй байх хандлага ажиглагдаж байсныг дээрх ТББ тайландаа дурджээ.

Хөвсгөл аймагт Сайн засаглалыг дэмжих иргэдийн оролцоо ТББ-ын санаачилгаар тус аймгийн ИТХ, ЗДТГ, Мөрөн сумын ЗДТГ болон өөрийн ТББ-ын төлөөллийг оролцуулсан 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан 2019 оны 10 дугаар сарын 2-нд Хөвсгөл аймгийн 2019 оны ОНХС-гийн хөрөнгө оруулалтын асуудлаар хяналтын сонсгол зохион байгуулжээ. Сонсголыг угтан нийтийн сонсголын асуудлаар иргэдэд мэдээлэл өгөх гарын авлага боловсруулж сургалт зохион байгуулсан байх ба нийтийн сонсголын явцыг kural.mn цахим сайт, орон нутгийн ТВ, сониноор дамжуулан олон нийтэд хүргэсэн байна.

Хөвсгөл аймгийн Ханх суманд Хөвсгөл далайн эзэд ТББ-ын зүгээс Хөвсгөл аймгийн байгалийн цогцолбор болон сумын эдэлбэр газарт газрын зөвшөөрөл олгох үйл явцыг иргэдийн оролцоотой ил тод, нээлттэй болгох зорилгын хүрээнд Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулсан. 2019 оны 9 дүгээр сарын 29-нд Ханх сумын соёлын төвд болсон дээрх сонсголыг зохион байгуулахын тулд багагүй бэрхшээлтэй тулгарсан байх ба Ханх сумын ИТХ-ын даргад сонсгол зохион байгуулах хүсэлт хоёр ч удаа хүргүүлэн шаардлага тавьсны



Өвөрхангай аймгийн Уянга суманд болсон нийтийн сонсголд оролцогчид, 2019 оны 10 дугаар сарын 08.

зэрэгцээ Ханх сумын засаг дарга, Засаг даргын орлогч гэх мэт төрийн албан тушаалтнууд сонсголыг эсэргүүцэж, зөвшөөрөл олгосон ИТХ-аа дарамтлах гэх мэт үйлдэл гаргаж байсныг дээрх ТББ тайландаа дурджээ. Эдгээр бэрхшээлийг даван ажилласны үр дүнд Ерөнхий хяналтын сонсгол болж үүнд ТББ, иргэд, төрийн байгууллагуудын төлөөлөл нийт 95 хүн оролцсон аж. Хөвсгөл далай орчмын байгалийн үзэсгэлэнт газарт сүүлийн 30 жилд замбараагүй газар олгосноор аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн тоо эрс өсөж байгальд болон нутгийн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөө нэмэгдсэн байна. Тухайлбал, нуур орчимд олноор байрласан жуулчны баазуудын хог хаягдал, бохироос болж далайн ус бохирдох, нутгийн малчдын бэлчээр хомсдох гэх мэт асуудлууд газар авсан ажээ. Иргэдийн зүгээс сонсголд маш идэвхтэй оролцож, сонсголын мөрөөр хийсэн ажлын талаар тайлан сонсож мэдээлэл авах сонирхлоо илэрхийлж байсан нь цаашид энэ асуудлаар нутгийн удирдлагын зүгээс гаргаж буй шийдвэрт оролцох идэвх сонирхол өндөр байгааг илтгэж байна. Ханх сумын ИТХ-ын хувьд Нийтийн сонсголын тухай хууль, журам, сонсголын дэг, зохион байгуулалт, тэмдэглэлийг цахим хуудсанд байршуулан сонсгол зохион байгуулах талаар ойлголттой болж чадсан байна. Улаанбаатарт Хууль зүйн мэдээлэл, хамтын ажиллагааны нийгэмлэг нь УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд хүсэлт гарган Хууль тогтоомжийн

тухай хуулийн хэрэгжилтийн асуудлаар сонсгол зохион байгуулах нөлөөллийн үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн Завхан аймгийн ИТХ “Улиастай суманд үйл ажиллагаа явуулж буй нийтийн аж ахуйн газруудын цагийн хуваарийг иргэдийн оролцоотой тогтоох нь” төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа болно.

Энэ дашрамд дурдахад өнөөг хүртэл Нийтийн сонсголын тухай хуулийн хүрээнд нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар сонсгол зохион байгуулах туршлага орон нутгийн түвшинд голлон төвлөрч ирсэн ба УИХ-ийн түвшинд иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс удаа дараа хүсэлт илгээн шаардлага тавьж ажиллаж байгаа хэдий ч хуулийг хэрэгжүүлэх идэвх санаачилга хомс байж ирсэн юм. Нийтийн сонсголын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш УИХ-ын түвшинд анхны Ерөнхий хяналтын сонсголыг 2019 оны 1-р сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцан агаарын бохирдлыг бууруулах асуудлаар хийлээ. Ерөнхий хяналтын сонсгол нь агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн бодлого, шийдвэр, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүнд төлөвлөгдсөн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг тодруулах зорилго агуулж байв. Улаанбаатар



Хөвсгөл аймгийн Мөрөн суманд “Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо” ТББ-ын зохион байгуулсан Хөвсгөл аймгийн 2019 оны ОНХС-гийн хөрөнгө оруулалтын хяналтын сонсголд оролцогчид, 2019 оны 10 дугаар сарын 02.

хотын иргэдийн хувьд эрх ашиг нь хамгийн ихээр хөндөгддөг уг асуудлаар Ерөнхий хяналтын сонсгол хийх нөлөөллийн ажлыг Утааны эсрэг аав, ээжүүд ТББ 2017 оноос эхлэн ННФ-ын дэмжлэгтэй зохион байгуулсны үр дүн ийнхүү гарав.

Дээрх үйл ажиллагаанаас гадна Монгол Улсад ардчиллыг хөгжүүлэн бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, нийтийн эрх ашгийг хамгаалах, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн иргэний нийгмийн байгууллагуудын хөгжлийг дэмжих, үйл ажиллагаагаа тогтвортой, үр дүнтэй явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг нь олон нийтэд сурталчлах тодорхой ажлуудыг мөн зохион байгуулж ирлээ. Энэ чиглэлд 2019 онд ТББ-ын санхүүгийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 50 ТББ-д санхүүгийн программ хангамж олгон, хэрхэн ашиглах арга барилыг эзэмшүүлэх сургалтыг зохион байгууллаа. Төрийн ил тод, хариуцлагатай байдал, засаглалын тулгамдсан асуудлаар ТББ-ууд өөр хоорондоо мэдээлэл болон санал бодлоо солилцох боломж олгох зорилгоор Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, Ашиг хүртэгч эздийн асуудлаар болон авлига, шүүхийн томилгооны асуудлаар цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулав. Түүнчлэн иргэний нийгмийн эмэгтэй зүтгэлтнүүд, тэдний олон жилийн түүштай үйл ажиллагаа, үр дүн, ололт амжилтыг олон нийтэд таниулж сурталчлах зорилгын хүрээнд Гэрэг сэтгүүл, UB Life вэбсайт Нью-Йорк таймстай хамтран "Монголын эмэгтэйчүүд" сэдэвт тусгай дугаар гаргахад нь дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.

Жил бүр зохион байгуулагддаг "Playtime" амьд хөгжмийн олон улсын фестивалд ННФ анх удаа оролцож "Монголын хөгжлийн зураглал" сэдвээр залуучуудын дунд хэлэлцүүлэг өрнүүллээ. Энэ

хүрээнд улс орны ирээдүй, нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан ирээдүйн хөгжлийн дүр зураглалыг бүтээлч сэтгэлгээ, урлагаар дамжуулан илэрхийлэх боломж оролцогч залууст олгосон нь тэдний нийгмийн идэвхийг нэмэгдүүлэхэд нөлөөлөх шинэлэг бөгөөд сонирхолтой арга хэмжээ болсон юм.

PLAYTIME +

Залуус, Амьд Хөгжим, Бүтээлч Сэтгэлгээ, Инновац, Ногоон хөгжил - Монголын Ирээдүй!

**МОНГОЛЫН ИРЭЭДҮЙН
ЗУРАГЛАЛ**

Эх орныхоо хөгжлийн асуудлаар санал солилцох талбар энд байна. Өргөнөөр оролцоно уу.

Хэзээ: 7 сарын 7-ны өдөр 18:00-19:00 цагт
Хаана: ЛА ВИ ЭН РОУЗ АСАРТ



СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦ, УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

2020 оны УИХ-ын болоод орон нутгийн сонгууль угтсан онцлог жилийг бид үдлээ. Монгол Улс ардчилалд шилжсэнээс хойших 30 жилийн хугацаанд сонгууль бүрийн өмнө хуулиа өөрчилж ирсэн нь энэ удаад ч давтагдаж УИХ-аас 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг шинээр баталсан. Энэхүү хуулийн төслийг боловсруулах явцад иргэний нийгмийн байгууллагууд идэвхтэй оролцож, өмнөх сонгуулиар хийсэн мониторинг, бусад судалгааны дүнд үндэслэн сонгуулийн үйл явцыг боловсронгуй болгох, сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал, хяналтыг сайжруулахтай холбоотой тодорхой санал, зөвлөмж боловсруулан танилцуулах, хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр тасралтгүй үйл ажиллагаа

явуулсаар ирлээ. Улмаар шинээр батлагдсан УИХ-ын Сонгуулийн тухай хуульд Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээнээс өгсөн нийт 28 зөвлөмжөөс 25-ыг авч тусгасан талаар СЕХ уг хуулийг танилцуулах хэлэлцүүлэг дээрээ албан ёсоор мэдэгдсэн. Үүнд сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулахтай холбоотой хэд хэдэн заалтыг авч тусгасан байна. Тухайлбал, сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах хүрээнд нам, нэр дэвшигчдийн санхүүжилттэй холбоотой мэдээллийг сонгуулийн өдрөөс өмнө ил болгох, зардлын тайланд тавих шаардлага болон тайланг хянахтай холбоотой Төрийн аудитын эрх үүрэг, оролцоог тодорхой болгоход чиглэсэн дараах өөрчлөлтүүд үүнд багтжээ.

СОНГУУЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЛИЙГ СОНГУУЛИЙН ӨДРӨӨС ӨМНӨ ИЛ ТОД БОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Нам, эвсэл: Сонгуулийн жилийн 3 дугаар сарын 1-ээс өмнөх жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацааны намын зардлын дансанд хуримтлагдсан хандивын Төрийн аудитаар баталгаажуулсан мэдээллийг сонгуулийн өдрөөс өмнө Төрийн аудитын цахим хуудсанд нийтлэнэ (58.3).
- Нэр дэвшигч: Хөрөнгө орлогын мэдүүлгийг нэр дэвшигчдэд үнэмлэх олгосон өдрөөс эхлэн АТГ цахим хуудсандаа ил тавьж нийтэд мэдээлнэ.
- Нэр дэвшигч, нам, эвсэл хандив болон сонгуулийн зардлын явцын тайланг санал авах өдрөөс 3 хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ (58.4). Төрийн аудитын байгууллага эл мэдээллийг хүлээн авсан өдрөө цахим хуудсандаа ил тавьж, нийтэд чөлөөтэй танилцах боломж олгоно (58.3).

МӨНГӨН БУС ХАНДИВЫН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТЫГ ӨМНӨХӨӨС ТОДОРХОЙ БОЛГОСОН

Мөнгөн бус хандивт дараах зүйл хамаарна

- үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх (55.1.1)
- үйлчилгээ үзүүлэх (55.1.2)

Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж үнийг үндэслэн гэрээгээр тогтооно (55.4).

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГИЙГ ӨМНӨХӨӨС ИЛҮҮ НАРИЙВЧИЛСАН (58.2)

- Сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад гарсан зөрчлийн талаар баримт бичиг үйлдэх, бүрдүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх
- Зардлын тайлан гаргах, хүлээн авах, нийтэд мэдээлэх, танилцуулахтай холбоотой журам маягт батлах
- Аудитын шаардсан мэдээлэл, баримтыг холбогдох иргэн, хуулийн этгээд гаргаж өгөх үүрэгтэй.

ЗАРДЛЫН ТАЙЛАН ГАРГАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХУУЛЬД НИЙЦҮҮЛЖ НАРИЙВЧИЛСАН

- Орлого, зарлагын мэдээллийг бүрэн тусгана.
- Зардлын тайлан нь мөнгөн ба мөнгөн бус хөрөнгийн санхүүгийн тайлан байна.
- Тайлан гаргах үзүүлэлтүүд:
 - Нийт орлогын нийт хэмжээг хөрөнгийн эх үүсвэр болон гүйлгээ тус бүрээр
 - Зарлагын ангилал, гүйцэтгэл, гэрээний хамт.

Дээрх хуулийн хувьд сонгуулийн санхүүжилтийн мэдээллийг ил тод болгох, түүнд хяналт тавихтай холбоотой зохицуулалтууд сайжирсан боловч хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт суларсан үхралт гарлаа. Тухайлбал, сонгуулийн зардлын тайлангаа хяналтын байгууллагад ирүүлээгүй нам эвслийг дараагийн сонгуульд бүртгэхгүй байх заалтыг хассан байх ба зардлын тайлан ирүүлээгүй нэр дэвшигчийг Зөрчлийн тухай хуулиар 4,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 40,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох хариуцлага ногдуулахаар зохицуулжээ.

Түүнчлэн 2019 оны 11 дүгээр сарын 14-нд УИХ-аас баталсан Монгол Улсын Үндсэн Хуульд орсон нэмэлт өөрчлөлтөд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангахад чиглэсэн чамлахааргүй өөрчлөлтүүд туслаа. Тодруулбал, Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд “намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно” гэсэн заалт туссан нь цаашид улс төрийн санхүүжилтийн асуудлыг цогц байдлаар оновчтой шийдвэрлэхэд чухал хөшүүрэг болно гэж үзэж байна.

Эрх зүйн орчинд ийнхүү нааштай өөрчлөлт бий болоход улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчныг сайжруулах, ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлэх асуудлаар ННФ болон бусад талуудын сүүлийн жилүүдэд тасралтгүй хийж ирсэн судалгаа шинжилгээ, индекс, мониторингийн тайлан, тэдгээрийг тойрсон яриа мэтгэлцээн тодорхой хэмжээнд нөлөөлж дөхөм үзүүлсэн нь гарцаагүй юм. 2019 онд ННФ-аас судлаачид, иргэний нийгмийн зүгээс дээрх асуудлын хүрээнд зарим зөрүүтэй байр сууриа харилцан мэтгэлцэж нэгтгэх, шийдэл арга замыг тодорхой болгох, цаашлаад иргэний нийгэм болон судлаачдын зүгээс олон нийтэд мэдээлэл өгөх,

нөлөөллийн үйл ажиллагаанд оролцохдоо нэгдмэл байр сууринаас үндэслэлтэй мэдлэг, мэдээлэл өгөх нь ач холбогдолтой гэж үзэн хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Юуны өмнө улс төрийн санхүүжилтийн асуудлаар ажилладаг Сонгогчдын Боловсрол Төв, Бодлогод Залуусын Хяналт тэргүүтэй иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, Э.Гэрэлт-Од (МУБИС-ын Улс төр судлалын тэнхим), А. Бат-Оргил (Дефакто Институт), Б. Эрдэнэ-Далай (МУИС-ын Улс төр судлалын тэнхим) нарын бие даасан судлаачдаас бүрдсэн баг бүрдүүлэн үялдаа холбоо бүхий дараах гурван багц сэдвийн хүрээнд мэдээлэл солилцон, хамтран дүн шинжилгээ хийж, санал зөвлөмж боловсруулахад дэмжлэг үзүүлэв. Үүнд:

- Клиентилист намын тогтолцоог өөрчлөх, сонгуулийн өрсөлдөөнийг бодлогод чиглүүлж тэгш шударга болгох хөшүүргийг эрх зүйн орчинд хэрхэн бий болгох;
- Дээр дурдсан хөшүүргүүдтэй үялдуулан улс төрийн намын төлөвшлийг дэмжихэд чиглэсэн санхүүжилтийн тогтолцоог хэрхэн бүрдүүлэх;
- Улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчныг зохистой бүрдүүлсэн нөхцөлд хяналт, хариуцлагын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаарх асуудлуудаар дүн шинжилгээ хийж, сүүлийн 4-5 жилийн хугацаанд улс төрийн санхүүжилттэй холбоотой хийгдсэн бусад судалгаа, тэдгээрт туссан зөвлөмжүүдийг зэрэгцүүлэн, зөрүүтэй саналуудыг хэлэлцэж, нэгдсэн шийдэл тодорхойлох ажлыг гүйцэтгэлээ. Ийнхүү тодорхойлсон зарим шинэлэг шийдлийг оролцогч талуудад танилцуулах, тэдний байр суурийг тодруулах зорилгоор хэд хэдэн удаагийн мэтгэлцээнийг мөн зохион байгуулав. 2019 онд цувралаар зохион байгуулсан эдгээр мэтгэлцээн нь “Сонгуулийн төлбөртэй сурталчилгааг хориглох нь зөв үү” (www.youtube.com/watch?v=nv1wi3xRlfw), “Хуулийн этгээдээс улс төрийн нам, нэр дэвшигчид хандив өгөхийг

хориглох нь зөв үү?” (www.youtube.com/watch?v=al9JnP-3UzE), “Улс төрийн нам хатуу гишүүнчлэлтэй байх нь зөв үү?” (www.youtube.com/watch?v=ro5Y95zO95A) зэрэг сэдвийг хөндсөн.

Оролцогч талуудын хувьд санал хуваагдаж, маргаан үүсгэх нь элбэг дээрх асуудлуудаас гадна сонгууль, улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой бусад асуудлаар төр, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг зохион байгууллаа. Үүнд “Улс төрийн нам, сонгуулийн санхүүжилт, хяналт, хариуцлага Канад Улсын түршлага” сэдэвт уулзалт, “Сонгууль ба хэвлэл мэдээлэл” “Хуурамч мэдээллийн үе дэх сэтгүүлзүй ба сонгууль” “Хуурамч мэдээний хор үршиг” “Сонгуулийн хуулийн өөрчлөлт”, “Улс төрийн болон сонгуулийн санхүүжилтийн зохистой менежмент” зэрэг сэдвийг хамарсан уулзалт, хэлэлцүүлгүүдийг тус тус зохион байгуулсан. Хэлэлцүүлгүүд нь эрх

зүйн орчинд тодорхой зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаа зарим асуудлаар олон улсын сайн туршлагатай танилцах, өөрийн орны онцлогт тохирох шийдэл тодорхойлох, тодорхой бодлогын асуудлаар иргэний нийгмийн байр суурийг бодлого боловсруулагчдад хүргэх зорилго агуулж байв.

Эрх зүйн орчны шинэчлэлийг дэмжихэд чиглэсэн дээрх үйл ажиллагаанаас гадна хуулийн хэрэгжилтийг хангах чадавхыг сайжруулахад чиглэсэн зарим үйл ажиллагааг улс төрийн санхүүжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд болон бусад оролцогч талыг хамруулан зохион байгуулав. Улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, хууль тогтоомжийг ягштал хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг чангатган, зөрчил илэрсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох нь улс төрийн хүрээний буюу өндөр түвшний авлигыг бууруулахад чухал нөлөөтэй гэж үздэг. Манай улсын хувьд одоо мөрдөгдөж буй хуулиар сонгуулийн бус

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

TRANSPARENCY INTERNATIONAL-MONGOLIA
the global and locally independent leading anti-corruption organization

Ж.Сүхбаатар
ҮНБ-ын даргын
ахлах зөвлөх

Д.Оросов
Хуульч

Таныг улс төрийн санхүүжилтийн тогтолцооны шинэчлэл сэдвийн хүрээнд зохион байгуулж буй
УЛС ТӨРИЙН НАМ ХАТУУ ГИШҮҮНЧЛЭЛТЭЙ БАЙХ НЬ ЗӨВ ҮҮ?
сэдэвт мэтгэлцээнд хүрэлцэн ирэхийг урьж байна

Хэзээ: 2019 оны 11 сарын 1-ний 13.00-15.00 цагт.
Харна: Нээлттэй Нийгэм Форумын Хурлын танхимд
Жамъян Гүний гудамж 5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14240

RSVP: 313207

үед улс төрийн намын санхүүжилтэд тавих хяналтыг намын өөрийнх нь дотоод хяналтын байгууллагад хариуцуулсан байдаг бол сонгуулийн санхүүжилтийн хяналтыг 2016 оны УИХ-ын сонгуулиас эхлэн Төрийн аудитын байгууллагад хариуцуулж иржээ. Гэвч 2016 оны УИХ-ын сонгуулийн санхүүжилтийн мониторинг хийсэн иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс Төрийн аудитын байгууллагаас сонгуулийн зардлын тайланд хийж буй хяналт нь зардлын нийт дүнг олон нийтэд тойм байдлаар зарлах, хуульд заасан тодорхой хэмжээнээс дээш хандив өгсөн хувь хүмүүс, хуулийн этгээдийн талаар мэдээлэл цацахаас цааш хэтрэхгүй байгааг шүүмжилсэн байдаг. Энэ нь нэг талаас Үндэсний Аудитын Газар (ҮАГ)-ын сонгуулийн санхүүжилтэд хяналт тавих чиг үүрэг, түүнтэй холбогдох харилцааг нарийвчлан тусгаагүй, нөгөө талаас тус байгууллагын хувьд шинэ тутам дээрх чиг үүргийг гүйцэтгэх чадавх сул байсантай холбоотой юм.

Үүнтэй холбоотой ННФ-аас 2019 оны 4 дүгээр сард сонгуулийн зардлын тайланд хяналт тавих эрх зүйн орчны талаар санал солилцох, аргачлалыг тодорхой болгох хоёр өдрийн семинарыг Монгол Улсын Ерөнхий Аудиторын Орлогч, Ерөнхий Аудиторын Зөвлөх, ҮАГ-ын удирдах ажилтнууд, тэргүүлэх аудиторнууд,

бусад холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулав. Уг арга хэмжээнд зориулж ННФ-ын зүгээс сонгуулийн хууль тогтоомжид туссан сонгуулийн зардал, түүнд тавих хяналттай холбоотой зохицуулалтууд, Их Британи, Канад, Гүрж гэх мэт улсуудын сонгуулийн зардлын тайлангийн маягт, журам, заавар зэргийг нэгтгэсэн мэдээллийн багц бэлтгэсэн нь семинар үр дүнтэй болоход чухал ач холбогдол үзүүлсэн. Семинарын дараа ҮАГ-аас 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийг угтан сонгуулийн зардлын тайлангийн маягтууд боловсруулах, зардлын тайланг цахим болгох тодорхой төлөвлөгөөг боловсруулан ажиллаж эхэлсэн билээ. Үүнтэй холбоотой сонгуулийн зардлын тайланг цахимжуулах технологийн шийдэл болон сонгуулийн санхүүжилтэд хяналт тавих асуудлаар Эстони Улсын туршлагыг судлах ажлыг ҮАГ-ын төлөөлөл болон УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны мэргэжилтнүүдийг оролцуулан 2019 оны 11 дүгээр сард зохион байгууллаа. Энэ хүрээнд Эстони Улсын Улс төрийн санхүүжилтийн хяналтын хороо, Төрийн аудитын байгууллагууд, Парламентад суудалтай олонх болон сөрөг хүчний гол намуудын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагууд, Эстонийн Цахим засаглалын академийн мэргэжилтнүүдтэй уулзан мэдээлэл авч туршлага судалсан болно.



Улс төрийн болон сонгуулийн санхүүжилтийн зохистой менежмент сургалтын явц 2019 оны 11 дүгээр сарын сарын 5-8.

Түүнчлэн 2019 онд Ардчилал, Сонгуульд Дэмжлэг Үзүүлэх Олон Улсын Хүрээлэн (АСДҮОУХ)-тэй хамтран хэрэгжүүлж буй “Улс төрийн санхүүжилт: Ёс зүй, оролцоо, хариуцлага” төслийн хүрээнд 2019 оны 11 дүгээр сарын 5-8-ны өдрүүдэд “Улс төрийн намын санхүүгийн зохистой менежмент” сургалтыг нам, намын төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулав. Сургалтыг олон улсын Humentum (<https://www.humentum.org/>) байгууллага удирдан явуулсан бөгөөд уг байгууллага нь ашгийн бус байгууллагын дотоод засаглал, түүний дотор улс төрийн намын санхүүгийн сахилга бат, зарчим, тэдгээрийг хангах процесс, зохион байгуулалтын талаар аль ч мэргэжлийн хүнд ойлгомжтой тайлбарлаж таниулах сургалтыг дэлхий даяар зохион байгуулдаг нэр хүндтэй байгууллага юм. Сургалтад хамрагдсан улс төрийн намын төлөөллийн хувьд нам санхүүгийн сахилга батаа хангахын тулд ямар зарчим баримталж, ямар процесс журмын дагуу ажиллах нь зүйтэй талаар суурь мэдлэг эзэмших боломжийг ийнхүү бүрдүүлж өгөв.

Дээрх төслийн хүрээнд 2019 оны 12 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд ҮАГ-тай хамтран "Улс төрийн санхүүжилтийн хяналтын тогтолцоо: Олон улсын

туршлага" сэдэвт олон улсын дугуй ширээний уулзалт зохион байгууллаа. Энэхүү уулзалтад Монгол Улстай түүхэн жимээр холбогдох хуучин социалист Гүрж, Латви улсуудын төрийн хяналтын байгууллагын мэргэжилтнүүд, Энэтхэг Улсын Сонгуулийн Ерөнхий Хорооны төлөөлөгч, АСДҮОУХ болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын судлаачид оролцсон бол Монголын талаас ҮАГ-ын удирдах ажилтнууд, мэргэжилтнүүдээс гадна АТГ, СЕХ, УИХ-ын төрийн байгуулалтын байнгын хорооны төлөөлөл оролцон туршлага солилцсон юм.

Улс төрийн санхүүжилтийн тогтолцоог шинэчлэхэд оролцогч талуудын дунд, ялангуяа улс төрийн намуудын дунд зөвшилцөл бий болох нь чухал юм. Үүнтэй холбоотой АСДҮОУХ-тэй хамтран төслийн хүрээнд улс төрийн намуудад мөн мэдээлэл өгөх зорилгоор “Улс төрийн санхүүжилтийн цахим тайлангийн систем: Олон улсын сайн туршлага”, “Улс төрийн санхүүжилтийн зохицуулалтын шилдэг загварчлал”, “Улс төрийн санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт ба Жендерийн асуудал” сэдэвт сургалт-хэлэлцүүлгүүдийг мөн зохион байгууллаа.



"Улс төрийн санхүүжилтийн хяналтын тогтолцоо: Олон улсын туршлага" Олон улсын дугуй ширээний хэлэлцүүлэгт оролцогчид 2019 оны 12 сарын 5-6

АСДҮОУХ-тэй хамтран хэрэгжүүлж буй “Улс төрийн санхүүжилт: Ёс зүй, оролцоо, хариуцлага” төслийн хүрээнд 2019 онд гүйцэтгэсэн нэг чухал ажил нь АСДҮОУХ-ээс эрхлэн гаргасан дэлхийн бараг бүх улс орны улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин, бусад мэдээллийг нэг дор багцлан танилцуулсан цогц бүтээл болох Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийн гарын авлагыг Монгол хэлнээ хөрвүүлэн нийтийн хүртээл болгосон явдал байв. Энэхүү гарын авлагад ардчилсан тогтолцоонд иргэд сайн дураараа эвлэлдэн нэгдэж улс төрийн хүсэл зоригоо илэрхийлэх, төрийн үйл хэрэг, засаглалд оролцох гүүр болох уламжлалт үүргээ намууд зохих ёсоор гүйцэтгэхэд улс төрийн санхүүжилтийн асуудал ямар чухал нөлөөтэй болох, уг асуудлыг шийдвэрлэлгүй орхигдуулсны улмаас үүсэх засаглалын янз бүрийн бэрхшээл нь эдүгээ дэлхий дахинаа ардчилалд нүүрлэж буй гол эрсдэл болоод байгааг онцлон өгүүлжээ. Улмаар өндөр түвшний авлига, төрийн албаны тогтворгүй байдал, хандивлагчдын зүгээс төрийн бодлого шийдвэрт нөлөөлөх болон төрийн хөрөнгө, нөөцөөр санал худалдан авах үзэгдэл гэх мэт улс төрийн санхүүжилттэй холбоотой асуудлыг шийдвэрлэхээр зорьсон янз бүрийн улс орнуудын туршлагыг харьцуулан тайлбарласан байгаа нь манайд өрнөж буй эрх зүйн орчны шинэчлэлд тус болох буй заа гэж найдаж байна.

Улс төрийн намууд, төрийн болон олон улсын байгууллагуудтай ийнхүү хамтран ажиллахаас гадна иргэний нийгэм, олон нийтийг мэдээллээр хангах нь мөн чухал болохыг үйл ажиллагааны стратегидаа онцолсны дагуу сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. ННФ-тай сонгууль, улс төрийн санхүүжилтээр ажилладаг ТББ-уудын хувьд чадавх нь харьцангуй сайн, үйл ажиллагаа нь тогтмолжиж танигдсан байгууллагууд байдаг давуу талтай. Энэ хүч бололцоог сааруулахгүй байх үүднээс ойрын жилүүдэд Бодлогод залуусын хяналт ТББ-д “Улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг дээшлүүлэхэд

нөлөөлөх” урт хугацааны зорилго бүхий “Улс төр ба Мөнгө” хөтөлбөрт дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. Тус байгууллагын хувьд хоёр дахь жилдээ энэхүү хөтөлбөрөө хэрэгжүүлж буй бөгөөд 2019 оны хувьд УИХ-ын 2020 оны сонгуульд хяналт тавих бэлтгэл ажлыг эхлүүлж, мөнгө эд зүйл тараах гэх мэт хууль бус сурталчилгаанд хяналт тавьж баримтжуулах ажлыг оюутнуудын оролцоотой зохион байгуулсан ба улмаар санал худалдан авах үзэгдлийг үл тэвчих уур амьсгалыг нийгэмд дэлгэрүүлэх зорилгын хүрээнд “Улс төрчдийн гарын бэлэг” сэдэвт явуулын гэрэл зургийн үзэсгэлэн гаргахын зэрэгцээ “Гэр иргэдийн оролцоо, амьдрах орчны зураглалын төв”-тэй хамтран, “Хоёр хотын цадиг” 5 өдрийн гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгуулсан аж.

Түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд хуримтлуулсан туршлага, судалгааны баримтуудад тулгуурлан НҮБ-ын гишүүн 192 орны хүний эрхийн төлөв байдлыг 4 жил тутамд дүгнэн хэлэлцэх чухал механизм болох Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR - Universal Periodic Review)-т хөндлөнгийн тайлан илгээж, #ХүчирхэгСонгогч2020 цахим аяныг эхлүүлэн хэрэгжүүлж байна. Тус байгууллагын зүгээс хоёр дахь жилдээ “Улс төр ба Мөнгө” оюутны мэтгэлцээнийг зохион байгуулсан ба энэ арга хэмжээнд оролцож улс төрийн санхүүжилт, сонгуулийн асуудлаар мэдээлэлтэй болсон залуусыг 2020 оны УИХ-ын сонгуульд хяналт



тавихад оролцуулахаар төлөвлөжээ. Түүнчлэн “Бодлого ярьцаая, Залуус аа!” судалгаанд тулгуурласан уламжлалт хэлэлцүүлгээ цаг үеийн чухал асуудал болох Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн үйл явц, агуулгын талаар залууст мэдээлэл өгөхөд чиглүүлж улмаар залуучуудын ТББ-ууд нэгдэж “Үндсэн хуульд иргэдийн оролцоо” цахим аяныг амжилттай хэрэгжүүлсэн юм. Үндсэн Хуулийн нэмэлт, өөрчлөлтөд багтсан дэвшилтэй заалтуудыг дэмжсэн уг аян нь нийгмийн сүлжээгээр

100 гаруй мянган хүнд хүрчээ. ННФ-ын зүгээс улс төрийн санхүүжилтийн асуудлаар тууштай мэдлэг, туршлага хуримтлуулан, уг асуудлаарх санаачилгадаа бусад залуусаа татан оролцуулж ажиллаж байгаа уг байгууллагатай хамтран 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулиар сонгуулийн тухай хуульд заасан сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал, хяналттай холбоотой заалтуудын хэрэгжилтэд мониторинг хийхэд хамтран ажиллахаар төлөвлөж байна.

УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙГ ИЛ ТОД БОЛГОХОД ТББ-УУДЫН ЗҮГЭЭС ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН АЖЛУУД



“Улс төрчдийн гарын бэлэг” сэдэвт явуулын гэрэл зургийн үзэсгэлэн, 2019 оны 11 сард



“Улс төр ба Мөнгө” сэдэвт оюутны мэтгэлцээн. 2019 оны 11 сар.



“Хоёр хотын цадиг” үзэсгэлэнг зохион байгуулагчид. 2019 оны 11-р сарын 8-ны өдөр. #Хүчирхэг2020 сонгогч



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ДУУСГААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖУУДЫН САНХҮҮЖИЛТИЙГ 2020 ОНЫ ТӨСӨВТ ТУСГАХ ШААРДЛАГАТАЙ

eagle.mn 14:05 ВАЛЮТЫН НӨӨЦ 3.9 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРТ ХҮРСЭН БАЙНА

ТӨСВИЙН ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ

Монгол Улсын төсвийн удирдлагын өнөөгийн байдлыг шинэ түвшинд хүртэл сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байгааг сүүлийн жилүүдийн төсвийн үйл явц тодорхой харуулж байна. Нэг талаас, Улсын Их Хурал (УИХ) ихээхэн хэмжээний алдагдалтай төсөв баталж байгаа, нөгөө талаас Засгийн газар гадаадаас их хэмжээний зээл авч байгаа нь улсын өрийн хэмжээг эрс нэмэгдүүлсэн. Мөн УИХ Төсвийн тухай хууль зөрчин зураг, төсөвгүй барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг жил бүр нэмж батлахын сацуу Засгийн газраас өргөн барьсан хөрөнгө оруулалтын төслүүдийн тухайн жилийн санхүүжилтийн хэмжээг бууруулан баталдаг. Эдгээр нь он дамжсан дуусдаггүй барилга байгууламжийн тоог нэмэгдүүлж, улмаар төсөвт өртөг нь өсөх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах сөрөг үр дагаврыг бий болгох нэг хүчин зүйл болж байна. Иймээс улс, орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэд, иргэний нийгмийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ННФ дараах арга замаар ажиллаж ирлээ.

Улс, орон нутгийн төсвийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөлт зэрэг тодорхой асуудлуудаар жил бүр судалгаа шинжилгээ хийн үр дүнг бодлого боловсруулагчид, олон нийтийн дунд танилцуулж, өргөн хүрээний цуврал хэлэлцүүлэг өрнүүлэх, хялбаршуулсан мэдээллийн багц, инфографик гаргах зэргээр бодлогын нөлөөллийн ажлуудыг тогтмол хийж буй. Тэрчлэн, 2018 оноос бид төрийн хяналтын байгууллагуудтай хамтын ажиллагаа өрнүүлэх, төсөв дэх иргэдийн оролцооны шинэ механизм болох төсвийн хяналтын сонсголыг орон нутагт зохион байгуулах ажлыг дэмжих, Шилэн дансны тухай хуулийн хүрээнд ил болсон зарлага, худалдан авалтын мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх, иргэний нийгмийн төсвийн шинжилгээний чадавхыг бий болгох чиглэлээр ажиллаж байна.

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН УДИРДЛАГЫГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дээр дурдсанаар Монгол Улсын төсвийн алдагдал, өрийн удирдлага, хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах асуудал

хурцаар тавигдаж буй энэ үед төсвийн асуудалд иргэд, иргэний нийгмийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх нь чухал юм.

2020 оны Улсын төсвийн төслийн шинжилгээ

Бид 2019 онд 2020 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд дүн шинжилгээ хийн түлгарч буй асуудлуудыг хөндөж гаргахыг зорилоо. Бие даасан судлаачидтай хамтран гүйцэтгэсэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын байдлын судалгаагаар УИХ-аас төсөв батлахдаа төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тоог нэмэхээс гадна Засгийн газраас өргөн барьсан нэлээд хэдэн төслийн тухайн жилийн санхүүжилтийн хэмжээг бууруулж баталсан нь харагдсан. Энэ нь он дамжсан, дуусдаггүй барилга байгууламжийг нэмэгдүүлж, жилээс жилд төсөвт өртөг нь өсөх сөрөг үр дагавар дагуулдаг ба үүнийг Үндэсний аудитын газраас 2018 онд дуусаагүй орхигдсон 40 гаруй барилгын ажилд хийсэн аудитын дүн харуулдаг. Бидний хийсэн судалгаагаар эдгээр төслүүдээс 20 гаруй барилгын ажлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг 2020 оны төсөвт суулгаагүйгээс

эдгээр барилга дуусахгүй үлдэхээр байна. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг буурах, барилга, байгууламжийн чанар муудах, эзэнгүйдэх, улмаар татвар төлөгчдөөс улсын төсөвт хуримтлуулсан эх үүсвэр үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг дагуулж байна.

ННФ 2019 онд мөн судлаачидтай хамтран 2020 оны төсвийн орлогын төлөвлөлтийг шинжлэн, 2020 оны нэгдсэн төсвийн төлөвлөсөн орлогын тооцоолол бодитой эсэх, ирэх жилд учирч болзошгүй эрсдэлүүдийг тоймлох, мөн орлогын бүрдэлтэд нөлөөлөх хүчин зүйлсэд дүгнэлт хийв. Түүнчлэн, тусгай сангуудын төсвийн төлөвлөлтийн судалгааны хүрээнд Нийгмийн даатгалын сангийн болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа Халамжийн сангийн 2019 оны төсвийн зарлага, 2020 оны зарлагын төлөвлөлтийн судалгааг хийж гүйцэтгэлээ.

Дээрх судалгаануудын үр дүнг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр танилцуулж, 2020 оны төсвийн төлөвлөлтөд анхаарах асуудал, судалгааны гол үр дүнг багцлан, энгийн ойлгомжтой харуулсан цуврал инфографик гарган нийтэд хүргэлээ. Мөн судлаачид,

төрийн бус байгууллагын төлөөлөл судалгааныхаа дүнг телевизийн цуврал хэлэлцүүлгээр олон нийтэд танилцуулав. (Энэ сэдвийн “2019 онд зохион байгуулсан үйл ажиллагаа”, “Сэдвийн хүрээнд гарсан хэвлэн нийтлэл” хэсгүүдийг харна уу)

Төсвийн нээлттэй байдал

Олон улсын төсвийн түншлэлийн хүрээнд гаргадаг Монгол Улсын “Төсвийн нээлттэй байдал”-ын ээлжит үнэлгээ 2019 онд хийгдлээ. Энэхүү үнэлгээг АНУ-д төвтэй Олон улсын төсвийн түншлэл (www.internationalbudget.org) байгууллагаас 2 жил тутамд эрхлэн гаргадаг бөгөөд ННФ хамтран ажилладаг билээ. Энэхүү судалгаагаар дэлхийн 100 гаруй орны төсвийн ил тод байдал, төрийн хяналтын байгууллагуудаас төсөвт тавих хяналт, төсвийн үйл явц дахь иргэдийн оролцооны түвшнийг харьцуулан үнэлж эрэмбэлдэг юм. Түүнчлэн, уг судалгаагаар улс орнуудын төсвийн нээлттэй байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээний талаарх Зөвлөмжийг гаргадаг ба 2019 оны ээлжит судалгааны дүнг 2020 онд дэлхий даяар танилцуулна.

Бид 2006 оноос энэхүү судалгааг хийж, дүнг бодлого боловсруулагчид, олон нийтийн анхааралд оруулж ажилласнаар гарсан нэг үр дүн нь 2018 оноос эхлэн Сангийн яам Иргэний төсвийн танилцуулга гаргах болсон явдал. Энэ нь улсын төсвийн төсөл болон батлагдсан төсвийн иргэнд зориулсан хялбаршуулсан хувилбарууд юм. Иргэний төсвийн танилцуулгыг энэ жилээс цахимаар нийтлэх болсныг онцлон тэмдэглүүштэй. Тэрчлэн, ННФ-аас 2015 оноос Улс, орон нутгийн төсвийн үйл явцын цаглабар ажиллуулж эхэлсэн бөгөөд энэхүү цаглабар нь төсвийн байгууллагын захирагчдын төсөв боловсруулах, хэлэлцэх, батлах, тайлагнах зэрэг үйл ажиллагааны хуваарийг иргэд, олон нийт мэдэх боломжийг бүрдүүлдэг юм.



Төсвийн үйл явцын цаглабар

Төсвийн болон мэдээллийн ил тод байдлын холбогдох хууль эрх зүйн баримт бичигт үндэслэн боловсруулсан улсын болон орон нутгийн төсвийн үйл явцын цахим цаглабар (www.forum.mn/tsaglabar/index.php)

Энэхүү цаглабараас иргэд, олон нийт цахим хаягаа бүртгүүлэн ойрын үед болох төсвийн үйл явцын талаарх сануулга мэдээллийг 7 хоногоор нь авах боломжтой.

ТӨСВИЙН ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭРХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ННФ-аас 2015-2017 онд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд орон даяар тасралтгүй хяналт тавьж, дүнг төр засаг, олон нийтийн анхааралд оруулж ажилласан нь уг хууль хэрэгжихэд чухал түлхэц болсон гэж бид үздэг билээ. Харин 2018 оноос Шилэн дансанд ил болсон төсвийн мэдээллийг нийтэд хүргэх замаар төсөвт иргэдийн

хяналт, оролцоог бүрдүүлэхийг зорьж ажиллаж байна. Үндэсний аудитын газрын аудитын дүнгээр 2018 оны бүтэн жилийн байдлаар уг хуулийг улсын төсвийн ерөнхийлөн захирагч (ТЭЗ), тэдгээрийн харьяа байгууллагууд 90.2 хувь, аймаг, нийслэлийн ТЭЗ, тэдгээрийн харьяа байгууллагууд 89.3 хувиар тус тус хэрэгжүүлжээ.

Төсвийн зарцуулалтын чиглэлээр

Шилэн дансанд ил болсон орон нутгийн төсвийн зарлагын мэдээллийг нийтэд хүргэх, төсөвт иргэдийн хяналт, оролцоог бий болгох чиглэлээр ажилладаг 15 төрийн бус байгууллага (ТББ)-ын үйл ажиллагааг 2019 онд бид дэмжиж ажиллалаа. Энэ хүрээнд 12 аймаг, нийслэлийн Багануур дүүрэгт ажилласан эдгээр ТББ-ын төслийг санхүүжүүлснээр тэд шилэн дансанд ил болсон зарлага, худалдан авалтын мэдээлэл, орон нутгийн төсөвт бүтцийн шинжилгээ хийсэн дүгнэлт, мэдээллийг нийтэд хүргэхийн зэрэгцээ Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-тай хамтран төсвийн сонсгол зохион байгуулан иргэдийг өргөнөөр оролцуулж, төсвийн худалдан авалт, тодорхой сангуудын зарцуулалтад мониторинг хийлээ. Тухайлбал, Архангай аймгийн Халамжийн сан болон Баянхонгор аймгийн Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийг дэмжих сангуудын зарцуулалт, зарим сумдын Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ, Сум хөгжүүлэх сан (СХС)-гийн зарцуулалт, Булган аймгийн Байгаль хамгаалах сангийн төсвийн гүйцэтгэл, аймгийн

2020 оны төсөв, Дархан-Уул аймгийн Дархан сумын төсвийн орлого, зарлага, ОНХС-гийн зарцуулалт, Дорнод аймгийн Хэрлэн сумын зарим төсөвт байгууллагын төсвийн зарцуулалт, Дундговь аймгийн СХС-гийн зарцуулалт, Завхан аймгийн 2020 оны төсөв, Өвөрхангай аймгийн зарим сумдын СХС-гийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, Ховд аймгийн ТЭЗ-ийн төсвийн төлөвлөлт, Жаргалант сумын СХС, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт, “Хөвсгөл нуур байгалийн цогцолборт газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн төсөл”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнгээр орон нутгийн байгууллагуудтай хамтран тодорхой арга хэмжээ зохион байгуулжээ (Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтээс харна уу). Мөн Дархан-Уул аймгийн Дархан сумын 2018-2019 оны төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтын асуудлаар, Өвөрхангай аймгийн ХЭДС-гийн төсвийн зарцуулалтаар төсвийн сонсголүүд хийгдэв (“ТББ-уудаас гаргасан мэдээлэл, мониторинг, зохион байгуулсан сонсгол” хэсгийг харна уу).

Тэрчлэн, ННФ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр Захиргааны Шинэ Санаачилга ТББ аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авалтын мэдээллийг жилийн туршид нийтэд хүргэж ирлээ. Энэ хүрээнд тус ТББ нь 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн эрүүл мэндийн төв, нэг, хоёрдугаар шатлалын эмнэлгүүдийн 5 000 000 төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг 2019

онд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэлээ. Захиргааны Шинэ Санаачилга ТББ сонгогдсон байгууллагуудын төсвийн зарцуулалт, тухайн байгууллагуудад эм ханган нийлүүлэгчдийн мэдээллийг нэгтгэн дүгнэж, танилцуулга мэдээлэл бэлтгэснээс гадна сэтгүүлчдэд мэдээлэл хүргэх уулзалтыг зохион байгуулж ажиллав.

2019 онд төсвийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэх чиглэлээр 12 аймаг, нийслэлд ажилласан төрийн бус байгууллагууд

№	Аймаг/дүүрэг	Байгууллагын нэр	Төслийн нэр
1	Архангай	“Архангай” бие даан амьдрах төв	Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн үйлчилгээний төсвийн зарцуулалтад хийх мониторинг
2	Баянхонгор	Амартайван итгэл ТББ	Төсөв-хонгор нутгийн иргэдийн хяналт
3	Булган	Булганы өнгө ТББ	Булган аймгийн төсөв, тусгай сангийн зарцуулалтын хариуцлагатай байдлыг дээшлүүлэх нь
4	Дархан-Уул	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний Дархан-Уул аймгийн салбар зөвлөл	Төсвийн хяналт, төсвийн сонголт суралцах нь
5	Дорнод	Буйр нуур, Халхгол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн ТББ	Шилэн дансны мэдээллийг иргэдэд хүргэх нь - мониторингийн төсөл
6	Дундговь	Дундговь Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ ТББ	Сум хөгжлийн сангийн зарцуулалт ба ил тод байдал
7	Завхан	Өрнөх хөгжил ТББ	Бидний оролцоо-иргэний хяналт
8	Өвөрхангай	Орон нутгийн санаачилга ТББ	Сум хөгжүүлэх сангийн зарцуулалт ба иргэдийн хяналт, оролцоо
9		Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан ТББ-ын Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөл	Ил тод сан-2 төсөл
10	Төв	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөний Төв аймгийн салбар зөвлөл	Төсвийн зарцуулалт-Иргэний хяналт
11		Ажил олгогч эздийн “Бизнес” холбоо	Иргэдийн хяналт – Зуунмод зөвлөл
12	УБ	Залуус манлайлал төв ТББ	Төсвийн ил тод байдал, төсвийн зарцуулалтад иргэдийн оролцоо
13	Увс	Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Увс аймаг дахь салбар	Иргэд болон сэтгүүлчид хамтран орон нутгийн төсвийн мэдээллийг олон нийтэд хүргэх нь
14	Ховд	Ховдын толь ТББ	Ил, тодын буухиа -II
15	Хөвсгөл	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн ТББ	Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл - мониторинг

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДААС ГАРГАСАН МЭДЭЭЛЭЛ, МОНИТОРИНГ



ТӨСВИЙН СОНСГОЛЫН ЯВЦААС




Өвөрхангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн зарцуулалтаар хийсэн төсвийн сонсголын явцаас



Дархан-Уул аймгийн Дархан сумын 2018-2019 оны төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтын төсвийн сонсголын явцаас


АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАН АВАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ЗАХИРГААНЫ ШИНЭ САНААЧИЛГА ТББ-ААС НИЙТЭД ХҮРГЭСЭН МЭДЭЭЛЛЭЭС



Төрийн аудитын Зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр

Төсвийн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн төрийн аудитын Зөвлөмжийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагууд идэвхтэй оролцож ажиллалаа. Төрийн аудитын байгууллага нь хуулийн дагуу УИХ-аас бусад төрийн болон төрийн өмчийн оролцоотой бүх байгууллагын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрээс нь үл хамааран аудит хийдэг. Тэрчлэн, дээрх байгууллага нь Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө болон олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс Монгол Улсын Засгийн газар, төсвийн байгууллагад олгосон зээл, тусламж, хандивын ашиглалт, зарцуулалт, үр дүн зэрэгт аудит хийх эрхтэй.

Төрийн аудитын байгууллагаас (i) санхүүгийн тайлангийн, (ii) гүйцэтгэлийн, (iii) нийцлийн гэсэн гурван төрлийн аудит хийж, дүгнэлт, Зөвлөмж гаргадаг. Төрийн аудитаас өгсөн зөвлөмжүүд хэрэгжээгүй буюу өмнө өгсөн Зөвлөмж давтагдах хандлагатай байгаа нь ажиглагдав. Энэ нь аудитын Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил хангалтгүй байгааг харуулах тул бид аудитын Зөвлөмжийн хэрэгжилтийг дээшлүүлэх чиглэлээр ажиллах Үнэн хатамж ТББ-ын үйл ажиллагааг дэмжиж ажиллалаа. Тус ТББ аудитын албан шаардлага, Зөвлөмжийн биелэлтийн мэдээлэлд дүгнэлт хийж, иргэний нийгэм, иргэд, бодлого боловсруулагчдад www.sinaudit.mn цахим хуудас, нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлэл түгээж ирлээ.



Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн мэдээллийн www.sinaudit.mn цахим хуудсыг “Үнэн хатамж” ТББ-аас эрхлэн ажиллуулж байна.

ТӨРИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГАТАЙ ӨРНҮҮЛСЭН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд төрийн хяналтын байгууллагуудтай түншлэн ажиллах зорилгоор ННФ нь 2018 оноос эхлэн Үндэсний Аудитын газартай амжилттай хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд 2018 онд Шилэн дансны тухай хууль дахь "...төсвийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд ... 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээний санхүүжилт, хэрэгжилтийн явцаа шилэн дансны цахим хуудаст мэдээлэх" үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгааг хянах төрийн аудитад анх удаа иргэний нийгмийн шинжээчид оролцсон билээ.

Харин 2019 онд аудитын дүнг олон нийтэд хүргэх мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллалаа. Энэ хүрээнд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн аудит, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон барилгуудын аудит, улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитын дүнгүүдээр тус тус мэдээллийн багц бэлтгэн нийтэд хүргэлээ. Энэ нь иргэд, олон нийт, хууль тогтоогчдын анхаарлыг аудитын дүгнэлт, зөвлөмжид хандуулахад ач холбогдолтой ажил болж байна гэж талууд үзэж байна. ("Сэдвийн хүрээнд гарсан хэвлэн нийтлэл" хэсгийг харна уу).


МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Бид 2008 оноос хойш Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ)-тай түншлэн жил бүр гаргаж буй улс орнуудын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр манай улсын ерөнхий үзүүлэлтэд ахиц гарсангүй. 2019 онд манай улс авбал зохих 100 онооноос 53 авснаар судалгаанд хамрагдсан 141 орноос 102 дугаарт эрэмбэлэгдэв. Өмнөх онд манай улс мөн 53 оноо авч 140 орноос 99 дүгээрт эрэмбэлэгдсэн юм. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол

Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030" бодлогын баримт бичгийн биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийн тоонд өрсөлдөх чадварын үзүүлэлт орж, манай улс дэлхийд өрсөлдөх чадвар сайтай эхний 70 орны нэг болох зорилт дэвшүүлсэн тул өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр дорвитой ажил хийх шаардлагатай байгааг судалгааны дүн харуулж байна.


Монгол Улсын өрсөлдөх чадвар 2018 ба 2019 онд (12 тулгуур үзүүлэлтээр)

Оноо (100 онооноос)



■ 2019 он ■ 2018 он

Зэрэглэл (141 улсаас)



■ 2019 он ■ 2018 он

Дэлхийн өрсөлдөх чадварын 2019 оны тайланг бүрэн эхээр нь <https://www.weforum.org/reports> хуудаснаас үзнэ үү.

СЭДВИЙН ХҮРЭЭНД ГАРСАН ХЭВЛЭН НИЙТЛЭЛ

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМААС ХИЙСЭН СУДАЛГААНЫ ДҮНГЭЭР ГАРГАСАН БҮТЭЭГДЭХҮҮН:

“Монгол Улсын 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хийсэн судалгаа” инфографикийн багц



“Монгол Улсын 2020 оны төсвийн төсөл: Орлогын төлөвлөлт” инфографикийн багц



“Нийгмийн даатгалын сангуудын 2020 оны төсвийн төсөл” инфографикийн багц



“Монгол Улсын 2020 оны төсвийн төсөл:
Нийгмийн халамжийн сангийн зарлагын
төлөвлөлт” инфографик багц



“Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020
оны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл”
(инфографик)



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТАЙ ХАМТРАН ГАРГАСАН:

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт: Аудитын ерөнхий дүн” (инфографикийн багц)



“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон барилгуудын гүйцэтгэлийн аудитын тайлан-2018” (инфографикийн багц)




“Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” аудитын дүнгээс (инфографикийн багц)



СЭДВИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ТВ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ТВ хэлэлцүүлэг-1: "Монгол Улсын 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт" (2019.10.29) (<https://www.facebook.com/eaglenewssocial/videos/531575190746374/?t=15> -аас үзнэ үү)



Судлаач Ж.Сайнзаяа



Судлаач Д.Баярмаа



ННФ-ын хөтөлбөрийн менежер Д.Оюнбадам

ТВ хэлэлцүүлэг-2: "Монгол Улсын 2020 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөлт" (2019.10.31) (<https://www.facebook.com/eaglenewssocial/videos/2337562109842211/?t=15> -аас үзнэ үү)



Судлаач А.Мөнхцог



Хэлэлцүүлэгт оролцсон судлаачид


1

АРЧИЛСАН САЙН ЗАСГАЛДЫГ
БЭХЖҮҮЛЭХ

ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ
ДЭМЖИХ

БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН
БОЛЛОГО

САНХҮҮГИЙН
ТАЙЛАН



ЭРДЭС БАЯЛГИЙН 14 ТӨРЛИЙН 700 ОРЧИМ ГЭРЭЭНД ИРГЭД ХЯНАЛТ ТАВИХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН САЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ

Нээлттэй Нийгэм Форум 2019 онд Эрдэс баялгийн салбарын засаглалын хөтөлбөрийнхөө хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, хариуцлага шаардах иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх замаар бодлогын үхралт гарахаас сэргийлэх, салбарын засаглалын асуудлаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилтууд тавьж ажиллалаа.

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛТ

Өнгөрсөн оны хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр эрдэс баялгийн салбарын бодлогод зарчмын шинжтэй шинэчлэлийг эхлүүлэх үндэс суурийг тавьж өглөө. Үүнтэй холбоотойгоор салбарын бусад холбогдох хууль тогтоомжид дэс дараатай өөрчлөлт хийгдэх нь тодорхой болов. Түүнчлэн, ОУИТБС-ын хэрэгжилтийг хуульчлах ажил өрнөж олон талын оролцоотой ажлын хэсэг

ажиллан хуулийн төсөл боловсрууллаа. Энэ хуулиар эрдэс баялгийн салбарын мэдээллийн ил тод байдал, ялангуяа эцсийн өмчлөгчийн мэдээлэл ил тод байх суурь зарчим тавигдахын зэрэгцээ гэрээний ил тод байдал, компани болон төрийн байгууллагуудын өгсөн авснаа ил тод тайлагнах үйл явц хуулийн хүрээнд баталгаажих юм.

Үндсэн хуулийн өөрчлөлт

2019 онд өрнөсөн Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр эрдэс баялгийн салбарын бодлогын хүрээг дараах байдлаар тодорхойлсон.

ХУУЛИЙН ЗААЛТ

- *Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.*
- *Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл аюулгүй орчин амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэснийн баялгийн санд төвлөрүүлж, тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.*
- *Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.*
- *Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.*

(2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан хэсэг)

ННФ нь Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар салбарын байр суурийг тодорхойлох Ажлын хэсэгт багтаж дараах хоёр чиглэлээр байр сууриа илэрхийлж ажиллалаа. Үүнд:

- (i) Байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зарчмыг хангах буюу салбарын хөгжлийг дэмжихийн сацуу нийгэм, байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх
- (ii) Ил тод байдлыг хангах, үр өгөөжийг иргэдэд тэгш шударга хүртээх.

ОУИТБС-ын хуулийн төсөл

ОУИТБС-ын хэрэгжилтэд 2018 оноос гарч эхэлсэн өөрчлөлт шинэчлэл 2019 онд идэвхтэй өрнөж, ил тод байдлын тайлан мэдээ бэлтгэх үйл ажиллагааг төрийн байгууллагуудын чиг үүрэгт тусган хэвшүүлэх, мэдээллийн баталгаатай, шуурхай байдлыг хангахад төр, хувийн хэвшлийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр бие даасан хуулийн төсөл боловсруулах ажил өрнөлөө. Бид ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн гишүүний хувьд хуулийн төсөл боловсруулах ажилд идэвхтэй оролцон Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгааг хийсэн нь бие даасан хуулийн төслийг цаашид боловсруулах ажлын гол үндэслэл болон ашиглагдаж байна.

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай буюу ОУИТБС-ын хуулийн нэг чухал зүйл нь гэрээний ил тод байдал бөгөөд үүнтэй холбоотойгоор Гэрээний мэдээллийн санг бүрдүүлэх, нийтэд нээлттэй тогтмол ажиллагаатай байлгах асуудал юу юунаас чухал байгаа юм. Тиймээс ННФ Уул уурхай хүнд үйлдвэрийн яамтай хамтран 2016 оноос гэрээний мэдээллийн сан байгуулах ажлыг эхлүүлж, тасралтгүй ажилласаар байна.

Энэ нь зөвхөн ННФ –ын төдийгүй энэ салбарт нөлөөлөл, мониторингийн чиглэлээр олон жил үйл ажиллагаа явуулж байгаа Монголын иргэний нийгмийн байгууллагуудын байр суурь юм. Тиймээс цаашид бид Үндсэн хуулийн үзэл санаанд салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх бодлогын хэлэлцүүлэгт иргэний нийгмийн байгууллагуудыг зохион байгуулан идэвхтэй оролцож, шийдвэр гаргах үйл ажиллагаанд албан ёсоор оролцох, мэдээлэл авах, хяналт тавьж, хариуцлага нэхэх, байгалийн баялгийн үр өгөөжийг тэгш шударгаар хүртэх иргэдийн эрхийг баталгаажуулахад анхаарал хандуулан ажиллах болно.

Гэрээний ил тод байдал

Гэрээний ил тод байдлыг хангахаар сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн ажлын үр дүн гарч 2019 онд Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санг (www.iltodgereee.mn; www.resourcecontracts.mn) олон нийтийн хүртээл болгов. Уг мэдээллийн санд төрөөс олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниудтай байгуулсан 14 төрлийн 700 гаруй гэрээг байршууллаа. Тэрчлэн энэхүү мэдээллийн сангийн нээлтийн үеэр “Эрдэс баялгийн салбарт гэрээний ил тод байдлыг хангах нь” сэдвийн дор 2019 оны 4 сарын 22-24-ний өдрүүдэд цуврал хэлэлцүүлэг зохион байгуулсан нь салбарын үйл ажиллагаанд хамаарах талуудад уг мэдээллийн сантай танилцах, ашиглах, гэрээгээ байршуулах боломж болсноос гадна салбарын ил тод байдалд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэх талбар боллоо. Мөн гэрээний ил тод байдлыг хангахад иргэний нийгмийнхний үүрэг оролцоо, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, үр нөлөөг хэлэлцэх сайхан боломж олгосон юм.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ОУИТБС-ын Ажлын алба, Олон Улсын Санхүүгийн Корпораци,

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй Мерит төсөл зэрэг олон талуудтай хамтран зохион байгуулсан дээрх цуврал арга хэмжээний хүрээнд 3 өдрийн турш доорх сэдвээр хэлэлцүүлэг өрнүүллээ. Үүнд:

- “Орон нутгийн гэрээний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, үр нөлөө” хэлэлцүүлэг
- “ОҮИТБС-ын хэрэгжилт, гэрээний ил тод байдал тулгамдсан асуудал” хэлэлцүүлэг
- Аймгийн захиргааны албан хаагчдад зориулсан Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд гэрээ байршуулах сургалт
- “Гэрээний ил тод байдлыг хангахад иргэний нийгмийн үүрэг оролцоо” хэлэлцүүлэг.

УУХУ-ийн дэд сайд гэрээний мэдээллийн санг нээж хэлсэн үгэндээ “Монгол Улсын эрдэс баялгийн салбарт гэрээний ил тод байдлыг хууль

тогтоомжид тусган баталгаажуулах чиглэлээр цаашид тодорхой арга хэмжээ авч ажиллах болно” хэмээсэн нь энэ чиглэлээр баримтлах төрийн байр суурийг албан ёсоор илэрхийлсэн хэрэг боллоо. Түүнчлэн дээрх цуврал хэлэлцүүлгийн үр дүнд эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хангахад чиглэсэн бие даасан хууль батлан гаргах, ингэхдээ сүүлийн жилүүдэд яригдаж ирсэн гэрээний болон эцсийн өмчлөгчийн ил тод байдлын асуудлыг цогцоор нь тусган шийдвэрлэх талаар талууд байр сууриа нэгтгэлээ. Энэ нь одоо ид өрнөж байгаа Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулах ажил эхлэхэд түлхэц болсон юм.

Орон нутгийн захиргааны албан хаагчдад хийсэн сургалтын үр дүнд орон нутагт уул уурхайн салбарт байгуулагдсан гэрээг мэдээллийн санд шуурхай байршуулах боломж нээгдэж, уг сургалтаас хойш нийт 260 гаруй гэрээг шинээр байршуулжээ.



Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сангийн нээлт. 2019 оны 4 сарын 22



Эрдэс баялагийн гэрээний мэдээллийн сангийн нээлт. УУХҮЯ-ны Гэрээний ил тод байдлыг хангах Ажлын хэсгийн гишүүн, Олборлох салбарын засаглалыг сайжруулах төслийн зохицуулагч Ш.Цолмон. 2019 оны 4 сарын 22.



Эрдэс баялагийн гэрээний мэдээллийн сангийн нээлтэд ННФ-ын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал үг хэлж буй нь. 2019 оны 4 сарын 22



Эрдэс баялагийн гэрээний мэдээллийн сангийн нээлтэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав үг хэлж буй нь. 2019 оны 4 сарын 22.



"Орон нутгийн гэрээний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, үр нөлөө" хэлэлцүүлэгт оролцогчид. 2019 оны 4 сарын 23

Эцсийн өмчлөгчийн бүртгэл


2017 оноос хэрэгжиж эхэлсэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх бүхий хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийн хэрэгжилтэд 2019 онд Авлигатай тэмцэх газар (АТГ)-тай хамтран дүн шинжилгээ хийлээ. Дүн шинжилгээгээр эцсийн өмчлөгчийг тодорхойлохтой холбоотой эрх зүйн орчин болон практикт тулгарч байгаа бэрхшээл, сорилтуудыг тодорхойлов.

Энэхүү судалгаагаар Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд эцсийн өмчлөгчийг зөрүүтэй тодорхойлсноос гадна, төрийн байгууллагуудын бүртгэл бүрэн цахимжаагүй, аж ахуйн нэгжүүдийн чадавх дутагдаж байгаа нь харагдав. Эдгээр нь хуулийн хэрэгжилтийг сааруулах гол хүчин зүйлс юм.


Татварын ерөнхий газар, Хуулийн этгээдийн бүртгэлийн газар, Ашигт малтмал, газрын тосны газрын дүн мэдээгээр эцсийн өмчлөгчийн бүртгэлийн хэрэгжилт дөнгөж 40 орчим хувьтай

байна. Өөрөөр хэлбэл, тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 2088 компаниас 63 хувь нь эцсийн өмчлөгчийн мэдээллээ огт бүртгүүлээгүй байгаа нь анхаарал татаж байгаа юм (графикийг харна уу). Өөрөөр хэлбэл, 2017 оноос эхлэн хэрэгжсэн эцсийн өмчлөгчийг бүртгүүлэх шаардлага 2018 оны 6 сарын 1-ний өдрөөс хойш зогсонги байдалд орсон байх боловч эцсийн өмчлөгч, түүний мэдээлэлд орсон өөрчлөлтийг бүртгүүлээгүй хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг цуцлах тухай Ашигт малтмалын тухай хуулийн заалт огт хэрэгжихгүй байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, тэдгээрийг эзэмшигч хуулийн этгээдийн тоо, 2019 оны 12 сарын 15-ны байдлаар



Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газарт эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлсэн хуулийн этгээд, эцсийн өмчлөгч этгээдийн тоо, 2019 оны 12 сарын 15-ны байдлаар



Тэрчлэн хууль тогтоомжийн зөрүүтэй байдлаас шалтгаалан дээрх төрийн байгууллагуудын мэдээлэл, тоо баримт хоорондоо зөрүүтэй байгаа нь цаашид эцсийн өмчлөгчийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нийтэд ил тод болгох ажилд саад учруулахаар байна.

Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрдэс баялгийн салбарт эрчимжүүлэх зорилгоор АТГ-тай хамтран зохион байгуулсан дугуй ширээний хэлэлцүүлгээр дээрх дүн шинжилгээний дүнг холбогдох байгууллагуудад танилцуулан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг хүргүүллээ. Үүний үр дүнд Хуулийн этгээдийн бүртгэлийн газартай хамтран эцсийн өмчлөгчийн бүртгэлийн маягтыг шинэчлэн батлуулаад байна.



“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт: олборлох салбарын ил тод байдал” хэлэлцүүлэг.
2019 оны 12 сарын 17

НИЙТИЙН ЭРХ АШГИЙН ӨМГӨӨЛӨЛ

Төрийн үйл ажиллагаа хууль зөрчихгүй, олон нийтийн эрх ашгийг хууль бусаар хөндөхгүй, хариуцлагатай явагдах нь өнөөгийн нийгэмд тулгамдсан асуудал болж байна. Энэ цаг үед иргэний нийгэмд хуулиар олгогдсон боломж болох нийтийн ашиг сонирхлыг шүүхэд нэхэмжлэн хамгаалах өмгөөллийг Монгол Улсад түгээн дэлгэрүүлэхэд анхаарал хандуулах нь чухал. Энэ үйл явцад ННФ зохих хувь нэмэр оруулах

зорилгоор нийтийн ашиг сонирхлын хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүхийн практикт дүн шинжилгээ хийж, холбогдох талуудад танилцууллаа.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэн буюу 2016 оны 7 сараас 2018 оны 12 сар хүртэлх хугацаанд захиргааны хэргийн шүүхэд хүлээн авсан

нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилго бүхий нэхэмжлэл, тэдгээрийг хянан шийдвэрлэх ажиллагааг хамарсан уг судалгаагаар эрх зүйн орчин, шүүхийн практик дахь хууль хэрэглээний алдаа, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэх төрийн бус байгууллагуудын чадавхтай холбоотой анхаарах асуудлуудыг тодорхойллоо. Тухайлбал, нийтийн ашиг сонирхлын хамрах хүрээг өргөжүүлэн Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн мэдээлэл авах, төрийн шийдвэр, үйл ажиллагаанд оролцох эрх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, нийтээр ашиглах дэд бүтцийн төлөвлөлтийн асуудлаар нэхэмжлэл гаргах боломжийг нээх шаардлагатай байна. Түүнчлэн зөвхөн төрийн бус байгууллага төдийгүй тухайн асуудлаар хангалттай ашиг сонирхол илэрхийлсэн хэн бүхэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжийг бүрдүүлэх зэрэг чиглэлээр эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ байна.

Харин шүүхийн практик талаас шүүх энэ төрлийн нэхэмжлэлийг хүлээн авахдаа нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, зөрчигдөх бодит эрсдэл үүссэн эсэхэд анхаарал хандуулж, дүгнэлт хийхийн оронд нэхэмжлэл гаргагч этгээдийн эрх зүйн байдалд түлхүү анхаарч, нэхэмжлэлийг хүлээн

авахгүй байх, үндэслэлгүйгээр олон дахин буцаах, хуулиар тогтоогоогүй шаардлага тавих, шүүх хуралдааныг үндэслэлгүйгээр хойшлуулах зэрэг алдаа дутагдал гарсаар байна.

Судалгааны дүгнэлт зөвлөмжийг холбогдох талуудад танилцуулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд туршлага мэдээлэл солилцох зорилгоор “Байгаль орчны эрхийн хэрэгжилт: Нийтийн эрх ашгийн өмгөөлөл” сэдэвт 3 өдрийн хэлэлцүүлгийг Хүний эрх хөгжил төв, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын сүлжээ (ЭЗНСЭОУС)-тэй хамтран зохион байгуулав. Хэлэлцүүлэгт ЭЗНСЭОУС-ний гишүүн Өмнөд Африк, Энэтхэг, Кени, Уганда, Нигери, Ирланд, Бангладеш, Филиппин, Индонез, Өмнөд Солонгос, Гүрж, Бразил, Мексик, Колумб, Чили, Эквадор, Франц, АНУ-ын байгаль орчин, хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, хуульчид, өмгөөлөгчид, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчид, Монголын хуульчдын холбооны Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн хороо, Захиргааны эрх зүйн хорооны гишүүн хуульчид, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцож мэдээлэл, туршлагаа хуваалцлаа.



“Байгаль орчны эрхийн хэрэгжилт: Нийтийн эрх ашгийн өмгөөлөл” сэдэвт хэлэлцүүлэгт оролцогчид. 2019 оны 6 сарын 11-13

Түүнчлэн 2019 онд иргэний нийгмийг чадавхжуулах зорилгоор Төрийн ил тод хариуцлагатай байдлыг дэмжих хөтөлбөртэй хамтран “Иргэний нийгмийн төрд хяналт тавих оролцоо, нийтийн эрх ашгийн өмгөөлөл” сэдэвт сургалтыг Дорнод, Хэнтий,

Сүхбаатар аймагт зохион байгууллаа. Сургалтад оролцсон орон нутгийн төрийн бус байгууллагуудын дунд нийтийн эрх ашгийн өмгөөллийн тэтгэлэг зарлан б байгууллагыг шалгаруулан ажиллаж байна.

2019 онд ННФ-ын дэмжлэгтэйгээр хийгдэж байгаа нийтийн эрх ашгийн өмгөөллийн хүрээнд гарсан гол үр дүнгээс

- Газрын тосны тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй Дорнод аймгийн Матад сумын Засаг даргын эс үйлдэхүйг хууль бусад тооцуулж, Петрочайна Дачинтамсаг ХХК-тай орон нутаг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулахыг даалгасан шүүхийн шийдвэр гаргуулав. Үүний үр дүнд тус компани нь орон нутгийн хөгжилд зориулж жил бүр 1,2 тэрбум төгрөг олгох гэрээг Халхгол, Матад сумдтай байгуулжээ.
- Төлсөн авсанаа нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвслийн 2018 оноос хойш тасралтгүй ажиллаж байгаа Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг шаардах өмгөөлөл өнөөг хүртэл үргэлжилж байна. 2019 онд Улсын дээд шүүхээс анхан шатны шүүхэд буцаасан уг хэргийг 2020 оны 1 сард анхан шатны шүүх дахин хэлэлцээд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй Монгол Улсын Засгийн газрын эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоолоо. Харин хариуцагч Засгийн газар гомдол гаргаснаар одоо уг хэрэг Улсын дээд шүүхэд дахин хянагдаж байна.
- Чингэлтэй дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооноос хөгжлийн бэрхшээлтэй хүн ял эдэлж байх хугацаандаа Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хуралдаанаар орж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгох боломжийг хаасан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалыг хүчингүй болгуулахаар ажиллаж байна. Уг хэргийн үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хязгаарласан дээрх шийдвэрийг өөрчлөх ажлын хэсгийг дээрх яамдаас томилон ажиллуулж байна.
- Их бага Баяншарга ТББ Сүхбаатар аймгийн Уулбаян, Түвшинширээ сумдад хууль зөрчиж олгогдсон цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлуулахаар ажиллаж байна. Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхэд буцаажээ. Улсын дээд шүүхээс давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр батлав.
- Нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах мэргэшсэн байгууллагуудыг бэлтгэх зорилго бүхий урт хугацааны тэтгэлгийн хүрээнд Хил хязгааргүй алхам ТББ нь говийн бүс нутагт уул уурхайн хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн 5 хэрэг дээр ажиллаж байна. Үүнд:
 - Уул уурхайн сөрөг нөлөөлд өртсөн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, хохирлын нөхөн төлбөр олгох хуулийн хэрэгжилтийг шаардах өмгөөллийн үр дүнд ЗГХЭГ-аас ийнхүү нөхөн төлбөр олгоход баримтлах эрх зүйн үндэс болох Нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний аргачлал болон холбогдох журам боловсруулах үүрэг бүхий салбар дундын ажлын хэсэг байгуулжээ.

- *Байгаль орчин, нутгийн иргэдийн эрүүл мэнд, амьжиргаанд сөрөг нөлөөлөл үзүүлж буй уул уурхайн хууль бус тээвэрлэлтийг зогсоох өмгөөллийн үр дүнд Зам тээвэр хөгжлийн яамнаас Ажлын хэсэг гарган ажиллуулж, Тавантолгойн уурхайгаас Говьсүмбэр аймаг хүртэлх 430 гаруй км замд хатуу хучилттай зам барих хүртэл тээвэрлэлтийг зогсоох шийдвэр гаргаад байна.*
- *Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд иргэдийн оролцоог хангах зорилго бүхий өмгөөллийн хүрээнд Дорноговь аймгийн Захиргааны хэргийн шүүхээс Даланжаргалан сумын Засаг даргын уул уурхайн компанитай байгуулсан гэрээг хүчингүй болгох шийдвэр гаргалаа. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд Сонсох ажиллагаа хийх шаардлагатайг ийнхүү анх удаа шүүхийн шийдвэрээр баталгаажуулсан нь уул уурхай бүхий бусад аймаг, сумдад жишиг болох ач холбогдолтой юм.*

Цаашид нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан шүүхийн шийдвэрээр дамжуулан бодлого, хууль тогтоомжийг өөрчлөх, холбогдох талуудад сурталчлан ойлгуулах замаар ижил төстэй зөрчил

давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх, сайн жишиг тогтоох чиглэлээр төрийн бус байгууллагууд түлхүү анхаарч ажиллах шаардлагатай байна.



Нийтийн эрх ашгийн өмгөөллийн амжилтыг танилцуулах арга хэмжээ, Зүүн гар талаас өмгөөлөгч Г.Дашдэмбэрэл, ННФ-ын менежер Д.Эрдэнэчимэг, Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн ТББ-ын тэргүүн Б.Баярмаа.



Өмгөөлөгч Г.Дашдэмбэрэл, Newspress агентлагийн сэтгүүлч Ж.Хулан. 2019 оны 1 сарын 24

Төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа

Эрх зүйн орчинд гарсан ахиц дэвшлийг сахин хамгаалж, үхралт гарахаас сэргийлэх зорилготой иргэний нийгмийн хяналтын (watchdog) бүлгийг ТАН эвсэлд тулгуурлан үргэлжлүүлж, Хүнд үйлдвэрийг

хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлого, журамд санал өгч ажиллалаа. ТАН эвслийн олон улсын хамтын ажиллагаа, санхүүгийн бие даасан байдлыг бэхжүүлэх үүднээс хөрөнгө босгох, харилцаа холбоо

хариуцсан орон тооны ажилтан ажиллуулснаар НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн нөөцийн хүрээлэн, "Төлсөн авсанаа нийтэл" олон улсын сүлжээтэй хамтран хөрөнгө босгох ажил хийж, хариуцлагатай уул уурхай, байгаль орчны мониторингийн хамтын ажиллагаа эхлүүлэв. Байгаль орчны мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулах STRIPE төслийн туршлагыг Төв аймгийн Алтанбулаг суманд өргөжүүлэн хэрэгжүүлэхэд ТАН эвсэлтэй хамтран ажилласнаар тус суманд ажилладаг уул уурхайн 5

компанийн үйл ажиллагааг Төв аймгийн Цагдаагийн газраас шалгаж эхэлжээ.

STRIPE төслийн үр нөлөөг үнэлэх, цаашдын үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор 2019 онд Сүхбаатар аймгийн Заамар, Төв аймгийн Заамар, Алтанбулаг сумдад газар дээр нь очиж ажиллав. Энэ үеэр цуглуулсан мэдээллээр уул уурхайгаас үүдэн байгаль орчин, нутгийн иргэдэд тулгамдаж буй асуудлыг хөндсөн цуврал нийтлэл бэлтгэн гаргалаа.



Зүүн гар талаас: Төв аймгийн Алтанбулаг сумын иргэдтэй STRIPE төслийн багийнхны хийсэн уулзалт, дараагийн зурагт төслийн баг Төв аймгийн Алтанбулаг сумын удирдлагуудтай уулзалт хийж буй нь. 2019 оны 9 сарын 24

2020 оноос ТАН эвслийн зохицуулагчаар Транспарэнси Интернэшнл Монгол ТББ сонгогдож, орон нутагт хуулийн хэрэгжилт, хариуцлагыг төлөвшүүлэхэд эвслийн үйл ажиллагааг бүхэлд нь чиглүүлэхээр ажлаа эхлүүлээд байна.

Эрдэс баялгийн салбарын засаглалын талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, иргэдийн хяналт, оролцоотой байлгах нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд юу юунаас чухал. Энэ чиглэлд манай хамтран ажилладаг төрийн бус байгууллагууд мэргэшин ажиллаж нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хооронд байгуулагддаг гэрээний үйл явцад иргэдийн хяналт,

оролцоог идэвхжүүлэхэд чиглэсэн тодорхой төслүүд хэрэгжүүлж байна. Харин ННФ нь энэ чиглэлээр Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнтэй хамтран Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний агуулга, хэрэгжилт, олон нийтийн хяналт сэдэвт сургалт зохион байгуулан 2018 оныг хүртэл 15 аймгийн 20 гаруй сумын иргэд, төрийн бус байгууллагыг хамруулсан бол 2019 онд Завхан аймагт мөн энэ сургалтаа зохион байгууллаа. Уг сургалтын хүртээмжийг тэлэх үүднээс сургалтад ашигладаг материалыг цахим гарын авлага болгон нийтийн хүртээл болголоо.



Завхан аймагт зохион байгуулсан “Орон нутгийн гэрээний агуулга, хэрэгжилт, олон нийтийн хяналт” сургалт. 2019 оны 10 сарын 23-24 өдрүүд

Эдгээр үйл ажиллагаанаас харахад, цаашид уул уурхайн орон нутагт үзүүлэх үр өгөөж, нийгэм байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэхэд Орон

нутгийн хамтын ажиллагааны гэрээний эрх зүйн асуудлыг бодлогоор зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулах

Байгалийн баялгийн зохистой удирдлагыг хангахад чухал үүрэгтэй төрийн өмчит компаниудын ил тод байдал, засаглалыг сайжруулах үйл ажиллагаагаа 2019 онд үргэлжлүүлж, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын 2018-2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (ХЭЭХ)-ын зохион байгуулалтад үнэлгээ хийлээ. Топ-20 ангиллын хувьцаат компаниудыг хамарсан үг судалгаанд Эрдэнэс Тавантолгой, Багануур, Шивээ овоо, Шарын гол, Тавантолгой зэрэг төрийн болон орон нутгийн өмчит уул уурхайн компаниуд мөн нэмж хамрагдлаа.

Компаниудын ХЭЭХ-ын зохион байгуулалтыг (i) хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, (ii) хурлын бэлтгэл ажил, (iii) хурлын зохион

байгуулалт, (iv) хурлын дараах ажиллагаа гэсэн үзүүлэлтийн хүрээнд үнэлэхэд судалгаанд хамрагдсан компаниудын дундаж оноо 3.2 (нийт 5 оноо авахаас) буюу дундаж үнэлгээ нь “дунд” түвшинд гарлаа. Энэ нь СЗХ-ны 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Компанид засаглалын үнэлгээ хийх, төвшин тогтоох журам”-д заасан үнэлгээний төвшнөөр Хөрөнгийн бирж дээрх ТӨП-20 ХК-ийн ХЭЭХ-ын зохион байгуулалт хангалттай түвшинд байна гэсэн үг биш юм. Иймд цаашдаа ХЭЭХ-тай холбоотой эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох, хувьцаа эзэмшигчдээс авах саналын хуудсыг боловсруулах, тэдэнд мэдээлэл хүргэх, тооллогын комиссын үйл ажиллагааг зохих ёсоор хэрэгжүүлэхэд компаниуд илүүтэй анхаарч ажиллах шаардлагатай нь харагдлаа.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

- Орон нутгийн гэрээний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, үр нөлөө” хэлэлцүүлэг
- “ОУИТБС-ын хэрэгжилт, гэрээний ил тод байдал тулгамдсан асуудал” хэлэлцүүлэг
- “Гэрээний ил тод байдлыг хангахад иргэний нийгмийн үүрэг оролцоо” хэлэлцүүлэг
- “Байгаль орчны эрхийн хэрэгжилт: Нийтийн эрх ашгийн өмгөөлөл” олон улсын хэлэлцүүлэг
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт: Олборлох салбарын ил тод байдал” дугуй ширээний ярилцлага
- Мэдээллийн санд гэрээ байршуулах чиглэлээр орон нутгийн захиргааны ажилтнуудад зориулсан сургалт
- Иргэний нийгмийн төрд хяналт тавих оролцоо, нийтийн эрх ашгийн өмгөөлөл сургалт
- Орон нутгийн гэрээний агуулга, хэрэгжилт, иргэдийн оролцоо сургалт

ХЭВЛЭН НИЙТЭЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН

- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хэрэгцээ, шаардлага урьдчилсан тандан судалгааны тайлан
- Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шүүхийн практик
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулалт - үнэлгээний тайлан





НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ
ДЭМЖИХ



ХҮНИЙ ЭРХ

ННФ-ын Хүний эрхийн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс дахь хүний эрхийн механизмыг бэхжүүлэх, олон улсын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт оролцох, иргэдийн хүний эрхийн боловсрол, мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлд тодорхой ажлууд төлөвлөн хийдэг билээ. 2019 оны хувьд Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форум (Хүний эрхийн форум гэх) нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг” механизмд 3 дахь удаагийн тайлангаа илгээлээ. Энэхүү тайланг нийслэл, хөдөө орон нутгийн иргэд, иргэний нийгэм, төрийн байгууллагын оролцоотой бэлтгэлээ.

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМЫГ БЭХЖҮҮЛЭХ

Хүний эрхийн форум нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг” механизмд хүний эрхийн үндэсний тогтолцоо, бодлогын үялдаагүй хөгжил ба хүний эрх, бүлгийн эрх, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо сэдвээр хамтарсан илтгэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрүүдэн шүүхээс ангид байх эрх, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн цөөнх хүмүүсийн эрх зэрэг сэдвээр дангаар илтгэл бэлтгэн хүргүүллээ. Тус тайланг бэлтгэх явцад гарсан том амжилт нь хэлэлцүүлгийг нийслэл төдийгүй орон нутагт цувралаар зохион байгуулснаар иргэдийн оролцоог өмнөхөөс тэлсэн явдал юм. Тайланг бэлтгэх үйл явц 10 сар орчим үргэлжилсэн бөгөөд нийт 20 орчим аймаг, орон нутаг, нийслэлийн 1000 гаруй иргэдээр хэлэлцүүлж, холбогдох төрийн байгууллагуудтай удаа дараа зөвлөлдсөний дүнд боловсрууллаа. Тухайлбал, иргэний болон улс төрийн эрхийн чиглэлээр бэлтгэж байгаа тайланг ХЗДХЯ, түүний харьяа агентлагуудтай, эдийн засаг, нийгэм, соёлын эрх, бүлгийн эрхийн тайланг ХНХЯ болон түүний харьяа агентлагуудтай тус тус зөвлөлдсөн билээ. UPR I, II циклийг бодвол зөвлөлдөх үйл явцад бүх талын оролцоо хангалттай байсан нь жинхэнэ утгаар зөвлөлдөх боломжийг олгосон юм.

Хүний эрхийн форум нь хүний эрхийн чиглэлээр хяналт тавьдаг, энэ чиглэлээр хариуцсан төрийн байгууллагатай хамтран ажилладаг, шаардлагатай үед хамтарсан нөлөөлөл, хамгааллын үйл ажиллагааг явуулдаг хүний эрхийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн институц болсон бөгөөд үүний нэг илэрхийлэл нь UPR Info Олон улсын ТББ-аас эрхлэн нийтэлсэн *“The Butterfly Effect: Spreading Good Practices of UPR Implementation”*, *“UPR Mid-term reporting: Good practices for UPR*

Stakeholders”, *“The Civil Society Compendium: A comprehensive guide for Civil Society Organizations engaging in the UPR”* зэрэгт Монголын Хүний эрхийн форумын туршлагыг онцлон дурдсан явдал байв. Үйл ажиллагаагаа тогтмолжуулах, хүний эрхийн чиглэлээр хүлээсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэхэд чадавхтай, идэвхтэй гишүүн байгууллагын гүйцэтгэх хувь нэмэр өндөр тул ННФ энэ чиглэлээр дэмжлэг үзүүлэхийг чухалчилдаг бөгөөд энэ хүрээнд “НҮБ-ын гомдлын механизмыг үр нөлөөтэй ашиглах нь” сэдэвт сургалтыг Нээлттэй нийгэм хүрээлэнгийн Хуулийн хөтөлбөртэй хамтран амжилттай зохион байгууллаа. Хэдийгээр Хүний эрхийн форум НҮБ-ын хүний эрхийн механизмын тайлагнах журмыг үр нөлөөтэй ашиглах чиглэлээр зохих туршлага хуримтлуулсан хэдий ч хүний эрх зөрчигдсөн тодорхой асуудлаар гомдол гаргаж үзээгүй байна. Монгол Улсын тухайд ч 2019 оны 8-р сарын байдлаар НҮБ-ын Хүний эрхийн хороонд хандсан нэг гомдол л хүлээгдэж байна. Тиймээс зөвхөн Хүний эрхийн форум гэлтгүй манай улсад энэ чиглэлийн туршлага хангалтгүй байгаа тул бид сургалтад ХЭФ-ын гишүүн байгууллагын зэрэгцээ нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах чиглэлээр зохих туршлага хуримтлуулсан өмгөөлөгчдийг татан оролцуулсан билээ.

НҮБ-ын Арьс үндсээр ялгаварлан гадуурхах асуудал эрхэлсэн хороо Монголын Засгийн газрын 23, 24 дүгээр илтгэлийг хэлэлцэж буйтай холбогдуулан Хүний эрхийн форумаас мөн мэдээлэл илгээлээ. Үүний зэрэгцээ хүний эрхийг хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэхэд эрх зүйн орчин нэн чухал тул Хүний эрхийн хамгаалагчийн тухай, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулиудын төсөл боловсруулах, хууль батлах нөлөөллийн үйл явцад идэвхтэй оролцож ирлээ.

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМЫН ТҮРШЛАГЫГ ОЛОН УЛСЫН ХЭВЛЭЛД ОНЦОЛСОН НЬ



Aside from developing collaboration between civil society actors through strategy workshops, CSOs should also consider the following, prior to the adoption of the Working Group Report to Geneva:

- **Lead your expertise on an issue or recommendation.** Contact your group to urge their support for your favoured recommendations and provide the year rationale so to why they should. By putting your own expertise behind recommendation you both enhance your recommendation and enhance your organisation's profile.
- **Don't try to reinvent the wheel.** Use whatever tools you find most effective that letters to ministers, public statements, media campaigns, or in-person with government officials.
- **Contact directly the States that made your preferred recommendations.** Encourage them to pressure your government into accepting the recommendations you find critical.

■ **Work with the media.** Translate technical language and publicise specific recommendations, as well as your suggested approach to follow-up. Media coverage help elaborate on the specific human rights concerns that the recommendation approved to address.

Mongolia
In Mongolia and Malawi, CSOs successfully advocated for the Government to accept an increased number of recommendations. In Mongolia, the Government eventually accepted 91% of the pending recommendations at the adoption thanks to CSOs advocacy work.

CSOs can bring the State to change its position on noted recommendations, especially those that are in line with international commitments and obligations. UPR thematic bodies concluding observations, before adoption at the HRC plenary session.


States under Review cannot reject UPR recommendations.
Contrary to what is often said, a State cannot tactically "reject" UPR recommendations. It can only indicate which recommendations "enjoy the State's support" and which ones are "noted". The only difference between the two is that when a State indicates that a recommendation enjoys its support, it makes a political commitment to implement that recommendation before the review. Nevertheless, the State can always decide to implement noted recommendations at a later stage. During the first UPR cycle, 39% of noted recommendations were implemented before the importance of maintaining a dialogue on noted recommendations with the State.¹¹

¹¹ Data available in UPR Info's beyond Prishtina publication.

...age them to pressure your government to find critical.

- **Work with the media.** Translate into recommendations, as well as your suggested approach to help elaborate on the specific human rights concerns supposed to address.

Mongolia
In Mongolia and Malawi, CSOs successfully advocated for the Government to accept an increased number of recommendations. In Mongolia, the Government eventually accepted 91% of the pending recommendations at the adoption thanks to CSOs advocacy work.



facilitator is a member of the Thai CSO Coalition for the UPR. The 23 thematic clusters that developed UPR advocacy fact sheets, cluster to work under the umbrella of the coalition. The workshop benefited greatly from one again interacting with representatives from the Malawi UPR coalition (COMAMNGO) and the Myanmar UPR coalition (Burma Myanmar UPR Forum). During the workshop, the coalition commenced the process of developing an implementation plan including SMART objectives to measure the implementation of recommendations, and an action strategy plan setting the activities CSOs can undertake to support the government on the implementation process. The coalition intends to present these suggestions to the government and subsequently to the High Commissioner in Charge for the administration of the UPR.

Lessons learnt

Fact sheets
The thematic advocacy sheets are one of the success stories of the Thai CSO Coalition for the UPR. Created with the support of UPR Info Asia, we picked up the idea when collaborating with the Mongolian Human Rights NGO Forum (MHRN Forum), which had already fact sheets on the occasion of the UPR 16th pre-session on Mongolia. The practice was replicated when we worked with the Burma/Myanmar UPR Forum and their fact sheets were widely used in-country pre-session on Myanmar, Bangladesh, and Mongolia. CSOs in other countries including Malawi, Uganda and Thailand have also developed fact sheets to strengthen their advocacy activities.

Each of the 23 fact sheets offers an overview of what had been implemented on a particular issue since the previous UPR cycle. The fact sheets are intended to provide CSOs priority recommendations were highlighted in each sheet and aligned with inputs from Treaty Bodies and Special Procedures to illustrate that the recommendations are credible and legitimate.

The Ministry of Justice and Diplomacy has responded positively to the Thai CSO Coalition for the UPR and its partners for putting together the fact sheets. Proof of the quality of the work undertaken by the civil society, the Ministry of Foreign Affairs has subsequently encouraged CSOs to continue their work on the fact sheets.

...documents frequently to the diplomatic community in order to further demonstrate that the UPR is a credible UPR stakeholder.

Lessons learnt

a. Factsheets
The thematic advocacy sheets are one of the success stories of the Thai CSOs Coalition for the UPR. Created with the support of UPR Info Asia, we picked up the idea when collaborating with the Mongolian Human Rights NGO Forum (MHRN Forum), which used brilliant factsheets on the occasion of the UPR 16th pre-session on Mongolia. The practice was replicated when we worked with the Burma/Myanmar UPR Forum and their fact sheets were widely used in-country pre-session on Myanmar, Bangladesh, and Mongolia.

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, МЭДЛЭГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ

ННФ-аас зохион байгуулдаг хүний эрхийн боловсрол, мэдлэг түгээн дэлгэрүүлэх болон нийгэмд өрнөж буй хүний эрхийн “халуун” сэдвээр өрнүүлдэг хэлэлцүүлэг тогтмолжиж, агуулга болон хамрах хүрээ нь өргөжиж байна. Бид хүний эрхийн асуудлыг олон талаас авч үзэхийг зорихын зэрэгцээ, асуудалд хамаарах бүх талыг хэлэлцүүлэгт татан оролцуулахыг хичээдэг. Тухайлбал, өнгөрсөн онд мансууруулах бодисын хэрэглээ, тулгамдсан асуудал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ба нийгмийн хандлага, цахим орчин дахь хүний эрхийн зөрчлүүд, урьдчилан сэргийлэх арга зам,

залуучуудын оролцоо, нийгэм дэх байр суурь, хог баялаг болох нь зэрэг нийгэмд тулгамдаж буй сэдвээр ярилцлаа. Үүний зэрэгцээ, цаазаар авах ялыг халах, сонгуулийн эрх, ардчиллын үнэт зүйлсийг хөндсөн сэдвээр кино хэлэлцүүлгийг иргэд, иргэний нийгмийнхэн, оюутан залуусын дунд өрнүүллээ. Монголын Эмнести интернэшнл ТББ-тай хамтран их дээд сургуулиуд дээр очиж кино хэлэлцүүлэг зохион байгуулсан нь хүний эрхийн болон ардчиллын боловсролыг түгээх, оюутан залуусыг энэ үйл ажиллагаанд татан оролцуулахад ач холбогдолтой байлаа.

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛСЭН ТУХАЙ

Нэгдсэн Үндэстний Байгууллага нь “Хүний эрх, эрх чөлөөг дээдлэн сахих нь бүх нийтийн аюулгүй байдал, энх тайвны үндэс” болохыг тунхаглаж, НҮБ-ын Ерөнхий Ассамблей Хүний эрхийн түгээмэл тунхаглал хэмээх түүхэн чухал баримт бичгийг 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталснаас хойш жил бүрийн энэ өдрийг “Хүний эрхийн өдөр” хэмээн дэлхий нийтээрээ тэмдэглэдэг уламжлал тогтсон билээ. ХЭФ нь 2014 оноос эхлэн хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан Сүхбаатарын талбайд тайван жагсаал зохион байгуулж ирсэн туршлагатай.

2019 оны тухайд “Эрхийнхээ төлөө нэгдэцгээе!” уриан доор Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран тэмдэглэсэн бөгөөд НҮБ-ын хүний эрхийн үндсэн баримт бичигт тооцогддог Иргэний улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактыг Монгол Улс соёрхон баталсны 45 жилийн ойг тохиолдуулан илүү өргөн хүрээнд тэмдэглэхийг зорилоо. Үүний тулд 21 аймагт хандан эрхийнхээ төлөө нэгдэхийг уриалахын зэрэгцээ 12 сарын 9 буюу Хүний эрхийн хамгаалагчийн өдрөөр “Бидний

эрх-Хүний эрх” сэдэвт мэдээллийн зах ажиллуулж, ХЭФ-аас НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд илгээсэн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд танилцууллаа. ХЭФ, ХЭҮК-ын уриалгыг дэмжиж Архангай, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Завхан, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс аймгийн ХЭҮК-ын ажилтнууд төр, төрийн бус байгууллагатайгаа хамтран “Эрхийнхээ төлөө нэгдэцгээе!” уриан доор хүний эрхийн асуудлаар зөвлөгөө өгөх, Хүний эрхийн хамгаалагчийн тухай хуулийн хэлэлцүүлэг зохион байгуулах, радио, телевизээр нэвтрүүлэг цацаж, албан байгууллагууд дээр өдөрлөг зохион байгуулж ажилласан нь ач холбогдолтой байв.

Хүний эрхийн олон улсын өдөр Улсын дуурь бүжгийн эрдмийн театрт хүний эрхийн сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах, жүжгийн хэсгээс тоглуулах, хүний эрхийн хамгаалагчдын түүхийг сонсох, хүний эрхийн сэдэвт богино видеог танилцуулахын зэрэгцээ үүдний танхимд төрөл бүрийн мэдээлэл, зөвлөгөө авах боломжийг олгож, гадаа талбайд хүний эрхийн үзэсгэлэн зохион байгуулснаараа

онцлогтой байлаа. “Эрхийнхээ төлөө нэгдэцгээе!” өдөрлөгийн нээлтэд Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийндэхорооны дарга Н.Оюундарь, НҮБ-ын суурин төлөөлөгч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Суурин зохицуулагч Тапан Мишра, зохион байгуулагчдыг төлөөлж ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж, ХЭФ-аас Глоб интернэшнл төв ТББ-ын Тэргүүн Х.Наранжаргал нар үг хэллээ. Өдөрлөгийг дохионы хэлмэрчтэй явуулсан нь сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангахад чухал ач холбогдолтой байлаа. Тус өдөрлөг 3 цагийн түрш үргэлжилсэн бөгөөд Монголын үндэсний олон нийтийн телевизийн 1-р сувгаар бүрэн эхээрээ цацагдсан юм.

Өдөрлөгийн үеэр байгаль хамгаалагч, малчин, оюутан, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй, бизнес эрхлэгч зэрэг төрөл бүрийн ажил мэргэжил, нас насны төлөөлөл болсон хүний эрхийн 5 хамгаалагч өөрсдийн түүхийг хуваалцсан нь хүн бүрт эрхийнхээ төлөө тэмцэх үүргийг сануулж, тэмцэх урам зоригийг бадраасан билээ. Мөн Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар хүний эрхийн сэдвээр бэлтгэсэн “Би эрүүдэн шүүхийн эсрэг”, “Явган зорчигчийн эрх зөрчигдсөөр”, “Орхидогсод ба Төрийн бодлого” сэдэвт богино видеог ирсэн зочдод үзүүлээ.



“Эрхийнхээ төлөө нэгдэцгээе” өдөрлөгийн үеэр ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан телевизийн ярилцлага өгч бу нь, 2019 оны 12-р сарын 10-ны өдөр

Үзэгчдэд богино хугацаанд тодорхой мессэж хүргэж чадсан нь тус богино хэмжээний видеог бүтээх шалтгаан байсан билээ. Түүнчлэн хүний эрхийн төлөө зөвхөн үг хэлж, үзэг цаас нийлүүлэх бус



“Эрхийнхээ төлөө нэгдэцгээе” өдөрлөгийг УИХ-ын гишүүн Н.Оюундарь нээж үг хэллээ, 2019 оны 12-р сарын 10-ны өдөр



"Эрхийнхээ төлөө нэгдэцгээе" өдөрлөгийн үеэр зохион байгуулсан зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа, 2019 оны 12-р сарын 10-ны өдөр

урлагаар дамжуулан тэмцэх боломжтой болохыг "Ус-Чандмань Эрдэнэ" жүжгийн уран бүтээлчид толилуулж, бидэнд өдрөөс өдөрт нөөц нь багасаж буй усаа гамнахыг сануулсан юм.

Өдөрлөгийн бас нэг онцлог хэсэг бол хүний эрхийн салбар хэлэлцүүлэг байсан бөгөөд МУГЗ, найруулагч Б.Мөнхдорж, Дундговь аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоож, "Ид шидийн орон" төслийн зохицуулагч У.Ганбаяр, Чойжин ламын сүм музейн захирал Д.Отгонсүрэн, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогт, Оюу толгой хяналт ТББ-ын Тэргүүн Д.Сүхгэрэл нар зочноор уригдан оролцож, уг хэлэлцүүлгийг ННФ-ын Хуулийн хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан хөтлөн явуулсан юм.

Уг хэлэлцүүлгээр төр, төрийн бус байгууллага, урлаг, бизнесийн салбарт ажиллаж буй төрөл бүрийн ажил мэргэжлийн хүмүүсийн хүний эрхийг хөхиүлэх, хангах, хамгаалахад оруулж буй хувь нэмрийг тодотгосноороо хүний эрхийг хангах, хамгаалах үйлсэд хүн бүрийн хүчин зүтгэл чухал болохыг батлан харуулсан юм.

Өдөрлөгийн үйл ажиллагаанд 430 орчим хүн оролцож, 360 орчим хүн хууль, сэтгэлзүйн зөвлөгөө туслалцаа авсан бол гадаа талбайд гарсан үзэсгэлэнг 120 гаруй хүн үзэж сонирхсон байна. Тус өдөрлөгийг угтан нийгмийн сүлжээгээр явуулсан мэдээ, мэдээлэлтэй 200 мянга орчим хүн танилцсан нь хүний эрхийг түгээхэд онцгой ач холбогдолтой байлаа.

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Хүний эрхийн Форум сар тутам хуралдав.
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд тайлан илгээх чиглэлээр ХЭФ-ын гишүүд 4 багт хуваагдан 2018 оны 12 дугаар сараас 2019 оны 9 дүгээр сарын хугацаанд ажиллалаа.
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн III циклд тайлан илгээх зорилгоор 21 аймаг, нийслэлд 1000 орчим хүмүүстэй цуврал хэлэлцүүлгийг 4-6 дугаар сард зохион байгууллаа.
- НҮБ-ын Арьс үндсээр ялгаварлан гадуурхах асуудал эрхэлсэн хороо Монголын Засгийн газрын 23, 24 дүгээр илтгэлийг хэлэлцэж буйтай холбогдуулан Хүний эрхийн форум мэдээлэл илгээлээ.
- Эдийн засаг, нийгэм, соёл, иргэний, улс төр, бүлгийн эрхийн чиглэлээр ХНХЯ, ХЗДХЯ, харьяа агентлагуудтай тус бүр 5-7 дугаар сард зөвлөлдсөн бол нийт илгээх тайланг танилцуулах үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2019 оны 8 дугаар сард зохион байгууллаа.
- Хүний эрхийн форумын гишүүн байгууллага, өмгөөлөгчдөд зориулсан “НҮБ-ын хувь хүний гомдлын механизмыг үр нөлөөтэй ашиглах нь” сэдэвт сургалтыг ННХ-ийн Хуулийн хөтөлбөртэй хамтран 8 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгууллаа.
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн III циклд илгээх тайланг хэлэлцүүлэх Үндэсний зөвлөлдөх уулзалтыг ГХЯ-ны Зөвшилцөл танхимд 8 дугаар сарын 28-ны өдөр зохион байгууллаа.
- НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн III циклд илгээсэн тайланг олон нийтэд танилцуулах зорилгоор “Мэдээллийн зах”-ыг Blue Mon Галларейд хүний эрхийг хамгаалагчдын олон улсын өдөр буюу 12 дугаар 9-ний өдөр зохион байгууллаа.
- “Эрхийнхээ төлөө нэгдэцгээе” өдөрлөгийг ХЭФ нь ХЭҮК-той хамтран Хүний эрхийн олон улсын өдөр буюу 12 дугаар сарын 10-ны өдөр Улсын дуурь бүжгийн эрдмийн театрт зохион байгууллаа.



"НҮБ-ын хүний эрхийн механизм", сургалт, 2019 оны 7-р сар

“ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ЯРИЛЦЪЯ” ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ

- “Залуучуудын оролцоо, нийгэм дэх байр суурь”, зочин: Лантуун дохио ТББ-ын Тэргүүн, “Ид шидийн орон”-г үүсгэн байгуулагч Ч.Ганжавхлан
- “Цахим орчин дахь хүний эрхийн зөрчлүүд, урьдчилан сэргийлэх арга зам”, зочин: Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, Цагдаагийн ахмад Д.Эрдэнэбулган
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх ба Нийгмийн хандлага”, зочин: ХБХХЕГ-ын дарга Ц.Ганчимэг, Хүний эрхийн эксперт, доктор Г.Нарантуяа
- Агаарын бохирдол ба эх, хүүхдийн эрүүл мэнд, Үндэсний сүлжээний ерөнхий зохицуулагч, жендерийн үндэсний шинжээч Д.Энхжаргал
- ЛГБТИ Хүмүүсийн эрх ба эрүүгийн эрх зүйн орчин, Нийслэлийн цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Э.Баярбаясгалан, ЛГБТ Төв ТББ-ын эрх зүйн хөтөлбөрийн менежер А.Балдангомбо
- Насанд хүрээгүй хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан, нөхцөл, Улсын Прокурорын Ерөнхий газрын Сургалт, судалгааны төвийн ахлах прокурор, хууль зүйн ухааны доктор Б.Өнөрмаа
- “Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн хэрэглээ, түлгамдсан асуудал”, ЦЕГ-ын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх газрын эрүүгийн ахлах мөрдөгч, Цагдаагийн хошууч Б.Мандухай
- Мансууруулах бодисоос хамаарал бүхий иргэдэд үзүүлэх тусламж, Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Цагдаагийн ерөнхий газар, Иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт - Ардчиллын баталгаа, МУИС-ийн ХЗС-ийн доктор, профессор О.Мөнхсайхан
- Хотын хөгжил ба Орхигдсон хүмүүс, “Дахин төлөвлөлт-Иргэдийн оролцоо” ТББ-уудын нэгдсэн холбооны тэргүүн Б.Нямжав, УЗГ М.Мөнхцэцэг, П.Давааням
- Хог биш баялаг, Zero Waste Mongolia ТББ, “Гялгар уутгүй Монгол хөдөлгөөн”-ийг санаачлагч, үүсгэн байгуулагч, сэтгүүлч М.Бүжинлхам



Хүний эрхийн богино хэмжээний кино хэлэлцүүлэг, 2019 оны 9-р сар



“ЭРЭЛХЭГ САХИУСАН ТЭНГЭРҮҮД”

Эмэгтэйчүүдийн сонгуульд оролцох эрхийн төлөө өөрсдийн амь насаа эрсдэлд оруулан байж хөдөлгөөн өрнүүлж буй зоримог залуухан эмэгтэйчүүдийн тэмцлийг харуулсан “Төмөр хошуут сахиусан тэнгэрүүд” хэмээх сэтгэл хөдөлгөм ая, нүд сэргээм өнгө будаг, явдаг камер зэргийг ашигласан Катя Вон Гарниерын уг бүтээл нь тухайн үеийн киноны талаарх ойлголтыг бүрмөсөн өөрчилж, орчин үеийн өнгө аястай болгож өгсөн. Залуухан идэвхтнүүдийн зоримог, тэмцэгч шинж чанар ахмад үеийн хуучинсаг эмэгтэйчүүдийн зан төрхөөс эрс ялгаатай байсан юм. Тэд эмэгтэйчүүдэд сонгуулийн эрх олгохын тулд хоригдож, эрүүдэн шүүгдсэн ч зорилгоосоо ухарч няцаагүй юм. Гол дүрүүдэд: Хилари Свенк, Франсе О’Конор, Жулиа Ормонд, Моли Паркер, Лора Фазер, Брүүк Смиф, Вера Фармига, Луйз Смиф, Марго Матиндале, Анжелика Хюстен
 Найруулагч: Katja von Garnier



iCinema кино театр, МУИС, ҮБХИС, ДХИС



“БАЯРТАЙ БАФАНА”

Найруулагч Билле Август. Гол дүрдүүдэд Жосеф Финнес, Денис Хаясберт, Дианна Кругер. Энэхүү киног 2007 онд бодит амьдралаас сэдэвлэн бүтээсэн бөгөөд энэхүү кинонд Нельсон Мандела, түүнийг харгалзагч, шоронгийн хамгаалагч нарын хоорондох харилцааны талаар өгүүлжээ. Залуу хувьсгалч Нельсон Манделагийн хоригдож байсан Роббен арлын шоронд хянагчаар Жеймс Грегори ажиллахаар ирэх бөгөөд тэрээр үугуул иргэдийн коса хэл мэддэг учраас Нельсон Манделагийн захидал, уулзалтыг хянах даалгаврыг авч ажиллахаар болно.

МУБИС, Соёл Эрдэм Дээд сургууль



“ЖИНХЭНЭ ГЭМТ ХЭРЭГ”

Найруулагч Клинт Иствуд, Гол дүрдүүдэд Клинт Иствуд, Исаяя Вашингтон, Лиза Гэй Хэмжилтон. “True Crime” буюу “Жинхэнэ гэмт хэрэг” киног үзүүлэхээр бэлтгэсэн. Уг кинонд Стив Эверетт гэгч архинаас гарч буй Оакландын сэтгүүлч, хүн амины хэрэгт буруутгагдсан алуурчин Франк Бэчамаас ярилцлага авч нийтлэл бичих үүргийг хүлээн авах ба тэрээр ямар нэг зүйл буруу байгааг анзаарч батлахыг оролдох бөгөөд түүнд 12 цагийн хугацаа л байна.

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД КИНО ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



Амнести интернэшнлийн богино хэмжээний баримтат киногоос үзүүлэв.



iCinema кино театр



СЕЛЬМА

Найруулагч Авы Дюверней, кино зохиолыг бичсэн Пол Вэб, Гол дүрд Дэвид Оело, Кармен Эжого, Тим Роф

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН НИЙТИЙН ЛЕКЦ

- “Сонгогчийн эрхийг хамгаалах нь: Саад бэрхшээл, түүнийг даван туулах арга зам”, илтгэгч: МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, Улс төрийн шинжлэх ухааны доктор Э.Гэрэлт-од
- “Хүний эрх, хөгжлийн уялдаа”, илтгэгч: НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын Хүний эрхийн шинжээч, Б.Болорсайхан
- “Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нь”, илтгэгч: Чива Хисао, Япон Улсын Жайка ОУБ-ын Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл
- “Хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалахад хүний эрхийн үндэсний байгууллагын гүйцэтгэх үүрэг”, илтгэгч: НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын асуудлаарх тусгай илтгэгч Мишель Форст
- “Авлигатай тэмцэж хүний эрхийг дээдэлсэн сайн жишгүүд”, илтгэгч: Транспэрэнс интернэшнл Монгол ТББ-ын Гүйцэтгэх захирал О.Батбаяр
- “Хүний эрх ба Тогтвортой хөгжлийн хөтөлбөр – 2030”, илтгэгч: НҮБХХ-ийн суурин зохицуулагч Биата Транкман



ХЭВЛЭН НИЙТЛЭЛ: ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ИЛТГЭЛ



”

1999 - 2015 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, гүтгэлэг доромжлолтой холбоотой шүүхээр иргэний **665** хэрэг /үүний **363** нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой/ шийдвэрлэжээ.

“Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2015,” 21.

”

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг бие даасан судалгаа, мониторингийн үр дүнгээр хангахын зэрэгцээ, шинэ эрх зүйн орчинд ажиллах эрх зүйн соёлыг төлөвшүүлэх, хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах шатанд иргэний нийгмийн санал бодлыг нэгтгэн хүргэхийг зорьж ирсэн. Өнгөрсөн оны тухайд эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, болзошгүй ухралтаас сэргийлэхэд гол анхаарлаа хандууллаа.

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ҮЙЛ ЯВЦАД ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГАД ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ НЬ

Эрх зүйн шинэ орчныг иргэний нийгэмд таниулах, энэхүү шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд иргэний нийгмийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор эхлүүлсэн “Хуулийн хэлэлцүүлэг”-ийг үргэлжлүүлэн зохион байгууллаа. Гэхдээ цаг үеийн үйл явдалд үзүүлэх хариу үйлдлийг түргэсгэх, хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх зорилгоор тус арга хэрэгслийг түлхүү ашиглалаа. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүсэлтээр 2016 онд УИХ-аас баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхдээ тус арга хэрэгслийг ашигласан бөгөөд үр дүнг “Хуулийн шүүмж”-ийн ээлжит дугаарт нийтлүүлээ.

Бид эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, болзошгүй үхралтаас сэргийлэхэд байнгын анхаарал хандуулж ирсэн. Тухайлбал, Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн “Монгол Улсад эрүү шүүлт бодитой оршсоныг зарлаж, албан ёсоор уучлалт гүйсэн” мэдэгдэлтэй холбогдуулан эрүүдэн шүүхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчны үнэлгээг хуулийн хэлэлцүүлгээр хийлээ. Энэ нь тал талын мэргэжилтнүүдийн оролцоотой цогц үнэлгээг богино хугацаанд гаргахад чухал ач холбогдолтой байдаг. Тус хэлэлцүүлгийн дүнг “Бодлогын асуудал” цувралд нийтлүүлж, МХХ-ноос жил бүр зохион байгуулдаг Хуульчдын форумын оролцогчдод болон УИХ-ын Хүний эрхийн дэд хорооноос эрүүдэн шүүхийн хохирогчдын эрхийн асуудлаар зохион байгуулсан хуралдаанд хэлэлцүүлэх материал болгон түгээлээ. Ингэснээр тодорхой үйл явдалд шуурхай хариу үзүүлэхийн зэрэгцээ эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж байгаа билээ.

Шинэ эрх зүйн орчинд ажиллах хуульчид, хууль сахиулагчдын эрх зүйн соёлыг төлөвшүүлэхэд зохих хувь нэмэр оруулахыг зорьж ХЗДХЯ, МХХ-той харилцан ойлголцлын санамж бичиг

байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд хуульчид, хууль сахиулагчдад зориулсан шинэ эрүүгийн хууль тогтоомжийн талаар сургалтын хөтөлбөр боловсруулах ажил багтсан юм. Сургалтын хөтөлбөрийн эхний төсөл бэлэн болсон тул сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг ХЗДХЯ-тай хамтран зохион байгуулж 2019 оны байдлаар нийт 43 багш бэлтгээд байна. УИХ-аар эрүүгийн хууль тогтоомжид оруулах нэмэлт өөрчлөлтийг баталсны дараагаар тус хөтөлбөрийг эцэслэж, сургагч багш нараар дамжуулан түршилтын сургалт явуулахаар төлөвлөлөө. Эрх зүйн соёлыг төлөвшүүлэх нь гагцхүү хууль тогтоомжийн талаар хангалттай сайн мэдлэгтэй байснаар хязгаарлагдахгүй тул зарим алба хаагчдын ёс зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ЦЕГ-тай тохиролцсоны дагуу “Цагдаагийн алба хаагчид зориулсан ёс зүйн сургалтын хөтөлбөр” боловсруулах ажлыг эхлүүлж, эхний түршилтын сургалт Сэлэнгэ аймгийн цагдаагийн бие бүрэлдэхүүнийг оролцуулан хийгдлээ. Сургалтын үеэр арга зүйчээр хөндлөнгийн үнэлгээг хийлгэсэн бөгөөд үүнд тулгуурлан хөтөлбөрийг эцэслэн боловсруулж ЦЕГ-т хүлээлгэн өгөх юм. Мөн хүнд ноцтой, шинэ тутам, үндэстэн дамнасан гэмт хэргийг илрүүлэхэд гаднын улс орны түршлагаас суралцах нь зайлшгүй тул ЦЕГ-ын хоёр ажилтанд АНУ, Канад Улсад зохион байгуулагддаг кибер гэмт хэрэгтэй тэмцэх, гүйцэтгэх ажлын талаарх олон улсад нэр хүндтэй сургалтад суух тэтгэлэг олголоо. Тус тэтгэлэгт хамрагдсан ажилтнууд буцаж ирээд бусдадаа мэдлэг, түршлагаа түгээх юм.

Эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд ННФ-ын оруулж буй нэг хувь нэмэр бол бодлогын судалгааг дэмжиж буй явдал билээ. Бид өнгөрсөн онд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, өршөөлийн хуулиудад хийх дүн шинжилгээ, нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт, хорихоос суллагдсан этгээдэд



"Хуульчдын форум 2019", нээлтийн үйл ажиллагаа, 2019 оны 6-р сар

тавих захиргааны хяналт, бага насны хүүхдийг алах, хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдал, гэрч хохирогчийн хамгаалалт, хорих ялыг дүйцүүлэн хасах жишиг зэрэг сэдвээр бодлогын судалгаа хийлгэлээ. Эдгээр судалгаа нь эрх зүйн шинэчлэлийн зарим бодлогыг үнэлж, маргаан бүхий зарим асуултад хариулт өгч, төрийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд түлхэц болохуйц үр дүнг олон нийтэд тодорхой арга зүйд түлгүүрлан, нотолгоо, дүгнэлттэй танилцуулж байгаагаараа ач холбогдолтой. Нөгөө талаас шинэчлэлийг бүрүүшаах, хуучин зохицуулалтыг шаардах, эсхүл хэрхэн хэрэгжүүлэх арга замаа олоогүй байгаа зэрэг хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд зохих үр дүнгээ өгнө хэмээн найдаж байна. Цаашид судалгаанд тулгүүрлан цуврал хэлэлцүүлэг хийх замаар судалгааны үр дүнг хэрэглээнд оруулж, эрх зүйн шинэчлэлд авч хэрэглэх эх сурвалж болгохоор тодорхой ажлууд төлөвлөөд явж байна.

Судалгаа, дүн шинжилгээнд тулгүүрласан эрх зүйн шинэчлэл үр дүнтэй, тогтвортой явагдана хэмээн үздэг тул "Гэмт хэргийн цагаан ном"

судалгааны ажлыг анхнаас нь дэмжиж Монголын криминологчдын холбоонд 2017 оноос тэтгэлэг олгож ирсэн бөгөөд энэ хугацаанд "Гэмт хэргийн цагаан ном" 2016, 2017, 2018 цувралууд гарлаа. Гэмт хэргийн цагаан ном жилээс жилд чанаржиж, агуулга, хүрээ тэлж байгаа нь Монгол Улсын гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг бодитоор үнэлж, цаашлаад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх оновчтой бодлого тодорхойлоход чухал түлхэц болохын зэрэгцээ олон улсын түвшинд бусад улс оронтой харьцуулагдах, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг амлалтыг бодитой дүгнэх боломжийг олгож байна. Гурван жилийн хугацаанд энэ судалгааг гүйцэтгэх арга зүй боловсруулагдсаны зэрэгцээ, ХЗДХЯ-ны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл энэ ажлыг хариуцахаар болсон нь цаашид энэ бүтээгдэхүүн тогтвортой гарах боломжийг бүрдүүллээ.

Тус хөтөлбөрөөс энэ онд шинээр танилцуулсан нэг арга хэрэгсэл бол эрх зүйн шинэчлэлийн маргаантай асуудлаар өөр өөр үзэл бодлыг хэлэлцэн мэтгэлцэх "Үзэл бодол" хэлэлцүүлэг юм. Нийгэмд өрнөж буй



"Гэмт хэргийн цагаан ном 2018"-ын танилцуулгын арга хэмжээнд оролцогчид, 2019 оны 12-р сар

эрх зүйн шинэчлэл, бодлогын шийдлийн сонголтод иргэдийн бодит оролцоог хангахад мэдээллийн дутмаг байдал гол саад тогтор болдог билээ. Бидний хэлэлцүүлгийн зорилго нь тодорхой маргаан бүхий асуудлаар эсрэг тэсрэг үзэл бодлуудыг уралдуулах замаар тухайн асуудалтай гүнзгий танилцах, үүнд түлгүүрлан өөрийн үзэл бодлоо цэгцлэх, улмаар шийдлийн талаар саналаа хуваалцах боломжийг оролцогч, үзэгчдэд олгоход чиглэдэг. Монгол Улсад өрнөж буй олон өөрчлөлт шинэчлэл, түүний үр дагаврын талаар иргэд, олон нийт сайн ойлголт мэдээлэлгүй байх нь түгээмэл байгаа үед асуудлыг олон талаас нь дүгнэж цэгнэсэн, мэргэжилтнүүдийн байр суурийг сонсох энэ мэт үйл ажиллагаа чухал ач холбогдолтой хэмээн үзэж МХХ-той хамтран цувралаар зохион байгуулж эхэллээ. Өнгөрсөн хугацаанд "Гүтгэлэг гэмт хэрэг мөн үү", "Шүүхээс эрүүгийн хэргийг буцаах нь буруу" зэрэг сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулаад байна. Энэ нь зөвхөн танхимд хэлэлцээд өнгөрөх биш, түс хэлэлцүүлгийн бүтэн бичлэгийг цахимд байршуулж, гол үр дүнг нэгтгэн "Чухал сэдэв" цувралд нийтэлдэг цогц үйл ажиллагаа билээ.

Тиймээс "Үзэл бодол" хэлэлцүүлэг нь эрх зүйн шинэчлэлд түлгарч буй асуудлыг шийдвэрлэхэд зохих хувь нэмэр болно хэмээн найдаж буй.



"Шүүхээс эрүүгийн хэргийг буцаах нь буруу",
Үзэл бодол хэлэлцүүлгийн явц, 2019 оны 6-р сар

ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН МЭДЛЭГ, МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ

ННФ нь 2014 онд “Театр хүний эрхийн төлөө” төслийн хүрээнд Глоб интернэшнл ТББ болон УДЭТ-тай хамтран “тавилттай уншлага” хэмээх үзвэрийн шинэ төрлийг мэргэжлийн театр, мэргэжилтнүүд болон зохиолчдод танилцуулж эхэлсэн билээ. Энэ хүрээнд өнгөрсөн онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэлэг зохицуулалтыг олон нийтэд танилцуулах зорилгоор бичсэн “Хуулийн өмнө”, “Наран цамхгийн хэрэг”, “Манаач” бэсрэг жүжгийг УДЭТ, Глоб интернэшнл ТББ-тай хамтран УДЭТ-ын тайзнаа тоглуулсан бол энэ онд эдгээр жүжгийг илүү олон хүнд хүргэх зорилгоор Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран дэлгэцийн бүтээл болгож, тус телевизээр давтамжтай цацаад

байна. Тус бүтээл нь МҮОНТ-ийн алтан фондод хадгалагдсан тул цаашид ч цацагдсаар байх юм. Үүний зэрэгцээ цахим хуудсанд байршуулах замаар илүү олон хүнд хүргэхийг зорилоо.

Мөн цаг үеийн чухал асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлж, олон нийтийг илүү тодорхой мэдээллээр хангахыг хичээж ажиллалаа. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт хэлэлцэгдэж байгаатай холбогдуулан УИХ-ын Дэд ажлын хэсгийн гишүүн, Доктор О.Мөнхсайханыг урьж “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт ардчиллын баталгаа болох нь” сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж, видео бичлэгийг цахим хуудаснаа байршуулсан юм.

МОНИТОРИНГ

ННФ-ын хувьд төрийн үйлчилгээнд мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжиж, ажилладаг чиглэлээр нь чадавхжуулж ирсэн нь төрийн бус байгууллагыг үйл ажиллагааных нь хувьд бэхжүүлэх чухал хөтөлбөр болдог. Хууль сахиулах ажиллагаанд мониторинг хийх чиглэлээр ТББ-ыг чадавхжуулах ажлыг 2014 оноос эхлүүлсэн бөгөөд эдүгээ хот хөдөөгийн 300 орчим ТББ сургалтад хамрагдаж, 100 гаруй ТББ нь том, жижиг мониторинг хийгээд байна. Өнгөрсөн оны тухайд бид мониторингийн сэдвийг илүү нарийвчилж, гүнзгийрүүлсний улмаас ТББ-аас илүү мэдлэг, үр чадвар шаардагдах болсон тул мониторингийн багуудад ментор ажиллуулах замаар чадавхжуулахад анхаарч ажиллалаа.

Энэ онд хэрэгсэхгүй болсон эрүүгийн хэрэгт дүн шинжилгээ хийх, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, авлигын гэмт хэргийн илрүүлэлт, хариуцлага хүлээлгэж буй байдал, нийтийн хэв журмыг сахиулах

үйл ажиллагаа, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтын зохион байгуулалт, хорихоос суллагдсан хүнд тавьж буй захиргааны хяналт, хүүхэд хохирогчтой гэмт хэрэг, зөрчлийн гомдол мэдээллийн шийдвэрлэлт сэдвийн хүрээнд нийт 10 мониторингийн тэтгэлэг өгөөд байна. Зарим мониторингийн үр дүнг олон нийтэд танилцуулах ажлыг эхлүүллээ.

Мөн энэ оны эхний улиралд нийслэл, 17 аймгийн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, иргэд оршин суугчдад ажлаа тайлагнах үйл явцад нэгдсэн удирдамжаар мониторинг гүйцэтгүүлж, үр дүнг нэгтгэн олон нийтэд хүргэлээ. Цаашид цагдаагийн байгууллагын шинэчлэлийн нэг гол үзэл баримтлал болох олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг бэхжүүлэхэд мониторингийн үр дүн чухал ач холбогдолтой. Мониторингийн дэлгэрэнгүй үр дүнг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.



Сэлэнгэ аймагт зохион байгуулсан "Цагдаагийн алба хаагчийн ёс зүй" сургалт, 2019 оны 12-р сар

- “Цагдаагийн албаны үйл ажиллагааны ил тод байдал, цагдаагийн байгууллагын олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа” сэдвийн хүрээнд нийслэл, 17 аймагт мониторинг хийлээ.
- “Театр хүний эрхийн төлөө 2019” үйл ажиллагааны хүрээнд Глоб интернэшнл төв ТББ, УДЭТ, МҮОНТ-тэй хамтран Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай шинэ хуулийн хүрээнд бичсэн “Наран цамхгийн хэрэг”, “Манаач”, “Хуулийн өмнө” бэсрэг жүжгийг дэлгэцийн бүтээл болгож, МҮОНТ-ээр цацлаа.
- “Эрүүдэн шүүхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх” хэлэлцүүлгийг МХХ, ХЭҮК, Монголын эмнести интернэшнл ТББ-тай хамтран зохион байгууллаа.
- Монголын хуульчдын форумын үеэр “Эрүүдэн шүүхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин” сэдвээр салбар хуралдаан зохион байгууллаа.
- “Гүтгэлэг гэмт хэрэг мөн үү”, “Шүүхээс эрүүгийн хэргийг буцаах нь бүрүү” сэдэвт “Үзэл бодол” цуврал хэлэлцүүлгийг 4, 5 дугаар сард зохион байгууллаа.
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт” хэлэлцүүлгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон холбогдох төрийн байгууллагын оролцоотой зохион байгууллаа.
- “Монгол Улс дах гэмт хэргийн цагаан ном-2018” практик хэрэглээ хэлэлцүүлэг хийнэ.
- “Эрүүгийн шинэ хууль тогтоомжийн хүрээнд сургагч багш бэлтгэх сургалт”-ыг ХЗДХЯ-тай хамтран зохион байгууллаа.
- “Цагдаагийн алба хаагчид зориулсан ёс зүйн сургалт”-ын хөтөлбөрийг түрших сургалтыг ЦЕГ-тай хамтран Сэлэнгэ аймгийн цагдаагийн бие бүрэлдэхүүнд зохион байгууллаа.

ХЭВЛЭН НИЙТЛЭЛ:

"МОНИТОР" ЦУВРАЛ



"ХУУЛИЙН ШҮҮМЖ" ЦУВРАЛ



"БОДЛОГЫН АСУУДАЛ" ЦУВРАЛ



"ЧУХАЛ СЭДЭВ" ЦУВРАЛ



БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАНГУУД



Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (2018.06.22), 49.6

- Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн гишүүдийн гурвыг иргэдээс; гурвыг хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан эрдэмтдээс тус тус сонгон шалгаруулж УИХ-ын холбогдох байнгын хороо нэр дэвшүүлэн УИХ хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар томилно;
- Гурван шатны шүүхийн шүүгчдээс тус бүр дундаасаа нэгийг сонгоно;
- Шүүгчийн хариуцлагын зөвлөлийн даргыг гишүүн дотроосоо нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.



ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Монгол Улсын шүүх эрх мэдлийн хүрээнд 2019 он нэлээд донсолгоотой жил тохиолоо. 2019 оны 3 сарын 27-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн барьсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай болон бусад холбогдох хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл УИХ-аар батлагдсан нь шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх үйл хэрэгт сорилт учруулсан. Тус нэмэлт зохицуулалтын хүрээнд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарснаар шүүгч, прокурорыг албан тушаалаас аливаа бодит үндэслэлгүйгээр чөлөөлөх эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд Улсын дээд шүүхийн иргэний танхимын шүүгчдийг нэр бүхий шүүгчдийн хамт албан ажлаас нь түдгэлзүүлснээр иргэдийн шүүхэд хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх, давж заалдах эрх хэрэгжих боломжгүй 6 сар гаруй хугацааг үдсэн юм.

ҮНДСЭН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ БА НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэхүү хямрал тохиохтой зэрэгцэн 2 жилийн хугацаанд хэлэлцэж ирсэн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажил эхэлсэн нь органик хуулиар бий болсон хямралыг засах чухал боломжийг бүрдүүлсэн юм. УИХ-аас 2019 оны 11 сарын 14-

нд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд шүүхийн салбарыг тогтолцоо, засаглалын хувьд бэхжүүлэх дараах 3 зүйл батлагдсан нь шүүхийн шинэтгэлийн хувьд түүхэн үйл явдал боллоо.

ХУУЛИЙН ЗААЛТ

МУ-ын Үндсэн хуульд шүүхтэй холбоотой орсон нэмэлт өөрчлөлт:

...49.5 Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага томилох журмыг хуулиар тогтооно.

49.6 Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.

48.1 Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.



Хуульчдын Форум- 2019: Шүүгчийн томилгоо сэдэвт салбар хуралдааныг Оюуны-Инноваци ТББ-тай хамтран зохион байгууллаа.

ННФ нь Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн (ҮХНӨ)-ийн төсөл боловсруулах, хэлэлцэх үйл явцад иргэний нийгмийн байгууллагууд, судлаачидтай хамтран оролцож судалгаа шинжилгээ, нөлөөллийн дэмжлэг үзүүлж ажиллалаа. Бидний 2018 оноос эхлүүлсэн Сэтгүүлчдийн өглөөний үүлзалт, 2015 оноос эхлүүлсэн бодлогын судлаачдыг дэмжих, шүүх эрх мэдлийн хүрээнд бие даасан, хараат бус судалгааны ТББ-д байгууллагын дэмжлэг үзүүлж ажилласан нь энэ чухал цаг үед үр шимээ өгч судалгаа мэдээлэлд суурилсан өргөн хүрээний бодлогын хэлэлцүүлэг өрнөж чадлаа.

Оюуны-Инноваци эрх зүйн судалгааны байгууллагыг институтийн хувьд бэхжүүлж, шүүх эрх мэдлийн бодлогын асуудлаар хараат бус байр суурь илэрхийлэх дүү хоолой гаргаж ирэх зорилгоор 2018 онд тэтгэлэг олгон хамтран ажилласаар ирсэн нь энэ удаагийн амжилттай нөлөөллийн үйл ажиллагаанд үр дүнгээ өглөө. Иймээс цаашид нөлөөллийн үйл ажиллагаагаа идэвхтэй явуулах, санхүүжилтийн олон талт эх үүсвэр бий болгоход нь дэмжлэг болох үүднээс 2 жилийн хугацаатай байгууллагын хөгжлийн тэтгэлэг олгоод байна.

БОДЛОГЫН СУДАЛГАА БА ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

Хөтөлбөрийн нэгэн чухал зорилт нь шүүх эрх мэдлийн хүрээнд судалгаа шинжилгээг хөгжүүлэх явдал бөгөөд бодлогын судалгааны хажуугаар шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээг хөгжүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна.

2016 оноос эхлэн хэрэгжүүлсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний тэтгэлэгт төслийн үр нөлөөг үнэлж, цаашдын төлөвлөгөөг хэлэлцэх зорилгоор шүүхийн судалгааны чиглэлээр хамтран ажилладаг судлаачдын оролцоотой арга зүйн семинар зохион байгуулав.



Оюуны-Инноваци ТББ-ын судлаач хуульч Төрболд сэтгүүлчдэд зориулсан мэдээлэл хийж байна.



www.legaldata.mn



contact@legaldata.mn



Oyuninnovatsi



+976-99137929



hutuch1



Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, оюутны гудамж
16/03, Unity center, 4 давхар 405 тоот

АЛСЫН ХАРАА:

Монгол Улсын хууль зүйн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, тэргүүлэгч байр суурьтай иргэний нийгмийн байгууллага болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Судалгаанд суурилсан, шинэ санаа, санаачилгыг дэвшүүлэх, нэвтрүүлэх замаар Монгол Улсын эрх зүйн хөгжлийг дэмжиж, шударга ёсыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулна.

ҮНЭТ ЗҮЙЛ, ЗАРЧИМ:

- Бие даасан байдлыг хангах;
- Хууль ёс, ёс зүйг баримтлах;
- Мэдлэг, чадварыг эрхэмлэх;

- Эрдмийн эрх чөлөөг хүндэтгэх;
- Бүтээлч, эвсэг, чадварлаг хамт олон.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- Эрх зүйн шүүмж судлалыг хөгжүүлэх;
- Хууль зүйн судалгааг дэмжих, хөгжүүлэх, судалгааны бүтээлийг түгээх;
- Эрх зүйн бодлогын академик болон хавсарсан судалгаа хийх;
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах;
- Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, үнэлгээ мониторинг хийх;
- Сургалт зохион байгуулах;
- Байгаль орчин, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч, хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах.



Шүүхийн судалгаа - Судлаачид, сэтгүүлчдийн уулзалт, 2019 оны 3 сар



Семинарын оролцогчид: ХЗС-ийн багш, хуульч судлаач нарын төлөөлөл, 2019.11.30

Үүний үр дүнд энэ төрлийн судалгааны ажлын хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байгаа төдийгүй арга зүйн хувьд зааглах боломжтойг бид олж харав.

Захиргааны гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх нь (Оюуны-Инноваци ТББ), Шүүхийн журмаар гэр бүл цуцлахад ипотекийн зээлийн барьцаанд байгаа хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хувааж буй шүүхийн практик (Эрх зүйн соёл ТББ), Газар өмчлөх, эзэмших эрхтэй холбоотой хэрэг, маргааныг хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдал (Эрх зүйн хөгжлийн төлөө ТББ), Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой маргааныг шийдвэрлэсэн байдал (судлаач Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар нар) зэрэг сэдвээрх шүүхийн шийдвэрүүдийн анализыг эмхэтгэл болгон хэвлэж олон нийтийн хүртээл болголоо (“Сэдвийн хүрээнд гарсан бүтээгдэхүүн” хэсгийг харна уу). Тэрчлэн, шинээр Байгаль орчин, байгаль орчны бохирдолтой холбоотой хэрэг маргааны шийдвэрлэлт болон Хяналтын шатны шүүх иргэний хэргийн шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцаасан үндэслэлийн талаарх шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийлээ. Эдгээр шинжилгээний эмхэтгэл мөн удахгүй хэвлэгдэн гарахаар бэлтгэгдэж байна.

Мөн түүнчлэн, цаашид хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллахад анхаарч байгаа тул шүүх хуралдааны ажиглалтын арга зүйг танилцуулах сургалт, семинарыг сэтгүүлчдийн дунд зохион байгууллаа. Үүний үр дүнд, 2020 онд олны анхаарал татсан хэрэг маргааныг хараат бусаар сурвалжилж иргэдэд шүүхэд хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хэвлэл мэдээллийн мониторинг хийх боломж бүрдэнэ гэж найдаж байна.



Сэтгүүлчдэд зориулсан "Шүүхийн ажиглалт"-ын танилцуулах сургалт, 2019 оны 11 сар

- Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх сэдэвт сэтгүүлчдийн уулзалт
- Хуульчдын форум-2019: Шүүгчийн томилгоо
- Сэтгүүлчдэд зориулсан шүүхийн ажиглалтын танилцуулах сургалт
- Шүүхийн салбарын судлаачдын семинар

ХЭВЛЭН НИЙТЛЭЛ: ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЭМХЭТГЭЛ



- Захиргааны гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх нь /Оюуны-Инноваци ТББ/
- Шүүхийн журмаар гэр бүл цуцлахад ипотекийн зээлийн барьцаанд байгаа хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хувааж буй шүүхийн практик / Эрх зүйн соёл ТББ/
- Газар өмчлөх, эзэмших эрхтэй холбоотой хэрэг, маргааныг хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдал /Эрх зүйн хөгжлийн төлөө ТББ/
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой маргааныг шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийх /Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар/



ТАНД ТУСЛАХ ЦАХИМ ХӨТӨЧ



WWW.E-KHUTUCH.MN

ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ САН

Иргэн бүрт эрх зүйн мэдлэгийг...



МЭДЭЭЛЛИЙН САМБАР

ТАНИЛЦУУЛГА



ХУУЛЬ ЗҮЙН
МЭДЭЭЛЭЛ



ХУУЛЬ ЗҮЙН
СУРТАЛЧИЛГАА



САНАЛ ХҮСЭЛТИЙН
ХАЙРЦАГ



ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Н ээлттэй Нийгэм Сангуудын олон улсын санаачилга, санхүүжилтийн хүрээнд 2016 онд эхлүүлсэн Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх төсөл 4 жилийн хугацаанд амжилттай хэрэгжиж дууслаа. Энэхүү төсөл нь аливаа бэрхшээл, ялгаатай байдлаасаа болон оршин амьдарч буй алслагдсан байршлаасаа хамаарч төрийн үйлчилгээ авч чадахгүй байгаа иргэдэд хууль зүйн суурь үйлчилгээг хүргэх албан ёсны тогтолцоо бий болгох зорилготой байв. Энэхүү төслийн хүрээнд иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэхдээ дараах нөхцөл байдлыг авч үзсэн юм.

Монгол Улсын иргэд, тэр дундаа алслагдсан хөдөө орон нутгийн иргэдэд хууль зүйн анхан шатны мэдээлэл үйлчилгээ хангалттай хүрч чадахгүй байгаа нь (i) одоогийн тогтолцоо,

зохион байгуулалт дээрээс доош буюу иргэдийн бодит хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгаа, (ii) хүргэж байгаа төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг, иргэдэд үйлчлэх арга зүй хангалтгүй (энэ нь төрийн албаны тогтворгүй байдалтай холбоотой), (iii) эрх зүйн мэдээллийг хүний эрхийн мэдрэмжгүй, жигд бус, иргэд хялбар ойлгоход нийцүүлэн хялбаршуулж хүргэдэггүйтэй холбоотой. Иймээс эрх зүйн ямарваа асуудал тулгарахад буюу хэрэгцээ шаардлага гарахад иргэд хэрэгцээт мэдээлэл, туслалцаа авах боломжтой сувгууд бий болгох замаар энэхүү тогтолцоог бий болгохыг зорьж Эрх зүйн цахим хөтөч боловсрууллаа.

2019 оны хувьд төслийн сүүлийн жил болохын хувьд өмнөх жилүүдийн ололт амжилтаа бэхжүүлэх, төслийн хүрээнд бий болгосон цахим хөтөч болон тусгайлан бэлтгэгдсэн эрх зүйн хөтөч хүмүүсээр дамжуулан анхан шатны эрх зүйн үйлчилгээг хүргэх үндэсний тогтолцоог тогтвортой хэрэгжүүлэх нь чухал байлаа.

БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Өнгөрсөн онд 2018 онд батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн эхний үе шатыг хэрэгжүүлэх чухал жил байв. ННФ-ын дэмжлэг санхүүжилтээр сонгон авсан аймаг орон нутагт эрх зүйн хөтчийн буланг нээж ажиллуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, Эрх зүйн хөтчийн сургалт зохион байгуулсан нь цаашид үндэсний хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд загвар туршлага

болсон гэж найдаж байна. Хэнтий, Сэлэнгэ аймагт нийт 118 эрх зүйн хөтөч бэлтгэгдэн ажиллаж эхлээд байгаа бөгөөд 2020 онд зүүн болон төвийн бүсийн 7 аймагт эрх зүйн хөтөч нарыг сурган ажиллуулахаар төлөвлөж байна. Бусад донор байгууллагуудын тусламжтай үлдсэн аймаг орон нутагт эрх зүйн хөтөч нарыг бэлдсэнээр 2020 оноос үндэсний хэмжээнд эрх зүйн хөтчийн бүрэн тогтолцоо бүхэлдээ ажиллаж эхлэх болно.



Хэнтий аймгийн ЗДТГ-ын дарга Ж.Ганбаатар Эрх зүйн хөтчийн булангийн нээлтэд үг хэлж байгаа нь. 2019 оны 7 сарын 3.



Хэнтий аймгийн Мөрөн суманд эрх зүйн хөтчийн буланг нээлээ. Энэ үеэр Хэнтий аймгийн бусад сумын төлөөлөл ирж эрх зүйн хөтчийн буланг хэрхэн тохижуулж, ажиллуулах талаар туршлага солилцсон юм. 2019 оны 12 сар.



Сэлэнгэ аймгийн Эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтын оролцогчид, 2019 оны 12 сар

ННФ нь Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй өнгөрсөн 3 жилийн хугацаанд хамтран ажилласны дүнд иргэдэд цаг хугацаа, зардал мөнгө хэмнэсэн нэгэн чухал үйлчилгээ болох эрх зүйн цахим хөтөч www.e-khutuch.mn-ийг бүтээлээ. 2016 онд хэрэгжүүлсэн Монгол Улсын иргэдийн эрх зүйн хэрэгцээ шаардлагын судалгаанд үндэслэн 20 гаруй сэдвээр иргэдэд ойлгоход хялбар, хууль ёсны агуулга боловсруулан үндэсний хэмжээнд хэрэглэхэд бэлэн болгож танилцуулсан нь энэхүү хөтөлбөрийн нэгэн том үр дүн байлаа. Цаашид энэ үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад түршлагатай, чадварлаг мэргэжилтнүүд тогтмол зөвлөгөө өгч, хэвийн ажиллуулах нь чухал юм. ННФ нь ХЗҮХ-нд 2020 оныг дуустал цахим хөтчийн техникийн хэвийн ажиллагааг хангахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэж өгөөд байна.



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал С.Энхцэцэг

ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ

Төлбөрийн чадвар хязгаарлагдмал болон газарзүйн хувьд алслагдмал нутаг орны иргэдийн онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн эрх зүйн мэдээлэл, үйлчилгээг алслагдсан, эмзэг бүлгийн иргэдтэй ажилладаг, тэдний төлөөлөл болсон, итгэлийг

нь даах иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан хүргэх нь үр дүнтэй ажээ. 2018 онд нийт 5 байгууллагад 1 жилийн хугацаатай эрх зүйн хөтчийн тэтгэлэг олгож хамтран ажилласан бөгөөд 2019 онд эдгээр төслийн үр нөлөөг үнэллээ.

Байгууллага	Зорилтот бүлэг	Орон нутаг	Эрх зүйн хөтчийн тоо
Гүнж төв	Залуу ээж, жирэмсэн эхчүүдэд эрүүл мэндийн эрхийг хэрэгжүүлэхэд туслах эрх зүйн хөтчийн хөтөлбөр	УБ хотын Хан-Уул дүүрэг	13
ЛГБТ төв	Бэлгийн цөөнхийн бүлгийн иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн хөтчийн хөтөлбөр	Улаанбаатар хот	13
Хөөрхөн зүрхнүүд ТББ	Гэр бүлийн хүчирхийллийг даван туулагчдад эрх зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн хөтчийн хөтөлбөр	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, Архангай аймгийн Цэцэрлэг хот	48
Хил хязгааргүй алхам	Уул уурхайн боловсруулах үйлдвэрийн нөлөөнд өртөж буй нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалахад туслах эрх зүйн хөтчийн хөтөлбөр	Дорноговь аймгийн Айраг сум	6
Түгээмэл хөгжил төв	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдэд туслах эрх зүйн хөтчийн хөтөлбөр	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, Баянгол дүүрэг, Архангай, Өмнөговь аймаг	40

2019 онд олон улсын Намати байгууллагын арга зүйд үндэслэн сонгогдсон иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан эрх зүйн чадавх дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаарх хоёрдох удаагийн сургалт-семинарыг зохион байгууллаа. Сургалтад эмзэг бүлгийн эрх ашгийг

хамгаалж ажилладаг нийт 12 иргэний нийгмийн байгууллага оролцсон бөгөөд эрх зүйн арга замаар өөрсдийн үйл ажиллагааны зорилтот бүлгүүдийг чадавхжуулах гадаад болон дотоодын туршлага сургамжтай танилцсан юм.



Сургалтад оролцогч зорилтот бүлгүүдтэй ажиллах иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл, 2019 оны 7 сар



Зорилтот бүлэгтэй ажилладаг ТББ-ынханд зориулсан сургалт, 2019 оны 7 сар

Тус сургалтад оролцогчдоос нийт 4 иргэний нийгмийн байгууллагад эрх зүйн хөтчийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх төслийн тэтгэлэг олгоод байна. Түүнчлэн Хөөрхөн зүрхнүүд байгууллагын туршлагыг дахин өөр орон нутагт нэвтрүүлэх замаар

үндэсний хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийг даван туулагчдыг эрх зүйн хувьд чадавхжуулах сайн туршлага бий болгоход хувь нэмэр оруулахыг зорилоо.

№	Байгууллага	Төслийн нэр
1	Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо	ХБИ-ийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, нөхөн үржихүйн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллах эрх зүйн хөтчийн хөтөлбөр
2	Монголын эмнести интернэшнл	Орон байртай байх эрхийг хамгаалах эрх зүйн хөтчийн хөтөлбөр
3	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо	Хараагүй иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх эрх зүйн хөтчийн хөтөлбөр
4	Хүүхдийн оюуны боловсролыг дэмжих төв	Иргэний номын санд эрх зүйн боловсрол олгох нь

ННФ-аас цаашид иргэний нийгэмд суурилсан эрх зүйн мэргэшсэн хөтөч нарыг ажиллуулах, улмаар энэхүү хөтчийн үйл ажиллагааг хууль зүйн анхан шатны тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгох чиглэлд бодлогын нөлөөлөл, дэмжлэг үзүүлж ажиллах юм.

Иргэний нийгмийн байгууллагын манлайллыг дэмжихэд Төв Европын их сургуулийн Нийтийн бодлогын сургуулиас зохион байгуулдаг Иргэдийн

эрх зүйн чадавхыг дээшлүүлэх манлайллын сургалт ихээхэн дэмжлэг болдог билээ. 2019 онд Иргэний номын төслийн удирдагч Ц.Уянга, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны гүйцэтгэх захирал Д.Гэрэл, ажилтан П.Шинэчимэг нар тус сургалтад хамрагдаж олон улсын сайн туршлагатай танилцаж, харилцаа холбоо тогтоох боломжоор хангагдлаа.



Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх манлайллын олон улсын сургалтад оролцогчид Баруун гар талаас 2 дахь нь Иргэний номын сан төслийн удирдагч Ц.Уянга, 2019 оны 12 сар

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ

Хүртээмжтэй, чанартай хууль зүйн мэргэжлийн туслалцаа нь иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх тогтолцооны нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. ННФ-ын дэмжлэгтэйгээр улсын өмгөөлөгч, төвийн ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх сургалтыг 3 дахь жилдээ дэмжин зохион байгууллаа. Ингэснээр Хууль зүйн туслалцааны төвд хэргийн хөдөлгөөн, тайлан мэдээллийн нэгдсэн сүлжээг нэвтрүүлэх ажил бүрэн хэрэгжиж эхэллээ.



Хууль зүйн туслалцааны төвийн ажилтнуудад зориулсан сургалтын явц, 2019 оны 3 сар

Хууль зүйн туслалцааны тогтолцоонд хуульчдын нийтэд тустай про боно үйл ажиллагааг нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг болгох зорилтын хүрээнд Монголын хуульчдын холбоо (МХХ)-той сүүлийн жилүүдэд хамтран ажиллаж байна. 2016 оноос эхлэн Азийн про боно чуулгад монголын хуульчдын

төлөөллийг оролцуулж ирсэн нь Монгол Улсад хуульчдын про боно үйлчилгээг дэлгэрүүлэхэд хувь нэмэр болж ирсэн юм. 2019 онд МХХ-той хамтран Непал Улсад зохион байгуулагдсан Азийн про боно чуулгад төлөөлөгчид оролцоход дэмжлэг үзүүлээ.



МХХ-ны Хуульчдын нийтэд тустай үйл ажиллагаа хариуцсан хорооны гишүүд про боно хуульчдын төлөөлөл Азийн про боно хуульчдын 8-р чуулга уулзалтад оролцож буй нь 2019 оны 10 сар

Хууль зүйн мэргэжлийн туслалцааг иргэдэд үнэ төлбөргүй үзүүлэх нэгэн том суваг нь хууль зүйн сургуулиудын дэргэдэх Хууль зүйн клиник төвүүд юм. Хууль зүйн клиник сургалтыг хөгжүүлэх чиглэлээр байгуулагдсан Монголын Клиникийн нийгэмлэгтэй хамтран ННФ-ын дэмжлэгтэйгээр клиник төвийн

багш нарт практик сургалтын арга зүйн сургалтыг зохион байгуулж гэрчилгээ олголоо. Цаашид бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажилд клиник төвүүдийн оролцоо улам бүр нэмэгдэх түл энэ чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлэх нь чухал юм.

ЭНЭ СЭДВИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АРГА ХЭМЖЭЭ



Хэнтий аймгийн эрх зүйн хөтөч нарын сургалтад оролцогчид, 2019 оны 7 сар

- Иргэний нийгмийн байгууллагынханд зориулсан иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх сургалт – 2019 оны 7 сар
- Хэнтий болон Сэлэнгэ аймагт Эрх зүйн хөтчийн үйлчилгээний нээлт - 2019 оны 7 сар, 12 сар
- Хууль зүйн туслалцааны төвийн ажилтнуудад зориулсан сургалт, 2019 оны 3 сар
- Хууль зүйн клиник төвийн багш нарт зориулсан арга зүйн сургалт, 2019 оны 12 сар



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН
БОДЛОГО



ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ

Өнгөрсөн он хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах бодлого бодит утгаараа хэрэгжиж эхэлсэн онцгой жил боллоо. 2019 оны 9 дүгээр сарын 1-ээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд амьдран сууж байгаа орон нутгийнхаа ерөнхий боловсролын сургуульд элсэж, үе тэнгийнхэнтэйгээ нэг ангид мөр зэрэгцэн суралцаж эхэллээ. Ийнхүү сүүлийн 20 гаруй жилийн туршид багш, судлаач, иргэний нийгмийн идэвхтэн, хандивлагчдын чамгүй их хөдөлмөр, хамтын ажиллагаа, дэмжлэг, шахалтаар алхам алхмаар бүрдэж ирсэн тэгш хамруулан сургах боловсролын бодлогын орчин хэрэгжих шатандаа шилжив. Одоо харин энэхүү бодлогыг хэрэгжүүлэх явцад гарах олон асуулт, сорилтыг хамтдаа даван туулах дараагийн чухал үе шат түлж ирлээ.

ННФ нь 2019 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах бодлогыг сурталчлан таниулах, хэрэгжилтийг нь мэдлэг, мэдээлэл, арга зүйн чадавхаар дэмжих, орон нутгийн иргэний нийгмийн оролцоо, хяналтыг бэхжүүлэх зорилтуудын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоод, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, МУБИС, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт зэрэг түнш байгууллагуудтай хамтран ажиллав.

Тэгш хамруулах боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран бүх хүүхдийг сурч, хөгжих ижил тэгш нөхцөл боломжоор ханган, үр дүнтэй сургах үйл явц юм. Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай арга зүй эзэмшсэн багш сургадаг тул ердийн ЕБС-д сургах боломжгүй гэсэн ойлголт хандлага хэвшжээ. Улмаар ихэнх ЕБС тэгш хамруулан сургах талаар мэдээлэл, туршлагагүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг элсүүлж авахаас татгалзах, эсвэл бүх асуудлыг ганц ангийн багшид тохож орхих явдал нэн түгээмэл байгааг ННФ-аас зохион байгуулсан “Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтад оролцогчид онцолж байв. 2019 оны 1 дүгээр сард зохион байгуулсан 3 өдрийн сургалтаар Архангай, Баян-Өлгий, Дорнод, Хөвсгөл, Өмнөговь, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотын оролцогчид тэгш хамруулан сургах боловсролыг хэрэгжүүлэх явцад гарсан бэрхшээл, тэдгээрийн шалтгаан болон эрх зүйн зохицуулалтыг судлан, бусад сургуулийн туршлагыг сонсон, орон нутагтаа шийдэх шаардлагатай асуудлыг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлаа төлөвлөв. ТББ-ууд хуримтлуулсан мэдлэг, туршлагаа нэгтгэх, орон нутгийн ТББ-уудыг чадавхжуулах зорилготой энэхүү арга хэмжээг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Боловсрол дах тэгш байдал ТББ, Түгээмэл хөгжил төв, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо, Сонсголгүйн боловсрол ТББ, Монголын Аутизмын холбоо, “Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн эвсэл хамтран зохион байгуулж, лекц, хэлэлцүүлэг, сэдэвчилсэн өртөө, жүжигчилсэн даалгавраар оролцогчдод мэдээлэл хүргэв. Оролцогчид нь мөн БСШУСЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын Үнэлгээний төв зэрэг төрийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролтой холбоотой мэдээлэл сонсож, харилцаа холбоо тогтоолоо.



“Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх нь” сэдэвт 3 өдрийн сургалтын үйл явцаас, 2019 оны 1 сар.

Шинэ хичээлийн жилийн элсэлт 5 дугаар сард зарлагдсан дарууд ННФ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг элсүүлэх, сургахтай холбоотой шинэ зохицуулалтуудыг тайлбарласан зурагт хавтас хэвлүүлэн, хот, хөдөөгийн сургууль, байгууллагуудад хүргэв. Баг, хорооны Засаг дарга тухайн жилд сургуульд элсэх 6 настны жагсаалтыг эцэслэхдээ хөгжлийн бэрхшээлтэй элсэгч байх юм бол хороо, сургууль, эмнэлгийн төлөөлөгчдийг багтаасан Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл байгуулж, эцэг эхийн хамтаар хүүхдийн боловсролын хэрэгцээг тодорхойлж, сургуульд хүргүүлснээр сургууль бэлтгэлээ хангаж эхэлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчийг амжилттай сургахад шаардлагатай нэмэлт хэрэгсэл, үйлчилгээ, программ хангамжийг худалдаж авах, ханган нийлүүлэх ажлыг захирал

хариуцаж, хүүхдийг ангидаа элсүүлэн сургах багш тэдгээрийг сургалтын үйл явцад ашиглах төлөвлөгөөгөө боловсруулж, бусад багш нараас бүрдэх сургууль доторх Дэмжлэгийн баг, хүүхдийн эцэг эхтэй зөвлөлдөж эцэслэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн элсүүлж авах үйл явцыг орон нутгийн хяналт оролцоотой болгох чиг үүрэгтэй Зөвлөл, хүүхэдтэй тулж ажиллах багшийг өдөр тутмын мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангаж өгөх зорилготой Баг нь манай боловсролын салбарын хувьд цоо шинэ механизмүүд тул тус бүрийн зориулалт, бүтэц, хоорондын уялдаа холбоог уг зурагт хавтсаар тайлбарласан юм. Үүний зэрэгцээ 5-7 дугаар сард ННФ нь телевиз, мэдээний сайтын мэдээ, ярилцлага, сурвалжилга хэлбэрээр шинэ эрх зүйн орчныг сурталчлан таниулж ажиллалаа.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ НЬ: ҮҮРЭГ ХҮЛЭЭГЧ ТАЛУУД

1 Сургууль

Баг, хорооны Засаг дарга тухайн жилд сургуульд элсэх 6 настны жагсаалтыг бүртгэнэ.

Сургуулийн захирал нь хамгийн сүүлтэй тогтвортой хүүхдийг сургуульд оруулж, сургууль дахь боловсрол эхлүүлэхэд зориулж, хамрагдалтын шаардлагатай хэрэгсэл, үйлчилгээ, программ хангамжийг худалдаж авах, ханган нийлүүлэх ажлыг захирал хариуцаж, хүүхдийг ангидаа элсүүлэн сургах багш тэдгээрийг сургалтын үйл явцад ашиглах төлөвлөгөөгөө боловсруулж, бусад багш нараас бүрдэх сургууль доторх Дэмжлэгийн баг, хүүхдийн эцэг эхтэй зөвлөлдөж эцэслэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн элсүүлж авах үйл явцыг орон нутгийн хяналт оролцоотой болгох чиг үүрэгтэй Зөвлөл, хүүхэдтэй тулж ажиллах багшийг өдөр тутмын мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангаж өгөх зорилготой Баг нь манай боловсролын салбарын хувьд цоо шинэ механизмүүд тул тус бүрийн зориулалт, бүтэц, хоорондын уялдаа холбоог уг зурагт хавтсаар тайлбарласан юм. Үүний зэрэгцээ 5-7 дугаар сард ННФ нь телевиз, мэдээний сайтын мэдээ, ярилцлага, сурвалжилга хэлбэрээр шинэ эрх зүйн орчныг сурталчлан таниулж ажиллалаа.

2 Зөвлөлт зорилон байгуулах

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах боловсрол нь үн хяналар бүр эцэслэж боловсролын байгууллагад бүрэн өөрүүлэн (ХХСХХ-ийн 14.3.3).

Баг, хорооны Засаг дарга 6 настны хүүхдийг багш, сургуульд хамруулах үүрэгтэй.

Баг, хорооны Засаг дарга сургуулийн эмнэл нэгдэл хүүхдийг бүртгэж, тухайн жилд нь сургуульд оруулах арга хэлбэр эвчлэн бүрэн эргэлт (Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тухайн шараагийн тухай хуулийн 23.1.5).

Баг, хорооны Засаг дарга гэрээний гэрээнд "орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЭБС-д тэтгэн хамруулах үүрэгтэй" гэдэг үгээр хамруулах (Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тухайн шараагийн тухай хуулийн 23.1.5).

ЭБС-ийн захирал хяналт оролцоотой бүр хүүхдийг сургуульд хамруулах үүрэгтэй.

[Зөвлөл] нь хяналт оролцоотой хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, тэдэнд суури боловсрол эхлүүлэхэд зориулж (Баг, дүрч боловсролын тухай хууль, 2012.8).

3 Сургах орчин нөхцөлийг төлөвлөх

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах боловсрол нь үн хяналар бүр эцэслэж боловсролын байгууллагад бүрэн өөрүүлэн (ХХСХХ-ийн 14.3.3).

Сургуульд хамрагдалтын шаардлагатай хэрэгсэл, үйлчилгээ, программ хангамжийг худалдаж авах, ханган нийлүүлэх ажлыг захирал хариуцаж, хүүхдийг ангидаа элсүүлэн сургах багш тэдгээрийг сургалтын үйл явцад ашиглах төлөвлөгөөгөө боловсруулж, бусад багш нараас бүрдэх сургууль доторх Дэмжлэгийн баг, хүүхдийн эцэг эхтэй зөвлөлдөж эцэслэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн элсүүлж авах үйл явцыг орон нутгийн хяналт оролцоотой болгох чиг үүрэгтэй Зөвлөл, хүүхэдтэй тулж ажиллах багшийг өдөр тутмын мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангаж өгөх зорилготой Баг нь манай боловсролын салбарын хувьд цоо шинэ механизмүүд тул тус бүрийн зориулалт, бүтэц, хоорондын уялдаа холбоог уг зурагт хавтсаар тайлбарласан юм. Үүний зэрэгцээ 5-7 дугаар сард ННФ нь телевиз, мэдээний сайтын мэдээ, ярилцлага, сурвалжилга хэлбэрээр шинэ эрх зүйн орчныг сурталчлан таниулж ажиллалаа.

4 Зөвлөлтэй баталгаажуулах

Сургахтай хүүхдийг сургах багш, багийн захирал хяналт оролцоотой хамрагдалтын шаардлагатай хэрэгсэл, үйлчилгээ, программ хангамжийг худалдаж авах, ханган нийлүүлэх ажлыг захирал хариуцаж, хүүхдийг ангидаа элсүүлэн сургах багш тэдгээрийг сургалтын үйл явцад ашиглах төлөвлөгөөгөө боловсруулж, бусад багш нараас бүрдэх сургууль доторх Дэмжлэгийн баг, хүүхдийн эцэг эхтэй зөвлөлдөж эцэслэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн элсүүлж авах үйл явцыг орон нутгийн хяналт оролцоотой болгох чиг үүрэгтэй Зөвлөл, хүүхэдтэй тулж ажиллах багшийг өдөр тутмын мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангаж өгөх зорилготой Баг нь манай боловсролын салбарын хувьд цоо шинэ механизмүүд тул тус бүрийн зориулалт, бүтэц, хоорондын уялдаа холбоог уг зурагт хавтсаар тайлбарласан юм. Үүний зэрэгцээ 5-7 дугаар сард ННФ нь телевиз, мэдээний сайтын мэдээ, ярилцлага, сурвалжилга хэлбэрээр шинэ эрх зүйн орчныг сурталчлан таниулж ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах бодлогын хэрэгжилтэд зориулан гаргасан мэдээллийн багц

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо нь 2019 оны 5 дугаар сарын туршид олон нийтийн боловсролын кампанит ажил хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, сайн дурынхныг сургах, видео болон хэвлэмэл материал боловсруулж гаргах, олон нийтийн сүлжээгээр мэдээлэл өгч ажиллаад, 'Хаалгаа нээ' арга хэмжээгээр кампанит ажлаа өндөрлөв. Арга хэмжээний үеэр зөвлөх эцэг эхүүд элсэлтийн журам, хүүхдийн боловсролын хэрэгцээг

тодорхойлох арга зүйг тайлбарлан зөвлөгөө өгч, асуудал хариуцсан төрийн албан хаагчид мэдээлэл хийн, салбарын мэргэжилтнүүд туршлагаасаа хуваалцаж, хөгжлийн бэрхшээлтэй залуучууд амьдралын түүхээ ярьж, хийсэн видеоогоо үзүүлжээ. ННФ нь зарим зөвлөгөө өгч, байгууллагын зардлыг санхүүжүүлэв. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо нь жил бүр орон даяар ийм кампанит ажил хийж байхаар төлөвлөж байна.



"Хаалгаа нээ" арга хэмжээнд оролцогч, уг арга хэмжээний үеэр ажилласан сайн дурын ажилтнууд, 2019 оны 5 сар.

Тэгш хамруулах боловсролын эхний жилийн хэрэгжилтэд ННФ-ын арга зүй, санхүүгийн дэмжлэгтэйгээр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Түгээмэл хөгжил төв зэрэг төрийн бус байгууллагууд 2019 оны 10-11 дүгээр сард ажиглалт мониторинг хийв. Нийслэлийн Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Налайх дүүргүүд, Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Орхон, Булган аймгууд хамрагдсан уг судалгаагаар баг/хорооны Засаг дарга нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлаар оролцоо сул, гарсан журам, тушаалтай танилцаагүй, хэрэгжүүлээгүй өнгөрсөн бол сургуулиуд хэрэгжүүлэхийг хичээж байгаа ч үр дүнтэй ажиллаж чадахгүй байгааг илрүүлжээ.

Албан бичгээр явуулсан асуулгад хариулсан 17 баг, хорооноос 15 нь Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл байгуулаагүй өнгөрчээ. 18 сургуулиас 9 нь батлагдсан аргачлалын дагуу Дэмжлэгийн багаа байгуулж, Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулсан ч нарийвчилсан удирдамж, зааварчилгаа байхгүй тул тогтмол ажиллуулахгүй байгаа бол 7 нь огт хэрэгжүүлээгүй дүн гарлаа (1 нь хариулаагүй). Нийслэлийн нэгэн лаборатори сургууль "хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд элсүүлдэггүй" гэж хариулжээ. Хөвсгөл аймгийн сургуулиуд тэгш хамруулах боловсролын шинэ механизмуудыг амжилттай хэрэгжүүлэх туршлагатай болж байгаа нь хандивлагч



“Хаалгаа нээ” арга хэмжээнд оролцогчид уг арга хэмжээний үеэр ярилцлага, нийтлэл бэлтгэж буй нь, 2019 оны 5 сар.

байгууллагууд (ЖАЙКА, ЮНИСЕФ)-ын төслийн үр дүн ажээ. БСШУСЯ нь элсэлтийг зохион байгуулах нарийвчилсан удирдамж гаргаж хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, хичээлийн жилийн туршид багшид дэмжлэг үзүүлэх механизмуудыг аргачлал, мэдлэгээр хангахад анхаарах шаардлагатай гэж мониторингийн баг зөвлөж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах асуудлаар мэдээлэл, дэмжлэг хүсэж иргэний нийгмийн байгууллагуудад хандах явдал нэмэгдэх төлөв ажиглагдав. Бодлогын хэрэгжилтийг дэмжих энэхүү боломжийг үр дүнтэй ашиглахад иргэний нийгмийн байгууллагууд хариуцлагатай хандаж, техникийн мэдлэг, мэргэжлийн туршлага хуримтлуулах шаардлагатай болж байна. ННФ, Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээ зөвлөлдөн, тодорхой асуудлаар дотоод чадавхаа хөгжүүлэх гишүүн байгууллагуудын санаачилгыг дэмжих стратегийг боловсруулав. Уг стратегийн хүрээнд 3 байгууллагад хүртээмжтэй орчин, тохирох хэрэглэгдэхүүний асуудлаар төвлөрч ажиллах, өөр 3 байгууллагад олон нийтийн боловсролын кампанит ажил хэрэгжүүлэхэд ННФ-аас дэмжлэг үзүүллээ. Сонсголгүйн боловсрол ТББ нь унших

бичгийн үгийн санг дохиожуулан видео цуврал хийх явцдаа сонсголгүй хүүхдийг боловсролд тэгш хамруулах талаар олон улсын туршлага, сонсголгүй хүүхдийн үгийн санг баяжуулах асуудлаар судалгаа хийв. Хараагүйчүүдийн үндэсний холбоо нь Монгол брайль үсгийн стандартыг боловсруулахын зэрэгцээ хараагүй хүүхдийг тэгш хамруулахад багш, сургуулийн зүгээс анхаарах ёстой асуудлуудаар арга зүйн зөвлөмж боловсруулав. Түгээмэл хөгжил төв нь тархины саажилттай хүүхдийг тэгш хамруулан сургаж байгаа багшид тус болох мэдээлэл бүхий гарын авлага бэлтгэв. Эдгээр байгууллага нь бий болгосон мэдлэгээ салбарын удирдлага, багш нартай хуваалцахын зэрэгцээ цаашид улам гүнзгийрүүлэн, сургалтын үйл явц дахь тохирох хэрэглэгдэхүүнийг ашиглах ойлголттой болгож бэхжүүлэхээр ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд, тэдний эцэг эхийн яриагаар 5 хэсэг контент хийж олон нийтийн сүлжээгээр түгээсэн бөгөөд агуулгаа төлөвлөх, санаагаа хүргэж ярих арга зүйг боловсруулах, давтах, зураг авах зэрэг хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлтэй сайн дурын залуус хамтран ажилласан байна. Монголын Аутизмын холбоо нь урлаг соёлын алдартнууд цагаа

хандивласан сайн дурын санаачилгыг харуулсан 2 хэсэг видео материал бэлтгэн олон нийтэд хүргэв.

Иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхийн зэрэгцээ хувь хүмүүсийн чадавхыг хөгжүүлэхэд анхаарч эхэллээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, тэгш хамруулах боловсролын асуудлаар бодлогын судалгаа, шинжилгээний 2 хоногийн үйл ажиллагааг Монголын нууц товчоо амралтын газарт зохион байгуулж, Я.Авирмэд (Түгээмэл хөгжил төв), Р.Будханд (Боловсрол дах тэгш байдал ТББ), Ц. Оюунбаатар (Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо), Д.Батцэцэг (Монголын Дауны холбоо), Г.Баянзул (“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн эвсэл) зэрэг экспертүүд мэдлэг мэдээлэл солилцож, багаар эрх зүйн орчны судалгааг гүйцэтгэв. Улмаар багаа бэхжүүлэн, Д.Гэрэл (Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо), Д.Эрдэнэчимэг (Сонсголгүйн боловсрол ТББ), С.Сэлэнгэ (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо), Б. Чулуундолгор (Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо) нартай хамтран, цуврал хэлэлцүүлэг зохион байгууллаа. Энэхүү ажлын үр дүнд нэн шаардлагатай болоод байсан “Тохирох хэрэглэгдэхүүний журам”-ын төслийг боловсруулж, БСШУСЯ-нд хүлээлгэж өгсөн бөгөөд багийн гишүүд тэгш хамруулах боловсролын асуудлуудаар сургалт хийх, бодлогын зөвлөгөө өгөх бэлтгэлээ хангав. Иргэний нийгмийн идэвх зүтгэлийн зэрэгцээ тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлэх хүний нөөцийг системтэйгээр хөгжүүлэхэд хамтран ажиллах шинэ түнш байгууллагатай болов. МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн Тэгш хамруулах боловсрол, Тусгай хэрэгцээт боловсрол, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын тохируулга зэрэг чиглэлээр бакалавр, магистрын хөтөлбөрөө шинэчлэх санаачилгыг дэмжиж ННФ нь 2 жилийн хугацаатай төслийн тэтгэлэг олгов. Уг төсөл нь 2018 оноос МУБИС-ийн Боловсролын хөгжлийг дэмжих төвөөс МУБИС-ийн дидактикийн багш

нарын багаар дамжуулан хэрэгжүүлж буй сурах ялгаатай хэрэгцээг харгалзан хичээл сургалтаа төлөвлөх арга зүй боловсруулан сургалтад нэвтрүүлэх төсөлтэй зэрэг хэрэгжих юм.

Тэрчлэн ННФ сургалтын агуулга, хөтөлбөрийн шинэчлэлийн үр дүнг хүлээлгүй багш, сургуулиудад өнөөдөр шаардлагатай байгаа агуулга, арга зүйн мэдээллийг хүргэх зорилгоор Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ)-тэй хамтран ажиллаж эхэллээ. ЖАЙКА, ЮНИСЕФ зэрэг олон улсын байгууллагын тэгш хамруулах боловсролын төслүүдийг хэрэгжүүлэн, арга зүйн арвин туршлага хуримтлуулсан уг байгууллага нь 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж байгаа бүх багшийг сургалтад хамруулахын зэрэгцээ захиалгаар сургууль, орон нутгуудад сургалт хийх боломжтой багшийн мэргэжил дээшлүүлэх бүтэц юм. БМДИ нь тэгш хамруулах боловсролын үзэл баримтлал, төсөл, хөтөлбөрийн хүрээнд бий болсон сайн туршлага, тусгай сургуулийн багш нарын ашигладаг аргууд зэрэг агуулгаар цахим болон танхимын сургалтын агуулга боловсруулж, багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хүргэх 1 жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлж байна.

2019 онд бид боловсролын бодлогын хэрэгжилтийг хянах засаг захиргааны механизмыг ашиглах ажлыг туршиж үзэв. ННФ-ын тэтгэлгээр “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн эвсэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлаар 7 аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-тай хамтран нийтийн сонсгол зохион байгуулсан юм. Энэхүү арга хэмжээний үр дүнд тэгш хамруулах боловсролыг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах зорилтууд орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд туссан ч хэрэгждэггүй, мөн чанарыг нь ойлгохгүй тунхаг шинжтэй тусгаж байх магадлал ажиглагдахын зэрэгцээ мөн нийтийн сонсгол хийх туршлага байхгүй байгаа нь тодорхой харагдсан байна.



ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

НФ нь өсвөр насны хүүхэд, залуучуудын дундах үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чиглэлд бодлого боловсруулагчдын анхаарлыг татаж, үндэсний хэмжээнд урьдчилан сэргийлэх хөтөлбөр, арга хэмжээ системтэйгээр төлөвлөн хэрэгжүүлдэг болох зорилт дэвшүүлэн уг хөтөлбөрийг 2014 оноос хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд төрийн мэдлийн 4 их сургуулийн нийгмийн ажилтан, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, цагдаагийн ажилтан бэлтгэх хөтөлбөрт залуучуудын дундах дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх агуулга нэвтрүүлэх ажлыг дэмжиж ажиллав. Бакалавр, магистрын хөтөлбөр, оюутны дадлагын болон эрдэм шинжилгээний ажил, багш нарын судалгааны ажил, салбарын боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт үе тэнгийнхний хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хичээл, сэдвийг тусгаж, хэрэгжүүлэх ажлыг Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль (АШУҮИС)-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль (ШУТИС)-ийн Нийгмийн ажлын тэнхим, Монгол Улсын Багшийн Их Сургууль (МУБИС)-ийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхим, Дотоод хэргийн их сургууль (ДХИС)-ийн 30 гаруй судлаач багш нэр хэрэгжүүлж байна.

Бид 2019 онд 4 их сургуулийн хөтөлбөр шинэчлэлийн ажлыг үнэлэх, гарсан үр дүнг бэхжүүлж тогтворжуулахад анхаарч ажиллав. 2014 онд гадаад хэл дээрх эх сурвалж, гадаадын их сургуулийн хөтөлбөрийг жишиг болгон ашиглаж, хөтөлбөр шинэчлэлийн ажлыг эхлүүлж байсан бол одоо мэргэжилтнүүдийн дунд үе тэнгийн хүчирхийллийн тухай ойлголт төлөвшиж, 2016 оноос гарч байгаа хүүхэд хамгааллын эрх зүйн орчны өөрчлөлтийг дагаад урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох эхний алхмууд хийгдэж байна. 2018 оноос Монгол Улс хүүхдийн эсрэг хүчирхийллийг урьдчилан сэргийлэх олон улсын INSPIRE аргачлалыг нэвтрүүлэхээр судалж байна. Эдгээр өөрчлөлтийг сургалтын хөтөлбөртөө тусгаж байгаа туршлагаа солилцох, хэрэгжүүлж байгаа сургалтын хөтөлбөрөө харьцуулж бие биеэсээ суралцах, хөтөлбөрөө ахин шинэчлэхэд ННФ-аас дэмжлэг үзүүлж байна. Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль (НЭМС), ШУТИС-ийн удирдаж байгаа уг төслийн баг нь 4 их сургуулийн сургалтын хөтөлбөрийг үнэлэх, харьцуулах, сайжруулахад зөвлөн туслахын зэрэгцээ цаашид хүүхэд хамгааллын тогтолцооны үндсэн аргачлал болж ашиглагдах INSPIRE стратегийг дээрх их сургуулиудын сургалтын хөтөлбөрт системтэйгээр нэвтрүүлэх юм. Ингэхдээ INSPIRE стратегийн түшиц АНУ-ын Колумбын их сургуулийн Нийгмийн ажлын сургуультай түншлэх ажлыг удирдаж байгаа бөгөөд төслийг сургууль дамнасан багуудаар, тогтмол уулзалт хэлэлцүүлэг зохиох арга хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Дашрамд дурдахад, ННФ нь INSPIRE арга стратегийг хүүхэд хамгааллын салбарын судлаач, их дээд сургуулийн багш нарт танилцуулах 2 удаагийн семинар зохион байгуулсан бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-аас орчуулан гаргахаар бэлтгэж байгаа гарын авлагын эхийг хянах, хэвлэх, тараан түгээхэд оролцох төлөвлөгөөтэй байна.

2019 онд иргэний нийгмийн байгууллагууд үе тэнгийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх ажилд мэргэжлийн мэдлэг, үр чадвараа нэмэрлэж бидний ажлыг дэмжсэн юм. Сэтгэл судлалын үндэсний төв ТББ нь хүүхэд, залуучуудад сэтгэл зүйн яаралтай үйлчилгээг хүргэдэг Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний чанарыг сайжруулах төсөл хэрэгжүүлсэн нь маш үр дүнтэй болов. 2014 онд эхэлсэн Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээ нь 24 цагаар 4-6 шугамаар нэгэн зэрэг дүүдлага хүлээн авч, сэтгэл зүйн яаралтай туслалцаа үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх зорилготой юм. Сэтгэл судлалын үндэсний төв нь 108 утасны үйлчилгээнд мониторинг хийж, ажлын байрны нөхцөлийг сайжруулах, ажлын ачааллыг оновчтой хуваарилахтай холбоотой зөвлөмжийг удирдлагуудад нь танилцуулжээ. Төслийн 2 дугаар шатанд 108 утасны зөвлөхүүдийн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх мэргэжлийн үр чадварыг хөгжүүлэх сургалт хэрэгжүүлсэн нь маш хэрэгцээтэй, нэн шаардлагатай арга хэмжээ болжээ. Сэтгэл судлалын үндэсний төв нь сургалтад ашигласан материалыг гарын авлага болгон тараагаад, 108 утасны зөвлөх болохоор шинээр ажилд орж байгаа болон одоо ажиллаж байгаа хүмүүст ажлын байранд мэргэжлийн үр чадварыг нь хөгжүүлэх сургалт заавал хийж байхыг нухацтай зөвлөж байна. Сэтгэл судлалын үндэсний төвийн залуучууд мөн хүүхэд залуучуудад утсаар сэтгэл зүйн зөвлөгөө өгөх асуудлаар судалгааны материалдаа түшиглэн тайлан гаргав.

Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ (БХАН) нь ННФ-тай хамтран үе тэнгийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургуульд суурилсан тогтолцоог бий болгохоор 2016 оноос хойш тууштай ажиллаж байна. 2018 онд ахлах ангийн сурагчдад хичээлийн бус хөтөлбөрөөр хүчирхийллээс зайлсхийх амьдрах ухааны мэдлэг, чадвар эзэмшүүлэх төсөл хэрэгжүүлсэн туршлагадаа тулгуурлан БХАН 2019 онд аргаа

өөрчлөн, нийгмийн ухааны хичээлд хүчирхийллийг урьдчилан сэргийлэх агуулгыг интеграцчилах төсөл хэрэгжүүлж байна. ЕБС-ийн агуулга нягт, сурагч, багш нарын ачаалал өндөр, багшид нэмэлт ажлын хөлс тооцохгүй, анги танхимын олдоц ялангуяа нийслэл, аймгийн төвийн сургуулиудад муу байгаа нөхцөлд хичээлийн бус хөтөлбөр хэрэгжүүлэх боломжгүй. Иймээс агуулгын интеграцчилал хийж, хичээл төлөвлөлтийг боловсруулан бэлэн материал болгож, арга зүйн гарын авлагын хамт багш нар

хүргэхээр БХАН ажиллаж байна. ННФ-ын арга зүй, санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй уг төслөөр БХАН нь 1-9 дүгээр ангийн Монгол хэл, Иргэний ёс зүй, Нийгэм судлал хичээлийн хөтөлбөрүүд, сурах бичигт анализ хийж дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх мэдлэг, чадварыг сурагчдын нас сэтгэхүйн онцлог, хичээлийн зорилго, сурах бичгийн сэдэвт нийцүүлэн интеграцчилах судалгааг хийж гүйцэтгээд байгаа ба 2020 онд ЕБС-ийн багш нартай хамтран агуулгаа боловсруулан, турших юм.



БХАН-ээс хэрэгжүүлж байгаа төслийн сургалтын үеэрх багийн ажиллагаа ба сургалтад оролцож байгаа ЕБС-ийн багш нар



Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээ

2019 онд ННФ нь бүтээлч залуучуудтай шинэ асуудал, шинэ арга барилаар хамтран ажилласан нь бидний ажилд урам зориг өгөхийн зэрэгцээ цаашид барьж ажиллах сонирхолтой чиглэлийг тодотгов. Баяр мэдээллийн боловсрол ТББ нь ННФ-ын тэтгэлгээр мэдээллийн суурь боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, иргэний нийгмийнхэнд цуврал сургалтаар хүргэж туршлаа. Тэд уламжлалт болон нийгмийн сүлжээний талаарх мэдээллийн үндсэн ойлголт өгөх, хуурамч мэдээг ялгах, үзэн ядах хэллэгийг хянан зохицуулах сэдвийг тусгасан уг хөтөлбөрийг ахлах ангийн сурагчдад хүргэхээр төлөвлөж байгаа юм.

ННФ нь “Нүүдлийн зурган өгүүлэмж ТББ-тай хамтран 2020 онд үе тэнгийн дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх сэдвээр комикс цуврал комикс гаргахаар бэлтгэлээ хангаж байна. Нүүдлийн зурган өгүүлэмж ТББ-ын “Хандгай” төсөл нь 2018 онд анх гарч эхэлснээс хойш нэг жилийн дотор фэйсбүүкт 58,000 орчим, инстаграмд 12,000 гаруй дагагчтай болсон бөгөөд тэд бараг бүгд 15-25 насны залуучууд байгаа юм. ННФ-ын тэтгэлгээр комикс бүтээгч уран бүтээлч залуучууд нь үе тэнгийн хүчирхийлэл, түүний сэтгэл зүйн шалтгаан, залуус харилцаандаа сайн сайхныг сонгож, хүчирхийллээс ухамсартайгаар татгалзах асуудалд төвлөрч ажиллах юм.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2019 онд нийт 1,839,700 ам.долларын төсөвтэй ажилласан ба үүнээс \$ 1,776,000 Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Соросын сангийн сүлжээний хөтөлбөрүүд, \$52,400 IDEA; \$11,300 бусад донор байгууллагаас санхүүжигдсэн болно. Төсвийн зарцуулалтыг дор хүснэгтээр харуулав.

НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ			
Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх нь	88,318	84,175	172,493
Сонгуулийн үйл явц, улс төрийн санхүүжилтийг боловсронгуй болгох нь	37,201	95,709	132,910
Төсвийн хариуцлагыг сайжруулах	45,609	85,459	131,068
Эрдэс баялгийн салбарын сайн засаглалыг дэмжих	48,782	116,807	165,589
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ			
Хүний эрх	-	70,311	70,311
Эрүүгийн эрх зүйн шинэчлэл	48,516	108,323	156,839
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	97,978	56,302	154,280
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь	90,165	47,888	138,053
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО			
Тэгш хамруулах боловсрол	61,807	28,420	90,227
Залуучуудын дундах үе тэнгийн хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх нь	57,221	32,909	90,130
ЗАХИРГАА	-	392,592	392,592
		-	-
НИЙТ ДҮН	575,597	1,118,895	1,694,492

НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт тэтгэлгийн зардал
АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ			
Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх нь	86,632	1,686	88,318
Сонгуулийн үйл явц, улс төрийн санхүүжилтийг боловсронгүй болгох нь	27,551	9,650	37,201
Төсвийн хариуцлагыг сайжруулах	45,609	-	45,609
Эрдэс баялгийн салбарын сайн засаглалыг дэмжих	45,437	3,345	48,782
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ			
Хүний эрх	-	-	-
Эрүүгийн эрх зүйн шинэчлэл	30,017	18,499	48,516
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	94,430	3,548	97,978
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь	74,690	15,475	90,165
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО			
Тэгш хамруулах боловсрол	61,807	-	61,807
Залуучуудын дундах үе тэнгийн хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх нь	57,221	-	57,221
НИЙТ ДҮН	523,394	52,203	575,597

2019 ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ

\$ доллар

Д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, хувь хүн	Төрөл		Тэтгэлгийн дүн
1	Улаанбаатар	Хөөрхөн зүрхнүүдийн аян	ТББ	\$	11,566
2	Улаанбаатар	А.Дэмбэрэл	Иргэн	\$	366
3	Улаанбаатар	Монголын криминологичдын холбоо	ТББ	\$	2,286
4	Улаанбаатар	Оюуны-Инноваци	ТББ	\$	36,597
5	Улаанбаатар	Б.Баярмаа	Иргэн	\$	2,117
6	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	ТББ	\$	14,727
7	Улаанбаатар	Амьдрах орчны зураглалын төв	ТББ	\$	10,555
8	Улаанбаатар	Т.Саруул	Иргэн	\$	1,686
9	Улаанбаатар	Зөв хөгжил үр дүнт оролцоо	ТББ	\$	1,741
10	Орхон	Төр иргэн түншлэл	ТББ	\$	1,411
11	Төв	Өнө мөнхийн эгшиглэн	ТББ	\$	1,755
12	Улаанбаатар	Орон нутгийн хөгжлийн бодлого судлалын төв	ТББ	\$	3,563
13	Улаанбаатар	Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн	ТББ	\$	1,791
14	Орхон	Орхон 21-р зуун	ТББ	\$	1,402
15	Улаанбаатар	Тунгаамал төв	ТББ	\$	932
16	Улаанбаатар	Байгаль орчны төлөөх хуульчдын холбоо	ТББ	\$	2,760
17	Улаанбаатар	Эрх зүйн соёл	ТББ	\$	1,727
18	Дархан-Уул	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	ТББ	\$	890
19	Улаанбаатар	Б.Мөнхсайхан	Иргэн	\$	7,445
20	Улаанбаатар	Э.Цэнгүүн	Иргэн	\$	11,054
21	Архангай	Архангай бие даан амьдрах төв	ТББ	\$	2,344
22	Багануур	Залуус манлайлал	ТББ	\$	1,934
23	Баянхонгор	Амартайван итгэл	ТББ	\$	3,128
24	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$	3,043
25	Булган	Булганы өнгө	ТББ	\$	2,275
26	Дархан-Уул	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	\$	2,689

Д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, хувь хүн	Төрөл		Тэтгэлгийн дүн
27	Дорнод	Буйр нуур, Халхгол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн	ТББ	\$	1,795
28	Өвөрхангай	Орон нутгийн санаачилга	ТББ	\$	1,344
29	Ховд	Ховдын толь сонин	ТББ	\$	5,762
30	Өвөрхангай	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	\$	2,543
31	Завхан	Өрнөх хөгжил	ТББ	\$	2,799
32	Улаанбаатар	Сэтгэл судлалын үндэсний төв	ТББ	\$	2,912
33	Дундговь	Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ	ТББ	\$	1,796
34	Төв	Ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$	1,573
35	Улаанбаатар	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	\$	1,704
36	Улаанбаатар	Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо	ТББ	\$	380
37	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$	4,470
38	Улаанбаатар	Анлимитед медиа групп	ХХК	\$	1,133
39	Увс	Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл	ТББ	\$	3,526
40	Дорнод	Буйр нуур, Халхгол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн	ТББ	\$	1,796
41	Улаанбаатар	Бүх нийт боловсролын төлөө	ТББ	\$	11,094
42	Баянхонгор	Баянхонгор аймгийн ИТХ	Төрийн байгууллага	\$	1,456
43	Булган	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	\$	753
44	Хөвсгөл	Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо	ТББ	\$	1,487
45	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$	1,493
46	Өвөрхангай	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	\$	1,306
47	Улаанбаатар	Хууль зүйн мэдээлэл судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэг	ТББ	\$	3,012
48	Улаанбаатар	Б.Хонгорзул	Иргэн	\$	2,194
49	Улаанбаатар	Монголын криминологичдын холбоо	ТББ	\$	9,759
50	Улаанбаатар	С.Сүхчүлүүн	Иргэн	\$	1,355

Д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, хувь хүн	Төрөл		Тэтгэлгийн дүн
51	Баянхонгор	Амьд хууль	ТББ	\$	2,307
52	Баянхонгор	Хонгор нутгийн дуудлага	ТББ	\$	2,336
53	Улаанбаатар	Их бага баяншарга сан	ТББ	\$	5,710
54	Говьсүмбэр	Хотол чойр	ТББ	\$	3,733
55	Улаанбаатар	Шинэ суурьшил эрүүл аюулгүй орчин	ТББ	\$	1,798
56	Улаанбаатар	Жавхлант гэрэлт ирээдүй	ТББ	\$	3,012
57	Улаанбаатар	Эх орон хамтын хүч	ТББ	\$	3,333
58	Улаанбаатар	Цагаан шорооны хор хөнөөлөөс ирээдүйгээ аврах хөдөлгөөн	ТББ	\$	4,830
59	Улаанбаатар	Хил хязгааргүй алхам	ТББ	\$	24,499
60	Улаанбаатар	Глоб интернэшнл төв	ТББ	\$	7,335
61	Төв	Ш.Энхтайван	Иргэн	\$	1,228
62	Улаанбаатар	Т.Уранболор	Иргэн	\$	2,528
63	Улаанбаатар	Монголын хуульчдын холбоо	ТББ	\$	6,431
64	Улаанбаатар	Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо	ТББ	\$	7,931
65	Улаанбаатар	Монголын эмнести интернэшнл	ТББ	\$	19,486
66	Улаанбаатар	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо	ТББ	\$	17,841
67	Улаанбаатар	Хүүхдийн оюуны боловсролыг дэмжих төв	ТББ	\$	12,573
68	Улаанбаатар	Д.Гэрэл	Иргэн	\$	4,724
69	Улаанбаатар	П.Шинэчимэг	Иргэн	\$	1,372
70	Улаанбаатар	Ц.Уянга	Иргэн	\$	4,412
71	Улаанбаатар	Бусад	Иргэн	\$	2,073
72	Улаанбаатар	Б.Золбоо	Иргэн	\$	1,930
73	Улаанбаатар	А.Солонго	Иргэн	\$	1,930
74	Улаанбаатар	Б.Бүндхорол	Иргэн	\$	1,930
75	Улаанбаатар	Ж.Идэрсайхан	Иргэн	\$	1,930
76	Улаанбаатар	С.Энхбаатар	Иргэн	\$	1,930
77	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$	27,322
78	Улаанбаатар	Хууль зүйн үндэсний хүрээлэн	ТББ	\$	19,618

Д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, хувь хүн	Төрөл	Тэтгэлгийн дүн
79	Улаанбаатар	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг	ТББ	\$ 13,455
80	Хэнтий	Хэнтий аймгийн ЗДТГ	Төрийн байгууллага	\$ 18,537
81	Сэлэнгэ	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	Төрийн байгууллага	\$ 18,537
82	Улаанбаатар	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль	Төрийн байгууллага	\$ 32,767
83	Улаанбаатар	Нүүдлийн зурган өгүүлэмж	ТББ	\$ 8,087
84	Дорнод	Буйр нуур, Халхгол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн	ТББ	\$ 7,341
85	Улаанбаатар	Амьдрах орчны зураглалын төв	ТББ	\$ 15,060
86	Улаанбаатар	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт	Төрийн байгууллага	\$ 9,713
87	Улаанбаатар	Ил тод байдал сан	ТББ	\$ 5,490
88	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачилга	ТББ	\$ 7,356
89	Улаанбаатар	Монгол Улсын Боловсролын Их Сургууль	Төрийн байгууллага	\$ 41,000
90	Завхан	Завхан аймгийн ИТХ	Төрийн байгууллага	\$ 2,946
ДҮН				\$ 575,597

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, АЖИЛТНУУД

Нээлттэй Нийгэм Форумын Удирдах Зөвлөлийн гишүүд

Г. Уранцоож	УЗ-ийн дарга, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн
Ж. Үнэнбат	УЗ-ийн гишүүн, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын гүйцэтгэх захирал
Ч. Хашчулуун	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ЭЗС-ийн багш (2019 оны 4 сар хүртэл)
Ч. Лодойравсал	УЗ-ийн гишүүн, МУИС-ын Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан Дэд захирал
О. Энхтуяа	УЗ-ийн гишүүн, Дэ Нэйчэр консерванси ТББ-ын захирал (2019 оны 4 сар хүртэл)
П. Наранбаяр	УЗ-ийн гишүүн, Шинэ Монгол дунд сургуулийн захирал
О. Мөнхсайхан	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ХЗС-ийн багш
Ч. Болортуяа	УЗ-ийн гишүүн, ikon.mn Ерөнхий редактор
Д. Энхжаргал	УЗ-ийн гишүүн, МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээний Ерөнхий зохицуулагч

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

П. Эрдэнэжаргал

Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд

П. Бадамрагчаа	Эрх зүйн хөтөлбөрийн менежер
А. Гэрэлмаа	Боловсрол, Нийгмийн бодлогын хөтөлбөрийн менежер
Д. Оюунбадам	Засаглалын хөтөлбөрийн менежер
Б. Хишигсайхан	Эрх зүйн хөтөлбөрийн менежер
Д. Энхцэцэг	Засаглалын хөтөлбөрийн менежер
Д. Эрдэнэчимэг	Засаглалын хөтөлбөрийн менежер
О. Сэлэнгэ	Хөтөлбөрийн туслах ажилтан
Б. Ундармаа	Хөтөлбөрийн туслах ажилтан
Б. Үүрийнтуяа	Хөтөлбөрийн туслах ажилтан
Д. Балжид	Мэдээллийн менежер
Б. Мөнхгэрэл	Мэдээллийн ажилтан
Д. Жавхлан	Санхүүгийн захирал
Ж.Алтанчимэг	Нягтлан бодогч
В. Халиунцэцэг	Нягтлан бодогч
Б. Лхагвацэрэн	Тэтгэлгийн менежер
Э. Сайнтүвшин	Мэдээлэл сүлжээний зохицуулагч
Б. Амгалан	Захиргааны ажилтан
Б. Баатар	Захиргааны туслах ажилтан
Г. Цэдэвхүү	Захиргааны туслах ажилтан
Б.Бат-Эвлэл	Захиргааны туслах ажилтан

Нийтлэг И-мэйл: osf@forum.mn